номын сан

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

3

- Казиногийн тухай Монгол Улсын хууль
- Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хууль
- Садар самуун явдалтай тэмцэх тухай Монгол Улсын хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай Монгол Улсын хууль

ЭНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
1998 ОН

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын хэвлэл

1998 оны 3-р сар №3 /70/

ГАРЧИГ

## 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


дзвногийн тухай 261
ншгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай 270
ж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын
уульд нэмэлт оруулах тухай 271
рүүгийн хуульд нэмэлт оруулах тухай 272
үйлдэх ажлын тухай 272
рүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай 283
адар самуун явдалтай тэмцэх тухай 284
рүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай 288
айгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 289
айгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
руулах тухай 297
рхидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
руулах тухай 298
рүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай 299
охиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 300
эрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай 300
нштой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 301


## 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


уулийн төсөл буцаах тухай №8 302
лын хэсэг байгуулах тухай №9 302
эрийн хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай №10 303
. Батмөнх агсны ар гэрийн ахуй хангамжийн тухай №11 304
огтоолын төсөл буцаах тухай №12 305
өрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн
бан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын
рэгэлзлийг тогтоох тухай" тогтоолд нэмэлт оруулах тухай №13 306

22. "Төрийн захиргааны албан тушаалын тэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" тогтоолд нэмэлт оруулах тухай №14
23. Хуулийн төсөл буцаах тухай №15
24. Үндэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлөх тухай №16
25. Үнэт цаасны хорооны гишүүнээр томилох тухай №17
26. Ерөнхийлөгчийн хоригийн тухай №19
27. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №20
28. Казиногийн тухай болон Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №21
29. Ю. Цэдэнбал агсны гэр бүлийн ахуй хангамжийн тухай №22
30. Тогтоолын төсөл буцаах тухай №23
31. 1998 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай №24

## 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

32. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай №06

## 4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

33. Банкны тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай №01

## 5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

34. Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай №12
35. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай №13
36. Журам батлах тухай №14
37. Журам батлах тухай №15
38. Тогтоолуудын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай №18
39. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай №19
40. Журам батлах тухай №21
41. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай №23

## 6. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

42. Дээд Шүүхийн 1993 оны 49-р тогтоолд өөрчлөлт оруулах тухай №427
43. Иргэний хуулийн өмчийн эрх зүйн хэсгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай №442
44. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаарх иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай №473
45. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай №524

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ны 1 дүгээр
15-ны өдөр

Улаанбаатар
хот

## КАЗИНОГИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**үгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь казино байгуулах, зөвшөөрөл олгох, бүртгэх, уулах, үйл ажиллагааг нь зогсоох, хяналт тавих үйл ажиллагаатай лсон харилцааг зохицуулахад оршино.

**угаар зүйл. Хуулийн нэр томъёо**

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ю:

1. "казино" гэж үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй аз н тоглоом тоглуулдаг зориулалтын өрөө, танхим бүхий газрыг;
2. "казинотой холбогдох тоног төхөөрөмж" гэж аз туршсан тоглоом лах зориулалтын тоног төхөөрөмж буюу машин, техник хэрэгслийг;
3. "слот машин" гэж мөнгө буюу түүнийг орлогч токенс хэрэглэн ог электрон хэрэгсэл буюу машиныг;
4. "токенс" гэж слот машин тоглуулахад хэрэглэдэг мөнгө орлогч зоосыг;
5. "чип" гэж тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх алтын тусгай хуванцар зоосыг.

**таар зүйл. Казиногийн тоглоомын төрөл**

Казиногийн тоглоом дараахь төрөлтэй байна:

1. ширээний тоглоом;
2. слот машин;
3. видео техник хэрэгслийн тоглоом.

Казиногийн тоглоомын нэрсийг Казиногийн асуудал эрхлэх батална.

**үгээр зүйл. Казиногийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

Казино нь үйл ажиллагаандаа шударга өрсөлдөх, эрх тэгш, ил тод лсэн зарчмыг баримтална.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Казино байгуулах, зөвшөөрөл олгох

**таар зүйл. Казино байгуулах**

Монгол Улсын Засгийн газар казино ажиллуулах зөвшөөрөл олгох дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.үндэсний аюулгүй байдал, нийгэм, иргэдийн эрх ашгийг хамг зорилгоор казиногийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүү хяналт тавьж, казиногийн үйл ажиллагаатай холбогдсон асу зохицуулан чиглүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх;

5.1.2. казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг олгох;

5.1.3. казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг далд т зарлаж дүгнэсний үндсэн дээр 3 хүртэл аж ахуйн нэгжид олгох;

5.1.4. тендерийн нөхцөл, болзлыг нарийвчлан боловсруулж зарлах.

5.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж бай ахуйн нэгж энэ хуулиар тогтоосон журмын дагуу онцгой эрхийн зөвш авсны үндсэн дээр казиногийн үйл ажиллагааг эрхэлж болно.

5.3. Онцгой эрхийн зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж шинээр казин салбар нээх буюу тоглоомын төрөл, тоогоо нэмэгдүүлэх бол энэ ху тогтоосон журмын дагуу тухай бүр зөвшөөрөл авна.

**6 дугаар зүйл. Казино байгуулах зөвшөөрөл олгох**

6.1. Засгийн газар дараах шаардлага хангасан аж ахуйн нэгжид к байгуулж ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг олгоно:

6.1.1. казиногийн 51-ээс доошгүй ширээний тоглоом ажил зориулалтын өрөө тасалгаа бүхий өөрийн буюу түрээсийн байртай;

6.1.2. казино ажиллуулахад шаардагдах олон улсын стандартад ни зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бусад хэрэ хангагдсан тухай баталгаа гаргасан;

6.1.3. аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хэмжээ нь 3 тэрбум төг доошгүй;

6.1.4. казиног ажиллуулахад бэлтгэгдсэн мэргэжлийн ажилтн хангагдсан тухай баталгаа гаргасан;

6.1.5. барьцааны 1 тэрбум төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмж хөрвөх валютыг Засгийн газрын зохих дансанд оруулсан.

6.2. Казино ажиллуулахыг хүссэн аж ахуйн нэгж энэ хуулийн заасан шаардлагыг хангасан тохиолдолд зохих зөвшөөрөл олгохыг өргөдлийг Засгийн газарт гаргах бөгөөд өргөдөлд дараах бичиг бар хавсаргана:

6.2.1. аж ахуйн нэгжийн танилцуулга;

6.2.2. хуулийн этгээдийн нэр, хаяг, бүртгэлийн гэрчилгээ, регис дугаар, эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчил танилцуулга, гишүүдийн нэр, хаяг;

6.2.3. аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож бай эсэхийг гэрчилсэн хуулийн байгууллагын тодорхойлолт ;

6.2.4. төлбөрийн чадварын тухай үйлчлүүлэгч банкны тодорхойло

6.2.5. казиногийн дүрэм;

6.2.6. казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;

6.2.7. казиног ажиллуулах байр,тоног төхөөрөмж болон аж нэгжийн нотариатаар батлуулсан хөрөнгийн баталгаа;

6.2.8. казинод ажиллах ажиллагсдын хөдөлмөрийн үндсэн н хөдөлмөрийн гэрээний загвар;

9. казиногийн мөнгөн кассын дүрэм;
10. барьцааны мөнгийг зохих дансанд тушаасныг тодорхойлох т.

. Онцгой эрхийн зөвшөөрөл авч чадаагүй тохиолдолд энэ хуулийн заасан барьцааны мөнгийг аж ахуйн нэгжид буцаан олгоно.

Энэ хуулийн 6.3-т заасан аж ахуйн нэгж хүсвэл казино ажиллуулах э эрхийн зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн салбар казино ууллахаар түүнтэй гэрээ байгуулж болно.

Засгийн газар аж ахуйн нэгжээс гаргасан өргөдлийг хүлээн авмагц огийн асуудал эрхлэх зөвлөлд шилжүүлнэ.

**угаар зүйл. Казиногийн асуудал эрхлэх зөвлөл**

Энэ хуулийн 6.1-д заасан Засгийн газрын чиг үүргийг Казиногийн л эрхлэх зөвлөл / цаашид "Зөвлөл" гэх/ хэрэгжүүлнэ.

. Зөвлөл нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд дарга, нарийн бичгийн 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн нарийн ин дарга орон тооны байх бөгөөд Зөвлөлийн хуралд таслах эрхгүй ню. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн лнэ.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүү, тайлан бүртгэлийн болон хуулийн слийн хүмүүсээс оруулах бөгөөд Зөвлөлийн гишүүн нь Монгол ял шийтгэлгүй иргэн байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн л эрхэлсэн байнгын хороотой зөвшилцсөний үндсэн дээр Засгийн жилийн хугацаагаар томилж, дүрмийг батална.

Зөвлөлийн гишүүнийг дараах тохиолдолд Зөвлөлийн эхүүнээс чөлөөлнө:

1. өөрөө хүсэлт гаргасан;
2. биеийн эрүүл мэндийн байдлын улмаас Зөвлөлийн гишүүний ажлыг эрхлэх боломжгүй болсон;
3. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдож, шүүхийн таслан эрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
4. төрийн албан хаагчийн ёс зүйг зөрчсөн нь эрх бүхий байгууллагын гээр батлагдсан.

Зөвлөлийн гишүүнийг дахин томилохыг хориглоно.

**л дэр зүйл. Зөвлөлийн эрхлэх асуудал, эрх, үүрэг**

Зөвлөл нь үндэсний аюулгүй байдал, нийгэм, иргэдийн эрх ашгийг лах зорилгоор энэ хуулиар тогтоосон журмын дагуу казино уулахыг хүссэн аж ахуйн нэгжийн өргөдөл, холбогдох бусад бичиг ыг судлах, шалгах, санал дүгнэлт гаргах, Засгийн газраар шүүлээр оруулах асуудлыг эрхэлнэ.

Зөвлөл өргөдөл, холбогдох бусад бичиг баримтыг энэ хуулийн 6.2-т шаардлагыг хангаагүй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш ийн дотор өргөдөл гаргагчид буцаана.

Зөвлөл өргөдөл, холбогдох бусад бичиг баримт зохих шаардлага н гэж үзвэл 30 хоногийн дотор холбогдох санал, дүгнэлтийг гаргаж,

Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

8.4. Зөвлөл дараах асуудлаар санал дүгнэлт гаргана:

8.4.1. казино ажиллуулахыг хүссэн аж ахуйн нэгжийн өрг холбогдох бичиг баримтыг судлан үзээд аж ахуйн нэгжээс санал бо буй нөхцлүүд нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид з шаардлагад нийцэж буй эсэх;

8.4.2. аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхи, хөрөнгийн болс хангалттай эсэх;

8.4.3.зөвшөөрөл олгож болох эсэх.

8.5. Зөвлөл дараах эрх үүрэгтэй:

8.5.1. казиногийн үйл ажиллагаа буюу тоглоомын хэрэгсэл, холб тоног төхөөрөмж үйлдвэрлэх, хадгалах, худалдан борлуулах, нийл ажлыг эрхлэж байгаа аж ахуйн нэгжийн ажиллагааг хянан ша казиногийн байр болон тоглоомын хэрэгсэл, холбогдох тоног төхөө сэлбэг хэрэгслийг шалгах;

8.5.2. шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн дагуу казин байр, эд хөрөнгийг битүүмжлэх, хяналт шалгалтын зорилгоор тогло хэрэгсэл, холбогдох тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг түр бүрмөсөн хураах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад ш шийдвэрлүүлэх;

8.5.3. казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн баримт, санхүү , нягтлан бодох бүртгэлийг хөндлөнгийн хяна шалгуулах болон хуулбарлах, эрх хэмжээнийхээ хүрээнд хянаж шалгах

8.5.4. казиногийн дотоод дүрэм болон тоглоомуудын дүрэм, жу батлах;

8.5.5. казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжээс төсөвт төлөх онцгой татварын төлөлтөнд хяналт тавих;

8.5.6. үйл ажиллагааныхаа талаар жил бүр Засгийн газарт тайлагн

8.5.7. казиногийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг Засгийн тухай бүр танилцуулж шийдвэрлүүлэх;

8.5.8. казиногийн үйл ажиллагаатай холбогдолтой бичиг баримт ахуйн нэгж, холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах.

8.6. Зөвлөл шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллага, хүм оролцуулсан шинжээчдийн хэсгийг томилж, аж ахуйн нэгжээс ир бичиг баримтыг судлуулж санал дүгнэлт гаргуулж болно.

8.7. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хура мөн. Хуралдааныг Зөвлөлийн дарга даргалах ба асуудлыг оло саналаар шийдвэрлэнэ.

8.8. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга зарлан хуралдуул Зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхи оролцсоноор хуралдаан тогтолдлор болно.

8.9. Зөвлөл аж ахуйн нэгжээс гаргасан хүсэлтийг хуралдаа хэлэлцэж, гарсан саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

8.10. Зөвлөл казинод шаардлагатай тоног төхөөрөмж, холб хэрэгслээр хангах үүргийг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулан ханг гэрээний биелэлтийг шалгах ажлыг зохион байгуулна.

*Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг*
*н Их Хурлаар хэлэлцээж шийдвэрлэтэл хуулийн энэ заалт хүчин*
*эдөр дагаж мөрдөгдөхгүй болно/*

11. Зөвлөл нь Монгол Улсын нутагт ажиллуулах казиногийн бүх
эмонд ашиглах чип, токенс, бусад хэрэгслийн загварыг батална.

**дүгээр зүйл. Зөвшөөрлийн хугацаа**

1. Засгийн газар казиногийн үйл ажиллагаа эрхлэх онцгой эрхийн
өөрлийг аж ахуйн нэгжид 10 хүртэл жилийн хугацаагаар олгоно.
2. Зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд
ээр гарсан өдрөөс эхлэн тооцно.
3. Засгийн газар шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг сунгаж болно.

**дугаар зүйл. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх**
**аж ахуйн нэгжийг бүртгэх**

.1. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх онцгой эрх авсан аж ахуйн нэгж
э тухайгаа Үндэсний татварын ерөнхий газарт бүртгүүлнэ.
Үндэсний татварын ерөнхий газар эрх бүхий байгууллагын шийдвэр,
уйн нэгжийн өргөдлийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ
ю.
.3. Үндэсний татварын ерөнхий газар өргөдлийг хүлээж авснаас хойш
огийн дотор бүртгэж, энэ тухайгаа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр
л мэдээлнэ.
.4. Казиног эрх бүхий байгууллагад улсын бүртгэлд бүртгүүлж
лгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэнд тооцно.
.5. Казино өөрийн оноосон нэртэй байж болно.

**дүгээр зүйл. Зөвшөөрлийг хүчингүй болгох**

.1. Засгийн газар Зөвлөлийн саналыг үндэслэн дараах тохиолдолд
о ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг хүчингүй болгож болно:
.1.2. зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон;
ол Улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн үйл ажиллагаа явуулсан
х бүхий байгууллагын шалгалтаар тогтоогдсон;
.1.3. зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 6 сарын
үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй буюу үйл ажиллагаа нь 3 сараас
хугацаагаар тасалдсан;
.1.2. аж ахуйн нэгж татан буугдсан;
.1.5. Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр казиногийн үйл ажиллагаа
х эрхээ бусдад дур мэдэн шилжүүлсэн;
.1.6. хуульд заасан бусад үндэслэл.
.2. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан бүртгэх байгууллага нь тухайн
хуйн нэгжийн зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай эрх бүхий
уллагын шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлээс хасч, энэ тухайгаа
л, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Казино ажиллуулах журам

**12 дугаар зүйл. Казино ажиллуулах байр**

12.1. Казиног Зөвлөлөөс зөвшөөрсөн зориулалтын байранд эрхлэн

12.2. Казиногийн тоглоомын өрөөнүүд хоорондоо тусгаарлагдсан ба тус тусын хаалгаар орж гарна.

12.3. Казиногийн байр, тоглоомын техник хэрэгсэл, тоног төхөөр тавилга хэрэгсэл нь ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл ахуй, аю байдлын шаардлагыг хангасан байна.

12.4. Казинод нийтийн тоглоомын өрөөнүүдээс гадна тогтоомжоор хориглоогүй үйлчилгээний өрөөнүүдийг ажиллуулж бол

12.5. Казинод мөнгө солих цэг ажиллуулах ба гадаад валютыг ту өдрийн төгрөгтэй тэнцэх ханшаар сольж үйлчилнэ.

12.6. Казинод зээлээр тоглох, зээлдэгийн буюу ломбард /барьц зээлдүүлэх үйлчилгээ/-ний үйлчилгээ ажиллуулахыг хориглоно.

12.7. Казино Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн гар дотоод журмыг мөрдөнө.

12.8. Казиногийн дотоод журмын биелэлтэд нь хяналт тавих болс журам сахиулах ажлыг казино өөрөө хариуцна.

12.9. Казиногийн тоглоомын ширээ бүр нь дүрс бичлэгийн боло бичлэгийн хяналтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

12.10. Ширээ бүрийн дууны болон дүрсний бичлэгүүд нь 72 цагийн хадгалагдана.

12.11. Казиногийн ажилтан болон үйлчлүүлэгч нь Монгол Улсын тогтоомж, казиногийн дотоод журмыг сахин биелүүлэх үүрэгтэй.

**13 дугаар зүйл. Казино ажиллуулах журам**

13.1. Казиног өдөр бүр ажиллуулж болно.

13.2.Казинод зөвхөн зөвшөөрөгдсөн тоглоомуудыг тоглуулна. Ш тоглоомын төрөл ажиллуулах бол холбогдох зөвшөөрлийг нэ заасан журмын дагуу авч, дүрмийг эрх бүхий байгууллагаар батлуул

**14 дүгээр зүйл. Казиногийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

14.1. Казинод дараахь хүмүүсийг тоглуулахыг хориглоно:

14.1.1. 21 нас хүрээгүй иргэн;

14.1.2. согтууруулах ундаа хэрэглэсэн болон эрхийн бүрэн чад этгээд, гэмт хэрэгтэн этгээд;

14.1.3. Зөвлөлийн гишүүд болон казиногийн удирдлага, ажилтнууд.

14.2. Казиногийн ажилтнууд болон тоглож буй үйлчлүүлэгчид нь к тоглож байгаа байдлыг ямар ч байдлаар гадагш мэдээлэхийг хориглон

14.3. Казиногийн ажилтнууд хувьдаа гар цайлгах мөнгө, шан авахыг хориглоно.

**дугаар зүйл. Казинод орох шаардлагатай төрийн албан хаагч**

1. Албан ажлын шаардлагаар дор дурдсан төрийн албан хаагч ид орж болно:

1.1. шүүх, прокурор, Хууль зүйн яамны холбогдох ажилтан;

1.2.Улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын хий ажилтан;

1.3. казино ажиллуулж байгаа дүүрэг, хорооны Засаг дарга;

1.4. татварын албаны ажилтан.

2. Албан ажлын шаардлагаар казинод орох эрх бүхий төрийн албан д Зөвлөл тусгай үнэмлэх олгоно.

3. Энэ хуулийн 15.1-д заасан төрийн албан хаагчид бооцоо тавьж д тоглохыг хориглоно.

*э зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хуулийн энэ заалт хүчин өр дагаж мөрдөгдөхгүй болно/*

**дугаар зүйл. Хяналт шалгах зөвлөл**

1. Казинод аж ахуйн нэгжийн эрх барих байгууллагын шийдвэрээр шалгах зөвлөлийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үүлах бөгөөд уг зөвлөлийн ажиллах журмыг Зөвлөл батална.

2. Хяналт шалгах зөвлөл нь ажиглалтын алба, хамгаалалтын алба, ын албатай байх ба тэдгээр нь дараах эрх, үүрэгтэй:

2.1. казинод тоглохоор ирэгсдийн бичиг баримтыг шалгах;

2.2. ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих;

2.3. казиногийн байранд зөрчил, маргаан гарвал зохицуулах;

2.4. казиногийн дүрэм, журам зөрчсөн этгээдийг тоглоомын аас хөөн гаргах;

2.5. дээр дурдсан этгээд нь тавьсан шаардлага биелүүлэхгүй бол и гаргах;

2.6. энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан зөрчил гаргасан ажилтныг халах тухай саналыг аж ахуйн нэгжийн удирдлагад тавьж эрлүүлэх.

2.7. казиногийн байранд танхайрсан, ажил үүргээ гүйцэтгэж байгаа ыг доромжилсон, заналхийлсэн үйлдэл гаргасан этгээдийг гийн байгууллагад шилжүүлэх.

**дугаар зүйл. Казиногийн тоглоомыг тоглуулах журам**

Казиногийн ширээнүүдэд дугаар хадаж, тоглоом бүрийн бооцооны ход хэмжээг бичиж тавьсан байна.

Казиногийн бүх төрлийн тоглоомыг тоглуулахдаа эрх бүхий лагаар баталгаажсан тодорхой үнэлгээ бүхий зориулалтын чип, буюу бусад хэрэгслийг ашиглана.

Казиногийн тоглоом бүр эрх бүхий байгууллагаас баталсан эй байх ба дүрмийг хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан

17.4. Тоглоомыг ажиллуулах ажилтнууд дүрмийг тоглог тайлбарлаж танилцуулна.

17.5. Казиногийн ажилтан тоглоомын ширээ захиалгатай гэж байлгаж болохгүй.

17.6. Казиногийн тоглоомыг тоглуулахдаа энэ хуулийн 17.2-г зө хуурамч чип, токенс хэрэглэхийг хориглоно

**18 дугаар зүйл. Хуурамч буюу батлагдаагүй чип, токенс, тоглоомын хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглахыг хориглох**

18.1. Казиногийн тоглоомын үйл ажиллагаанд хуурамч буюу эрх б байгууллагаар батлагдаагүй чип, токенс, олон улсын стандартыг ханг тоглоомын хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

18.2. Казиногийн ажилтан болон бусад этгээд мөнгө, үнэт зүйл, токенсийг хууль бусаар олж авах зорилгоор тоглоомын хэрэгсэл, т төхөөрөмжийг онгойлгох, үйл ажиллагаанд нь нөлөөлөх зориула аливаа багаж, техник хэрэгсэл, түлхүүрийг биедээ авч явах буюу ашигл хориглоно.

18.3. Эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авалгүйгээр казино тоглоомын хэрэгсэл, слот машин, тоног төхөөрөмж, бусад хэрэг ашиглах, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Санхүү, татвар

**19 дүгээр зүйл. Санхүүгийн тайлан тэнцэл**

19.1. Казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь тогтоомжоор тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлан тэнцлий бүхий байгууллагад зохих ёсоор гаргаж өгөх үүрэгтэй.

19.2. Казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэ санхүүгийн үйл ажиллагаанд холбогдолтой дараах маягтуудыг хөтөлн

19.2.1. . тоглоомын ширээ бүрийн тоглолтын явцыг бүртгэх;

19.2.2. чип, токенс авалтыг бүртгэх;

19.2.3. чип, токенс тушаалтыг бүртгэх;

19.2.4. гүйлгээнд байгаа чип, токенсыг бүртгэх;

19.2.5. шоо, хөзөр, хөзрийн хайрцгийг бүртгэх;

19.2.6. нөөцийн сангаас авсан буюу буцааж тушаасан мөн баримтыг бүрдүүлэх;

19.2.7. тоглоомын боомооны тавилыг хөтлөх.

19.3. Дээр дурдсан бүртгэлийг Хянан шалгах зөвлөл дугаарлан хө гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

19.4. Бүртгэлийг баллаж, засварлаж болохгүй бөгөөд хэрэв шаардлага гарвал улаан өнгийн үзгээр засаж, хянан шалгаад зөвл гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

19.5. Казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж бүрийн эхний 2 хоногт урьд сарын санхүүгийн нэгдсэн тайлан г

эо, чип, токенс, чекээр орсон орлого, хандив, цалин гэх мэт орлого, гын үзүүлэлт тус бүрээр тайланг гаргана.

9.6. Казиногийн ажилтан тоглоомын нэр, төрөл, тоо хэмжээ, бооцооны ээ, нөөцийн сангаас авсан мөнгөний хэмжээ, өдөр бүрийн орлого, длыг тооцож, Хянан шалгах зөвлөлд гаргаж өгнө.

**9 дугаар зүйл. Татвар**

9.1. Казиногийн үйл ажиллагаатай холбоотой татварыг Татварын ний хууль[1], бусад хууль тогтоомжоор зохицуулна.

9.2. Казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь хууль омжоор тогтоосон хугацаанд татварыг төлөх үүрэгтэй.

9.3. Казиногийн байранд татварын газрын бие төлөөлөгч байнга т тавьж ажиллана.

9.4. Казиногийн онцгой албан татварын орлогын гуравны нэгтэй х хэсгийг аймаг, нийслэлийн төсөвт оруулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

.1. Казиногийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай сд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны цлага хүлээлгэнэ:

.1.1. энэ хуулийн 12.6-д заасныг зөрчиж, зээлээр тоглосон, улахыг зөвшөөрсөн, зээллэгийн буюу ломбардын үйлчилгээний цэг нуулсан бол аж ахуйн нэгжийн удирдлага, казиногийн ажилтан, гчийг 500000 төгрөгөөр торгох;

.1.2. зөвшөөрөлгүйгээр тоглоомын төрөл ажиллуулсан нь эрүүгийн цлага хүлээлгэхээргүй бол 500000 төгрөгөөр торгох ба тоглоомын эл болон олсон орлогыг хураах;

1.3. энэ хуулийн 14 дүгээр зүйл, 15.3-т заасныг зөрчиж, казинод улахыг хориглосон хүмүүсийг казинод оруулж тоглуулсан тохиолдолд сон болон тоглуулсан этгээдийг 100000 төгрөгөөр торгох;

1.4. энэ хуулийн 14.2, 14.3-ийг зөрчсөн этгээдийг 100000 төгрөгөөр ;

1.5. энэ хуулийн 16.7-д заасан үйлдэл гаргасан этгээдэд эрүүгийн цлага хүлээлгэхээргүй бол 100000 төгрөгөөр торгох;

1.6. энэ хуулийн 17.6-д заасан зөрчил гаргасан этгээдийг 100000 өөр торгох;

1.7. энэ хуулийн 18 дугаар зүйлийг зөрчсөн этгээдэд эрүүгийн

---

арын ерөнхий хууль "Ардын эрх" сонины 1993 оны 1 р сарын 5-ны өдрийн 3 дугаарт, "Төрийн мэдээлэл" ллийн 1993 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

хариуцлага хүлээлгэхээргүй бол 500000 төгрөгөөр торгох.

21.2.Энэ зүйлд заасан захиргааны хариуцлагыг цагдаа байгууллагын эрх бүхий ажилтан хууль тогтоомжоор тогтоосон жу дагуу хүлээлгэнэ.

21.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр казиногийн ажиллагаа эрхэлсэн этгээдэд эрүүгийн хуульд заасан хариу хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОР**

*[Жич: Казиногийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 15 д зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчлэн хориг тавьсан тул уг хор Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэтэл энэ ху эдгээр зүйл, заалтууд нь хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй бо сонордуулъя. Энэ тухай тайлбарыг хуулийн хориг тавигдсан заалтуудын ард хийсэн болно/.*

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр — Улаанбаат хот

## ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын хуульд дор ду агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 6 дахь заалт:

"6/казиногийн үйл ажиллагаа";

2/ 6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

"5.Казиногийн үйл ажиллагааны онцгой албан татвар да хувь, хэмжээтэй байна:

1/ эхний жил нийт орлогын 10%;

2/ хоёр дахь жилээс жил тутам 3 пунктээр өсгөнө.

6. Казиногийн үйл ажиллагааны онцгой албан татвар нь орлогын 40 хувиас дээшгүй байна".

3/ 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Казиногийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд онцгой татварыг сар бүрийн 15-ны болон сарын эцсийн өдөрт төсөвт тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор тушаана".

**дугаар зүйл.** Онцгой албан татварын хуулийн 1 дүгээр зүйлийн м бараанд" гэсний дараа "болон зарим үйл ажиллагаанд" гэж, таар зүйлийн "үйлдвэрлэж байгаа" гэсний дараа "болон ногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа" гэж, 4 дүгээр зүйлийн гийн "бараа" гэсний дараа ",үйл ажиллагаа" гэж мөн зүйлийн хэсэгт "бараанд" гэсний дараа "болон үйл ажиллагаа" гэж тус эмсүгэй.

**дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин дор болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ОНГОЛ УЛСЫН ИХ**
**РЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

оны 1 дүгээр Улаанбаатар
15-ны өдөр хот

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**дүгээр зүйл.** Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан ын хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт гэй:

7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:
)/ казиногийн тоглоомын үйл ажиллагаанаас олсон орлого".
7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг:
l.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын ан албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг казиногийн үйл агаа эрхлэгч аж ахуйн нэгж эдлэхгүй."

**угаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ОНГОЛ УЛСЫН ИХ**
**РЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр — Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Монгол Улсын Эрүүгийн хуульд доор дур агуулгатай 146/2/ дугаар зүйл нэмсугэй:

"146/2/ дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих

Гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажил явуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу зуун мя хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр — Улаанбаат хот

### ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь гүйцэтгэх ажил, түүнийг эрхлэх тө байгууллага /цаашид "гүйцэтгэх байгууллага" гэх/, ажилтны ажиллагааны зарчим, эрх, үүргийг тодорхойлж тэдгээрт хяналттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил**

Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халд хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердий тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдэ баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажил гүйцэтгэх ажил гэнэ.

**угаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж**

йцэтгэх ажлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Улсын гүй байдлыг хангах тухай хууль, энэ хууль, тэдгээртэй гүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**угээр зүйл. Гүйцэтгэх ажлын зарчим**

йцэтгэх ажилд үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй ыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хүний эрх, өлөөг хүндэтгэх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах ыг удирдлага болгоно.

**угаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл**

нь хүний иргэний харьяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, гө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын т нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гэх ажил явуулахад саад болохгүй.

**угаар зүйл.Хуулийн нэр томьёо**

"Тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажил"," нууц арга, эл"," нууц гүйцэтгэх ажилтан", " туслагч, туслах ажилтан", ичлах" гэсэн нэр томьёог Монгол Улсын Аюулгүй байдлыг тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.

"Эрэн сурвалжлах ажил" гэж Улсын аюулгүй байдлыг хангах ллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн ин шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор луулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг эгтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.

**угаар зүйл.Гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах**

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл агааны улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа үн, хуулийн этгээд зохих дээд шатны байгууллага, албан тан, прокурорт гомдол гаргах эрхтэй.

Гүйцэтгэх байгууллага, түүний ажилтан нь хуулиар олгосон мжээгээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж хууль бусаар иргэн, ин этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг юсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан байгууллага, тушаалтан болон шүүх зөрчигдсөн эрхийг нь сэргээж, учирсан ныг арилгах арга хэмжээг тус тусын чиг үүрэг, хууль мжид заасны дагуу авна.

**угаар зүйл. Гүйцэтгэх ажилд хориглох зүйл**

Энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байгууллага, албан тан, хувь хүн гүйцэтгэх ажил явуулах аливаа техник ийг гүйцэтгэх ажлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно.

8.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн дүгээр зүйлд зааснаас бусад үндэслэлээр гүйцэтгэх ажил явуула хориглоно.

8.3. Гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх ажилтан, нууц гүйц ажилтан, туслагч, туслах ажилтныг ажиллуулахдаа хуулиар өөр зөвшөөрөгдөөгүй эрх эдлүүлэх буюу харьялуулснаас өөр асу шалгуулах, түүнчлэн хууль тогтоомжоор хориглосон техник хэр ашиглуулж болохгүй.

8.4. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх х заасан албан тушаалтан, Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерө хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Монгол Улсын их Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируу хэрэгжүүлэгч агентлагийн дарга нууц нар гүйцэтгэх ажилтан, тус туслах ажилтан байж болохгүй.

8.5. Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн Сонгуулийн Ерөнхий хорооны гишүүн, шүүгч, проку өмгөөлөгчийн үнэмлэхийг халхавчийн баримт бичиг бо ашиглахыг хориглоно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА, ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ЯВУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ХҮРЭЭ

**9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага**

9.1. Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх явуулах эрхтэй:

9.1.1.Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага- тагнуул, тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонир хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, ху хэрэгжүүлсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм бур этгээдийг олж тогтоох;

9.1.2. цэргийн тагнуулын байгууллага-олон улсын болон нутгийн цэрэг, улс төрийн байдал, үүсч болзошгүй цэргийн заналыг судлаж, түүнээс Монгол Улсад учирч болох хор аю урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, төрийн дээд болон з хүчний удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;

9.1.3. цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн заасныг бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт х илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж то түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, с сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүү

ясан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум сэл, тэсрэх дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх ин дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох;

1.4. шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба дол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон эх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, н зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор н хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах.

2. Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг улах зорилгоор Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага энэ ийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг жүүлнэ:

2.1. гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;

2.2. үйцэтгэх ажилд дагаж мөрдөх журам, зааврыг хууль эмжид нийцүүлэн батлах;

2.3. энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллагын мэдээл н утсан харилцаа хянах, сонсох төхөөрөмжийн улсын нэгдсэн үртгэл хөтлөж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих;

2.4. гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл зохион бүтээх, олж авах, ах талаар нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

2.5. нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны н дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг , цагдаа болон хорих ял эдлүүлэх байгууллага дээр хянан х, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, лагатай мэдээ баримтыг гаргуулж авах.

3. Гүйцэтгэх ажлыг хуульд заасан тус тусын чиглэлээр бие даан харилцан ажиллах, хувь хүн, хуулийн этгээдийн туслалцаа авах э хэрэгжүүлнэ.

. Гүйцэтгэх ажил явуулахдаа холбоо, мэдээллийн систем, гэрэл кино, дүрс, дууны болон бусад бичлэг хийх, хүний амь бие, мэнд, хүрээлэн байгаа орчинд аюулгүй бусад техник хэрэгсэл ана.

**дугаар зүйл. Халхавчийн баримт бичиг, бусад зүйл**

1. Халхавчийн баримт бичиг болон бусад зүйлд гүйцэтгэх ллага, тэдгээрийн ажилтны ажиллагаа, байр, эд хөрөнгө, ийн хэрэгслийг далдлах баримт бичиг, нэр хаяг, дүрэмт хувцас

2. Халхавчийн баримт бичиг, бусад зүйлийг халхавчилж байгаа ллагын даргын шийдвэрээр олгоно.

**дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл**

1. Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр агза явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний

аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаархи төрийн бодлогын үнд
удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэ
өөрийн үзэмжээр явуулна.

11.2. Цагдаагийн байгууллага эрэн сурвалжлах ажлыг доор дур
үндэслэлийн аль нэг нь байвал гүйцэтгэнэ:

11.2.1. хуулиар харьяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйл
буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл б
мэдээллийг ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй;

11.2.2. хуулиар харьяалуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг
арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй;

11.2.3. эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд ша
зорилгоор шүүх, прокурор, мөрдөн байцаагчаас даалгавар ирүүлсэ

11.2.4. баривчилгаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга бо
хүнийг эрж олох талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт
өөрт байгаа баримтыг үндэслэн;

11.2.5. энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д за
баримт бичиг, эд зүйлийг эрж олох талаар байгууллага, ирг
хүсэлт ирүүлсэн;

11.2.6. эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх г
Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгуулл
хүсэлт ирүүлсэн.

11.3. Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага өөрт нь хуу
харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүү үүс
хэргийг шалгахдаа энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д за
үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.

11.4. Хорих ял эдлүүлэх байгууллага энэ хуулийн 9 ду
зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан зорилтыг хэрэгжүүлэхийн
хоригдлын дунд, түүнчлэн оргосон ялтныг баривчлах зорилгоор
сурвалжлах ажил явуулна.

11.5. Гүйцэтгэх ажилтан, туслах ажилтнаар ажиллуулах хү
шалгаж сонгох, төрийн нууц хариуцах ажилтныг судалж ша
Харьяатын тухай хуулийн 2О дугаар зүйлийн 4 дэх хэсэгт за
дагуу иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний т
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үүднээс дүгнэлт г
зорилгоор гүйцэтгэх ажил явуулж болно.

**12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ**

12.1. Гүйцэтгэх ажил дараахь хүрээгээр хязгаарлагдана:

12.1.1. гадаад улс, байгууллагын тодорхой бодлого,
ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонир
хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох тагнуулын ажил;

12.1.2. Монгол Улсын эсрэг гадаадын улс, байгууллага, и
тэдгээрийн төлөөний этгээдийн зүгээс явуулж байгаа тагнуул, хо
сүйтгэх ажиллагаа болон тагнуулын байгууллагын харьяаллын гэ

ийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн х тагнуулын ажил;

2.1.3. энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т зааснаас бусад гэмт ийг илрүүлэх, таслан зогсооход чиглэсэн эрэн сурвалжлах ажил;

2.1.4. оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, барьцаанд байгаа ийг суллах, сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүнийг олох ажил;

2.1.5. алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, г, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхт, мансууруулах с, түүх, соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох;

2.1.6. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хэрэг хянан шийдвэрлэх ийн ажиллагаанд шаардлагатай нотлох баримтын эх сурвалжийг тогтоох.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ БҮРЭН ЭРХ, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

**дугаар зүйл. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрх**

.1. Гүйцэтгэх байгууллага өөрийн орон тооны ажилтан /цаашид гэтгэх ажилтан" гэх/, түүнчлэн нууц гүйцэтгэх ажилтан, туслах тан, туслагч /цаашид "туслах ажилтан" гэх/-аар дамжуулан тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

.2. Гүйцэтгэх байгууллага, ажилтан дараах эрх эдэлнэ:

.2.1. хуулиар харьяалуулсан болон энэ хуулийн 11 дүгээр зүйлд н үндэслэлийн дагуу гүйцэтгэх ажил явуулах;

.2.2. шаардлагатай бол байгууллага, иргэдийн байр, орон сууц, р, холбоо, мэдээллийн хэрэгслийг зохих хэлцэлгэйгээр ашиглах;

.2.3. сэжигтэн, яллагдагч, ялтан болон хэрэг бүртгэх, мөрдөн ах, шүүх прокурорын байгууллагад шалгагдаж байгаа оргосон нуугдаж байна гэж үзэх үндэслэл байвал байгууллага, ийн байр, орон сууцанд саадгүй орох, иргэний баримт бичгийг х;

.2.4. өөрийн болон гүйцэтгэх, туслах ажилтан, тэдгээрийн үйл агаар далдлах зорилгоор хаалхавчийн баримт бичиг, бусад зүйл ах, халхавчийн байгууллага байгуулах;

.2.5. гүйцэтгэх ажил хууль тогтоомжоор хориглоогүй техник эл ашиглах, тэдгээрийг зохион бүтээх

.2.6. ажил үүргээ гүйцэтгэж байхдаа зэвсэг, тусгай хэрэгслийг сон журмын дагуу биедээ авч явах, хэрэглэх.

13.3. Гүйцэтгэх байгууллага, ажилтан дор дурдсан үүрэгтэй:

13.3.1. хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэгжүүл шаардагдах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

13.3.2. гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа ту түүнчлэн улс, нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахуйц ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл авмагц гарч болох а хохирлыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусын чиг үүргийн дагуу шуурхай авах;

13.3.3. өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа гүйцэтгэх аж зориулалттай техник хэрэгслийн болон нууц арга хэрэглэж зохи ажлын тоо бүртгэл хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгу ажиллуулах;

13.3.4. өөрийн болон гүйцэтгэх, туслах ажилтны аюулгүй бай хангах, хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж тэдгээрт учирч болох халдлагаас урьдчилан сэргийлэ

13.3.5. шалгаж тогтоогоогүй шийдвэрлээгүй мэдээ баримтыг задруула байх, гүйцэтгэх ажлын явцад мэдсэн буюу илэрхий болсон м баримтыг хууль бусаар хувийн болон улс төрийн зорил ашиглахгүй байх, түүнчлэн гүйцэтгэх ажил явуулахдаа бусдыг о хатгаж гэмт хэрэгт турхирахгүй байх;

13.3.6. гүйцэтгэх ажлын холбогдолтой төрийн нууцыг хамгаалах, нууцлалыг сахих;

13.3.7. шаардлагатай бол гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий б байгууллагатай мэдээлэл солилцох, хамтарч харилцан ажиллах;

13.3.8. гүйцэтгэх ажлын хэргийн шалгалтыг хуульд за үндэслэл, журмын дагуу явуулах, хэргийн мэдээ, баримтыг х тогтоомжид заасан үндэслэл журмыг зөрчиж устгахгүй байх, архи зохих журмын дагуу хөтлөх;

13.3.9. гүйцэтгэх ажлын зориулалтаар төсвөөс олгосон хөрөн зохих зориулалт, журмын дагуу зарцуулж тайланг тогто хугацаанд гаргах;

13.3.10. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

13.4. Гүйцэтгэх байгууллага, ажилтнаас энэ хуульд за үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад аж ахуйн н байгууллага, тэдгээрийн албан тушаалтнаас саад учруул хориглоно.

**14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах**

14.1. Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуули дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн зөвшөөрснөөр иргэний харьяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, а тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харга туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.

2. Туслагч, туслах ажилтныг бичгээр байгуулсан гэрээний
н дээр ажиллуулна.
3. Туслагч, туслах ажилтныг зөвхөн гэрээ байгуулсан
ллагад хуулиар харьяалуулсан асуудлыг шалгахад оролцуулах
1 гэрээнд гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагын
тодорхой заана.
4. Туслагч, туслах ажилтныг нэгээс илүү гүйцэтгэх
ллагад ажиллуулахыг хориглоно.
5. Туслагч, туслах ажилтан нь гүйцэтгэх байгууллага, түүний
хий ажилтнаас энэ хуулийн хүрээнд өгсөн үүргийг биелүүлнэ.
үүрэг нь тухайн байгууллагын харьяалалд хамаарахгүй, энэ
йн заалтад нийцэхгүй байна гэж үзвэл туслагч, туслах ажилтан
гийг биелүүлэхээс татгалзаж болно.
6. Туслагч, туслах ажилтанд хууль зөрчсөн үүрэг өгч
лгүүлсэн гүйцэтгэх ажилтныг эрх мэдлээ хэтрүүлсэнд тооцож
ийн хариуцлага хүлээлгэнэ.

**дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын санхүүжилт**

1. Гүйцэтгэх ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
2. Гүйцэтгэх ажлын зайлшгүй шаардлагаар зохих хууль
өмжийн дагуу байгуулсан халхавчийн байгууллагын аж ахуйн
иллагааны орлогыг гүйцэтгэх ажлын зардалд ашиглаж болно.
3. Гүйцэтгэх ажлын төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Төрийн
шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т
эрх бүхий албан тушаалтан шалгана.
4. Гүйцэтгэх ажлын зардлыг салбар нэгжид хуваарилах,
лалтад тавих хяналтыг тухайн гүйцэтгэх байгууллагын дарга
на.

**дугаар зүйл. Гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтны**
**үйл ажиллагааны эрх зүйн баталгаа**

1. Гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтан албан үүргээ
лсэнтэй нь холбогдуулж амь бие, эрүүл мэнд, нэр төр, түүний
л, эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.
2. Хуулийн хүрээнд явуулсан гүйцэтгэх ажлын улмаас хувь хүн,
йн нэгж, байгууллагад учирсан хохирлыг төр хариуцна.
3. Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу туслагч, туслах
аар ажиллаж байгаа буюу ажиллаж байсан тухай мэдээ төрийн
хамаарна.
4. Гүйцэтгэх байгууллага нь туслагчийг ажлын үр дүнгээр
уулж, туслах ажилтанд зохих хөлс олгоно.
5. Туслагч, туслах ажилтан нь гүйцэтгэх байгуллага, ажилтнаас
үүргийг биелүүлэх үедээ амь нас, хөдөлмөрийн чадвараа
, тахир дутуу болсон бол гүйцэтгэх ажилтанд тухайн
долд олгодогтой ижил хэмжээний нэг удаагийн буцалтгүй

болон бусад тусламж авах эрхтэй бөгөөд ар гэрт нь тэжэ алдсаны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтг тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгоно.

16.6. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтнаас энэ ху заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад и хуулийн этгээд хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэ хориглоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ЯВУУЛАХ

**17 дугаар зүйл. Мэдээ, мэдээлэл шалгах**

17.1. Гүйцэтгэх байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр заасан үндэслэлээр цуглуулсан, эсхүл иргэн, хуулийн этгэ холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн ирүүлсэн м мэдээллийг судалж шалган шийдвэрлэнэ.

17.2. Мэдээ, мэдээлэл нь тухайн гүйцэтгэх байгуулл харьяаллын асуудал биш байвал харьяалах гүйцэтгэх байгуул нэн даруй шилжүүлж, энэ тухай мэдээ, мэдээлэл ирүүлсэн и хуулийн этгээдэд хариу мэдэгдэнэ.

**18 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах**

18.1. Гүйцэтгэх ажлын явцад авагдсан мэдээ, мэдээлэл, ба бичиг, нотолгоог зөвхөн дараах зорилгоор ашиглана:

18.1.1. үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийц төрийн бодлого боловсруулах, тухайн байгууллагад тогтоомжоор оногдуулсан үүргийг шийдвэрлэх;

18.1.2. гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдч сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох ба цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох;

18.1.3. Төрийн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлд з албан тушаалтнуудад танилцуулах.

**19 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын хэрэг нээх**

19.1. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны хийсэн судалгаа, шалгалтаар дараах байдал тогтоогдвол гүйц ажлын хэрэг нээнэ:

19.1.1. үндэсний болон улс орны аюулгүй байдалд хор у учруулах гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж б тухай үндэслэлтэй сэжиг тогтоогдсон;

19.1.2. энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан үндэслэл тогтоогд

19.2. Гүйцэтгэх ажлын хэрэг нээх тогтоолд тухайн гүйц байгууллагын дарга гарын үсэг зурснаар хүчинтэй болох б үүнийг нааш нь шалгах үүргийг эрх бүхий ажилтанд хариуцуулн

9.3. Хэрэг нээн шалгах явцад авагдсан мэдээ, мэдээллийг түүлж, устгаж болохгүй.

**О дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын хэрэг хаах**

).1. Дор дурдсан тохиолдолд гүйцэтгэх ажлын хэрэг шалгах лагааг дуусгавар болгож, хэргийг хаана:

).1.1. шалгасан үндэслэл батлагдан эрүүгийн хэрэг үүсгэсэн, ı эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэр гарсан;

).1.2. оргосон этгээд баривчлагдсан, барьцаанд авагдсан хүн ırдсан, сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, эсхүл дсан эд зүйл олдсон;

).1.3. гүйцэтгэх ажлын үр дүнг энэ хуулийн 18 дугаар зүйлд ıаар ашигласан;

).1.4. хэргийн холбогдогч нас барсан буюу Монгол Улсын ıс бүрмөсөн гарсан нь тогтоогдсон.

**l дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалах**

.1. Төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй йн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу шана.

.2. Төрийн нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг итгэмжлэн ıсан гүйцэтгэх ажилтан, албан тушаалтан нь уг ажил, албан лд томилогдох буюу халагдахдаа нууц хадгалах баталгааг эр гаргана.

.3. Гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй ıах эрх олгогдсон албан тушаалтан, тэдгээртэй танилцахдаа хадгалах баталгаа гаргана.

.4. Туслагч, туслах ажилтантай гэрээ байгуулах үедээ нууц ıах баталгааг бичгээр гаргуулна.

.5. Энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан баталгаа гаргасан ı нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцыг хуульд заасны ил болох хүртэл хадгалах үүрэгтэй.

.6. Нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг ил болгоогүй байхад лбал эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

.7. Энэ хуулийн 17, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, шалгалтын ıалыг Төрийн нууцын жагсаалтын тухай хуульд заасан нууцлах ıа дуусттал архивт хадгална.

.8. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан хугацаа дуусмагц тгэх ажлын материалыг зохих журмын дагуу устгах бөгөөд түүх, ааны ач холбогдол бүхий мэдээ, баримт бичиг, хэргийг тгэх байгууллагын архивт үргэлжлүүлэн хадгална.

## ТАВДУГААР БҮЛЭГ

## ГҮЙЦЭТГЭХ АЖИЛД ТАВИХ ХЯНАЛТ

**22 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын хяналт**

22.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын д Ерөнхий сайд гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай танилцан

22.2. Улсын Их Хурал, Засгийн газар шаардлагатай гэж ү өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжу гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

22.3. Гүйцэтгэх байгууллагын дарга нь гүйцэтгэх ажилд т дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

**23 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт**

23.1. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын хяна Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прок хэрэгжүүлнэ.

23.2. Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн бүртгэлд прокурор хяналт тавина.

23.3. Гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ша дор дурдсан ажиллагаа явуулахад прокурор бичгээр урьдч зөвшөөрөл өгнө.

23.3.1. утсан харилцааг хянах;

23.3.2. шуудан харилцааг хянах;

23.3.3. орон байр, барилга байгууламж, газар, тээв хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх;

23.3.4. нууцаар ажиглалт явуулах;

23.3.5. нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах.

23.4. Хойшлуулшгүй тохиолдолд тухайн гүйцэтгэх байгууллагын даргын шийдвэрээр энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажилл явуулсан бол зөвшөөрлийг 24 цагийн дотор прокуророос авна.

23.5. Прокурор гүйцэтгэх ажлын явцад авагдаж, эрүүгийн хэр нотлох баримт болгосон баримт сэлтийг хуульд заасан үндэ нөхцөл, журмын дагуу цуглуулсан эсэхэд хяналт тавина.

23.6. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагааг яв зөвшөөрөл олгосон прокурор нь уг ажиллагааны талаар г гомдлыг хянан шийдвэрлэх, шаардлагатай бол эдгээр ажиллагаан дүн болон гүйцэтгэх ажлын холбогдох материалтай танилцаж бо

23.7. Прокурорын зөвшөөрөл нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт з ажиллагаа явуулах тухай гүйцэтгэх байгууллагын шийдвэ батламжлах хэлбэрээр үйлдэгдэх бөгөөд шийдвэрт дараах зүй тодорхой тусгасан байна:

23.7.1. зохиох арга хэмжээ, түүний үндэслэл, зор... холбог

й тухай мэдээ, хянах утасны дугаар, шуудан харилцааны төрөл үзлэг хийх орон байрны хаяг, шаардагдах хугацаа, ашиглах й техник хэрэгсэл;

3.7.2. тухайн үйлдэл, үйл ажиллагааг бусад аргаар илрүүлэх, итжуулах боломжгүй буюу бэрхшээлтэй болох тухай үндэслэл 3 тайлбар;

3.7.3. уг арга хэмжээг тухайн хүнд холбогдуулж урьд зохиож ин эсэх тухай лавлагаа.

3.8. Зохиосон арга хэмжээ дуусмагц гүйцэтгэх байгууллага өөрөл олгосон прокурорт энэ тухайгаа мэдэгдэнэ.

**дугээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

хууль зөрчиж гүйцэтгэх ажил явуулсан байгууллага, албан алтанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хуцлага хүлээлгэнэ.

ОНГОЛ УЛСЫН ИХ
УРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

оны 1 дүгээр Улаанбаатар
22-ны өдөр хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 256 дугаар зүйлийн гарчиг болон хэсгийн "насанд хүрээгүй хүнд", мөн зүйлийн 3 дахь хэсгийн нд хүрээгүй хүмүүст хүч хэрэглэх, эсхүл" гэснийг хассугай.

ОНГОЛ УЛСЫН ИХ
УРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

## САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, үнэлж явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчил журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль тогтоомж**

2.1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль тогтоомж Эрүүгийн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан х тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд заас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дур утгаар ойлгоно:

3.1.1."садар самууныг сурталчлах" гэж бэлгийн дур хүслийг ө зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг ил хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон б хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг;

3.1.2."садар самуун явдал" гэж биеэ үнэлж явалдах, түүнд бу уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн с самууныг сурталчлахыг;

3.1.3."эротик" гэж гоо сайхны таашаал төрүүлэх зорилгоор х нүцгэн биеийг урлаг, уран сайхны хэлбэрээр үзүүлэхийг.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Садар самуун явдлыг хориглох

**4 дүгээр зүйл. Биеэ үнэлж явалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулахыг хориглох**

4.1.Биеэ үнэлж явалдахыг хориглоно.

4.2. Биеэ үнэлж явалдах нөхцөлөөр хангаж, зочид буудлын өрөө, орон сууц, тусгай байр, тээврийн хэрэгслээр зориуд үйлчлэх, лахыг хориглоно.

**5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох**

1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.

2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, , дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ агоор халдалахыг хориглоно.

3. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс эг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг глоно.

**6 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг**

1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон эрүүл , хэвлэл, мэдээлэл, гэгээрлийн байгууллагууд садар самуун ын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах, бэлгэсийн варт болон дархлалын олдмол хомсдол өвчноос урьдчилан йлэх сурталчилгаа явуулах үүрэгтэй.

2. Шөнийн цэнгээний газар, зочид буудалд бэлгэвч худалдаалах г төхөөрөмжийг заавал байрлуулсан байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Эротикийн сурталчилгаа, үйлчилгээнд тавих шаардлага

**7 дугаар зүйл. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам**

1. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг аймаг, элийн Засаг даргаас тогтоосон тусгай цэгт худалдана.

2. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдахад хь зүйлийг хориглоно:

2.1. албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, лэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс, барааны удалдаа, үзвэр үйлчилгээний газар худалдах;

2.2. гар дээрээс худалдах;

2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй худалдах.

**8 дугаар зүйл. Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл**

8.1. Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих үр үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн бусад үзвэрийг үзүүлэхэд дара зүйлийг хориглоно:

8.1.1. гэгээрлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны т нутгийн захиргааны байгууллагаас тусгайлан зөвшөөрснөөс бу газарт энэ төрлийн кино, дүрс бичлэгийг үзүүлэх;

8.1.2. телевизийн нийтийн сувгаар дамжуулах;

8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.

**9 дүгээр зүйл. Эротикийн сурталчилгаанд тавих хяналт**

9.1. Эротик чиглэлийн хэвлэл, ном зохиол, кино, дүрс бич тавих хяналтыг эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гэгээрлийн бо хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуу дэргэдэх зөвлөл /цаашид "Зөвлөл" гэнэ/ хэрэгжүүлнэ.

9.2. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн га батална.

9.3. Эротик хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгийг зөв Зөвлөлөөр хянуулсны дараа хэвлэн нийтлэх, нийтэд үзүүлэх зөвшөөрнө.

**10 дугаар зүйл. Эротик тоглолт явуулах**

10.1. Эротик тоглолтыг зөвхөн шөнийн цэнгээний газарт явү болно.

10.2. 18 насанд хүрээгүй хүнийг шөнийн цэнгээний га оруулах болон эротик тоглолтод оролцуулахыг хориглоно.

**11 дүгээр зүйл. Татварын хувь, хэмжээ**

11.1. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан б төлбөртэй ашиглуулсан, эротик тоглолт явуулсан үйлчилгээ орлогод Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 -т заасан хувь, хэмжээ татвар ногдуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

**12 дугаар зүйл. Биеэ үнэлж явалдсан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн тоо бүртгэл**

12.1. Биеэ үнэлж явалдсан зөрчилд захиргааны шийтгэл хүлээ этгээдийн талаархи тоо бүртгэлийг цагдаагийн байгууллага эр хөтөлнө.

12.2. Цагдаагийн байгууллага биеэ үнэлж явалдсан этгээд гаргасан зөрчлийн талаар түүний ажиллаж, суралцаж байгаа газ

газад, ажил, сургуулийн буюу гэрийн тодорхой хаяггүй бол и сууга газрын харьяа сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргад нийтэд албан ёсоор мэдээлнэ.

дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

.1. Энэ хуулийн 5.1, 5.2-т заасан зөрчлийг нэг жилийн дотор и гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага лгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

.2.1. энэ хуулийн 4.1-ийг зөрчсөн бол биеэ үнэлж олсон ыг нь хурааж, 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

2.2. энэ хуулийн 4.2-ыг зөрчсөн гэм буруутай иргэнийг -50000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 7-15 хоногийн гаар баривчлах, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 л төгрөгөөр торгох буюу биеэ үнэлэх газрын зориулалтаар асан зочид буудал, цэнгээний газрыг хаах, биеэ үнэлж ахад тээврийн хэрэгслээр зориуд үйлчилсэн бол тээврийн слийг хураах;

2.3. энэ хуулийн 5.1-ийг зөрчсөн бол садар самууныг үйлж олсон орлогыг хурааж, гэм буруутай албан тушаалтныг -60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 0-150000 хүртэл төгрөгөөр торгох, энэ зөрчлийг нэг жилийн давтан гаргасан бол хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл агаар зогсоох;

2.4. энэ хуулийн 5.2-ыг зөрчсөн бол садар самууны глоатой эд зүйлсийг хурааж, гэм буруутай иргэнийг 40000-50000 л төгрөгөөр торгох;

2.5. энэ хуулийн 5.3-ыг зөрчсөн бол хууль бусаар нэвтрүүлсэн нэвтрүүлэхийг завдсан зүйлсийг хурааж, гэм буруутай иргэнийг -50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 7-15 хоногийн хугацаагаар члах, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 хүртэл өөр торгох;

6. энэ хуулийн 6.2-ыг зөрчсөн гэм буруутай иргэн, албан лтныг 30000-50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгжийг )-150000 хүртэл төгрөгөөр торгох.

2.7. энэ хуулийн 7 дугаар зүйл, 8.1.3-ыг зөрчсөн гэм буруутай ийг 25000-30000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг )-250000 хүртэл төгрөгөөр торгох;

2.8. энэ хуулийн 8.1.1, 8.1.2-ыг зөрчсөн бол эротик кино, дүрс гийг үзүүлж олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг )-200000 хүртэл төгрөгөөр торгох;

13.2.9. энэ хуулийн 9. 3-ыг зөрчсөн бол хууль бусаар ол орлого, Зөвлөлөөр хянуулаагүй эротик хэвлэл, ном зохиол, ка дүрс бичлэгийг хурааж, гэм буруутай иргэнийг 30000-50000 хүр төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 хүр төгрөгөөр торгох;

13.2.10. энэ хуулийн 10.1, 10.2-ыг зөрчсөн гэм буруутай иргэн 30000-50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150( 200000 хүртэл төгрөгөөр торгох;

13.3. Эрх бүхий албан тушаалтан дараахь харьяаллаар энэ хуул 13.2-т заасан захиргааны шийтгэлийг ногдуулна:

13.3.1. шүүгч энэ хуулийн 13.2-т заасан баривчлах, тээвр хэрэгслийг хураах шийтгэлийг;

13.3.2. цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хуулийн 4.2, 5.1, 5.2, 6.2, 7 дугаар зүйл, 8.1.2, 8.1.3, 9.1, 10 дугаар зүйлийг зөрчсөнд холбогдох шийтгэлийг;

13.3.3. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуул 8.1 дэх заалтыг зөрчсөнд холбогдох шийтгэлийг;

13.3.4. гаалийн байцаагч энэ хуулийн 5.3-ыг зөрчсөн этгэ ногдуулах шийтгэлийг.

**14 дүгээр зүйл. Хуулийн заалтыг дагаж мөрдөх журмын тухай**

14.1. Энэ хуулийн 6.2-т заасныг 1998 оны 7 дугаар сарын 1- өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаат хот

## ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 126 ду зүйлийн "Эрүүгийн хуулийн ... 107" гэсний дараа "111 ду зүйлийн 1 дэх хэсэг", "247" гэсний дараа "256," гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

3 оны 1 дугээр ин 22-ны едер | Улаанбаатар хот

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

**дүгээр зүйл. Хуулийн зорилт**

.1. Энэ хуулийн зорилт нь байгаль орчныг хамгаалах, экологийн эл алдагдахаас сэргийлэх, байгалийн баялгийн ашиглалтыг цуулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, ийг хэрэгжүүлэх эсэх[1] талаар шийдвэр гаргахтай холбогдсон лцааг зохицуулахад оршино.

**дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж**

.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль оомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах ı хууль[2], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль юмжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан р ойлгоно:

1.1. "байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ" гэж иргэн, аж ı нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн ı эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой эллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга ээ тогтоохыг;

1.2. "төсөл" гэж шинээр байгуулах болон одоо ажиллаж буй зэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, тех болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах жиллагааг;

1.3. "төсөл хэрэгжүүлэгч" гэж тухайн төслийг хариуцагч йн этгээдийг;

---

[1] нгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 1 дугээрт нийтлэгдсэн

[2] аль орчныг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" үлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн

3.1.4. "ослын үнэлгээ" гэж төслийг хэрэгжүүлэх явцад байгал гэнэтийн үзэгдэл, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч болзоц ослоос сэргийлэх, ослын үр дагаврыг тодорхойлж, түүнийг багас арилгах арга хэмжээ тогтоохыг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

**4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ**

4.1. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлд үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргө болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төс байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

4.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө хийгдсэн байна.

4.3. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууль байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн эсэхэд ту орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, ай нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ту Тэргүүлэгчид хяналт тавина.

4.4.Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн товч тодорхойлолт, тех эдийн засгийн үндэслэл, ажлын зураг болон холбогдох бусад б баримтыг бүрдүүлэн төслийн энэ хуулийн хавсралтад за ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирга төв байгууллага, эсхүл нутгийн захиргааны байгууллагад хүргү байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

4.5. Төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэ хийх аргачилсан зааврыг байгаль орчны асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага батална.

4.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг шин ажлын 12 өдөрт багтаан хийж дараах дүгнэлт гаргана:

4.6.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийлгэлгүйгээр төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;

4.6.2. төслийг тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжү боломжтой гэж үзэх;

4.6.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийлгэх.

4.7. Шинжээчийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан бай орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллі шийдвэрээр томилно.

**5 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ**

5.1. Энэ хуулийн 4.6.3-д заасан дүгнэлтэд байгаль орчинд нө лөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээг тодорхой за

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу эрх авсан аж ахуйн нэгж этгээд.
3. Эрх бүхий аж ахуйн нэгж нь нарийвчилсан үнэлгээний тайлан на.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нд дараах асуудлыг тусгана:
4.1. байгаль орчны төлөв байдлын үндсэн үзүүлэлтүүд;
4.2. төслийн оновчтой хувилбар;
4.3. төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, түүнийг гах, арилгах арга хэмжээний зөвлөмж;
4.4. төслийн сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагаврыг осон тооцоо, судалгаа;
4.5. ослын үнэлгээ;
4.6. байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;
4.7. орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр;
4.8. төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн санал;
4.9. төслийн онцлогтой уялдсан бусад асуудал.
5.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нгийн төсөлд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авна.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ эх, дүгнэлт, шийдвэр гаргуулахад шаардагдах зардлыг хоёр байгуулсан гэрээний үндсэн дээр шийдвэрлэнэ.
7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ н аж ахуйн нэгж нь үнэлгээний ажилд оролцсон мэргэжилтийн судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд ль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг н хувь бэлтгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн гааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэгчид тус бүр нэг хувийг нэг хувийг өөртөө үлдээх бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй .

**дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр**

1. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны явц, үр дүнг , байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт, мжийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчныг алах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй на.
1.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд юх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, х арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах е зардлыг тусгасан байна.
1.2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрлэлийн үйл агааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг жүүлэх арга, хэлбэр, хугацааг тодорхойлон тусгана.

6.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинж гээний хөтөлбөрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөн үнэлгээ хийсэн байгууллага батална.

6.3. Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө биелэлтийг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэл хийсэн байгууллагад жил тутам тайлагнаж байна.

6.4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-ш жилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд тухайн орон нутгийн бай орчны хяналтын улсын байцаагч, аймаг, нийслэл, сум, дүүрг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид хяналт тавин

**7 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлт**

7.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэл хийсэн аж ахуйн нэгж нь үнэлгээний ажлын тайланг холбогдох бу бичиг баримтын хамт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерө үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

7.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтааж дүг гаргана.

7.3. Нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн нэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захир ны төв байгууллага уг төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийд лэнэ.

**8 дугаар зүйл. Хянан магадалгаа**

8.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн н байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, бай орчинд хохирол учруулсан бол үнэлгээний үнэн зөв эсэхэд х магадалгаа хийнэ.

8.2. Хянан магадалгаа хийх ажлын хэсгийг байгаль орчны асу эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэж хүмүүсийг оролцуулан тухай бүр томилон ажиллуулна.

8.3. Хянан магадалгаа хийхэд шаардагдах зардлыг байгаль ор асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хари бөгөөд хэн буруутай этгээдээс уг зардлыг нэхэмжлэн авна.

8.4. Хянан магадалгаа хийхэд шаардагдах баримт бичгийг бай орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн аж а нэгж болон төсөл хэрэгжүүлэгч саадгүй бүрдүүлж өгнө.

8.5.Хянан магадалгаа хийх хугацааг байгаль орчны асу эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох талуу тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

8.6. Хянан магадалгаагаар байгаль орчинд нөлөөлөх байд нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдвол уг ажлыг з шаардлагын түвшинд хүртэл дахин хийлгэж, энэ хугацаанд б төсөлд нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг нь байгаль орчны асу эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэ түдгэлзүүлж болно.

8.7. Хянан магадалгаагаар нэмэлт ажил хийх шаардлагатай нь тоогдвол холбогдох зардлыг анх нарийвчилсан үнэлгээ хийсэн аж йн нэгж хариуцна.

**9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох**

9.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ к эрх авахыг хүссэн Монгол Улсын аж ахуйн нэгж нь энэ тухай эдлөө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв гууллагад гаргана.

9.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ к эрх авахыг хүссэн өргөдөлд дараахь баримт бичгийг гаргасан байна:

9.2.1. аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тухай танилцуулга;

9.2.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ к мэргэжлийн хүмүүсийн тодорхойлолт.

9.3. Энэ зүйлийн 9.1-д заасны дагуу өргөдөл гаргасан аж ахуйн кийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ к чадварыг Комисс ажлын 26 өдөрт багтаан шалгаж, дүгнэлт ана.

9.4. Комиссыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн иргааны төв байгууллагын шийдвэрээр томилон ажиллуулна.

9.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчинд нөлөөлөх байдлын йвчилсан үнэлгээ хийхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

9.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ аж ахуйн нэгжид Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн гаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг үндэслэн эрх олгоно.

9.7. Аж ахуйн нэгжид байгаль орчинд нөлөөлөх байдлын йвчилсан үнэлгээ хийх эрхийг энэ зүйлийн 9.4-т заасны дагуу илсон Комиссын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал лсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хоёр йн хугацаатай олгоно.

9.8. Аж ахуйн нэгж нь байгаль орчинд нөлөөлөх байдлын йвчилсан үнэлгээ хийх эрхийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулахыг хүссэн өргөдлөө хийж гүйцэтгэсэн ажлын тайлангийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв уулагад хүргэсэн байна.

9.9. Өргөдөл болон ажлын тайланг Комисс хянан үзэж, байгаль нд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн цааг сунгах эсэх талаар дүгнэлт гаргана.

9.10. Комиссын дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжийн байгаль нд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг байгаль ы асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэрээр нэг удаад 2 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

9.11. Эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчинд нөлөөлөх лын нарийвчилсан үнэлгээг хоёр удаа буруу хийсэн нь хянан

магадалгаагаар нотлогдсон бол уул үнэлгээ хийх эрхийг нь эрхийг олгосон байгууллага хүчингүй болгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд оролцогчдын эрх үүрэг

**10 дугаар зүйл. Төсөл хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг**

10.1. Төсөл хэрэгжүүлэгч дараахь эрх эдэлнэ:

10.1.1 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийл хүсэлтээ эрх бүхий аж ахуйн нэгжид тавих;

10.1.2. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэл хийлгэх аж ахуйн нэгжийг сонгох;

10.1.3. тухайн төслийн техник, технологи, бизнесийн холбоо зарим мэдээллийг нууцлахыг байгаль орчинд нөлөөлөх байд нарийвчилсан үнэлгээ хийлгэх аж ахуйн нэгжээс шаардах.

10.2. Төсөл хэрэгжүүлэгч дараахь үүрэг хүлээнэ:

10.2.1. төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ холбогдол бүхий бичиг баримтыг эрх бүхий байгууллага, ал тушаалтанд гаргаж өгөх;

10.2.2. байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-ш жилгээний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж, биелэлтийг тогтоо хугацаанд тайлагнах.

**11 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн эрх, үүрэг**

11.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийх эрх бүхий аж ахуйн нэгж дараахь эрх эдэлнэ:

11.1.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аж шаардлагатай баримт бичгийг төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулж ав

11.1.2. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажлын байранд саа нэвтрэн орох, сорьц дээж авах.

11.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийх эрх бүхий аж ахуйн нэгж дараахь үүрэг хүлээнэ:

11.2.1.урьд хийгдсэн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг ашигл

11.2.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчи үнэлгээний тайланд хийсэн шүүмжийн дүгнэлтийн дагуу нэм өөрчлөлт оруулах;

11.2.3.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчи үнэлгээний үр дүнгийн үнэн зөвийг хариуцах;

11.2.4.тухайн төслийн техник, технологи, бизнесийн холбо мэдээллийн нууцыг хадгалах.

11.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь үнэлгээний ажилтай холбогд эрсдэлийг даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## БУСАД ЗҮЙЛ

**2 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх**

2.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, рлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага элгэнэ.

2.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага элгэхээргүй бол шүүгч, эсхүл эрх бүхий байгаль орчны хяналтын ин байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

2.2.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, зохих дээр гаргуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус н орлогыг улсын орлого болгож сум, дүүргийн төсвийн дансанд хүүлэх;

2.2.2. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан здлагыг биелүүлээгүй бол зөрчлийг арилгах хүртэл үйл шагааг нь түдгэлзүүлэн зогсоож, гэм буруутай албан тушаалтныг 0 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 төгрөгөөр ох;

2.2.3. байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-килгээний хөтөлбөргүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөө, лбөрийг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, огдох газарт тайлагнаагүй бол гэм буруутай албан тушаалтныг 0-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 эгөөр торгох.

**3 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх**

3.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэлгүйгээр йг хэрэгжүүлснээс буюу үнэлгээгээр тавигдсан шаардлагыг сэний улмаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд лсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ эрх бүхий аж ахуйн нэгж нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нотлогдвол үнэлгээ хийлгэсэн зардал болон учирсан шууд олыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

**ОНГОЛ УЛСЫН ИХ**
**УРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

# БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ХАВСРАЛ1

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилал**

| Нэр | Хариуцан гүйцэтгэгч | |
|---|---|---|
| | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Аймаг, нийслэлийн даргын Тамгын газар |
| 1. Уул уурхайн төсөл | Бүх төрлийн ашигт малтмал олборлолт | Тухайн нутаг дэвсгэ хэмжээнд ашиглагдах гээмэл тархацтай а малтмал олборлолт |
| 2. Хүнд үйлдвэрийн төсөл | Бүх төрөл | - |
| 3. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн төсөл | Улсын чанартай томоохон үйлдвэр | Орон нутгийн жижиг, үйлдвэр |
| 4. Хөдөө аж ахуйн төсөл | -усан сан<br>-усжуулалтын систем<br>-атар газар эзэмших үйл ажиллагаа | Бусад үйлдвэрлэл, үй гээ эрхлэх үйл ажилла |
| 5. Дэд бүтцийн хөгжлийн төсөл | -1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц<br>-35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам<br>-дулааны шугам<br>-усан цахилгаан станц<br>-төмөр зам<br>-нисэх буудал<br>-улс, хот хоорондын зам<br>-улс, хот хоорондын холбоо | -1 мвт хүртэл хүчин бүхий эрчим хүчний ст<br>-35 кв хүртэл хүч цахилгаан дамжуулах шугам<br>-тухайн нутаг дэвсг хэмжээнд дамжуулах дулааны шугам<br>-орон нутгийн ча зам, холбоо |
| 6. Үйлчилгээний салбарын төсөл | -5О ор хоногоос дээш хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар<br>-аялал,жуулчлал эрхлэх үйл ажиллагаа | -5О хүртэл ор хон хүчин чадалтай буудал, амралт, су бусад үйлчилгээний га |

| | | |
|---|---|---|
| усад төсөл<br>г байгуулалт<br>глан хамгаалах<br>он иргэний хам-<br>іалтын зориулал-<br>э хэрэгжүүлэх<br>эл<br>ин хангамжийн<br>стем<br>эрлэх байгууламж<br>хаягдлын<br>эсэн цэг г.м | -10000-аас дээш хүн амтай төв, суурин газрын усан хан-гамж, цэвэрлэх бай-гууламж, хог хаягдл-ын нэгдсэн цэг<br>-батлан хамгаалах болон иргэний хам-гаалалтын зориу-лалтаар байгуулах улсын чанартай барилга байгууламж | -10000-аас доош хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгуу-ламж, хог хаягдлын нэгд-сэн цэг<br>-батлан хамгаалах болон ир-гэний хамгаалалтын чиглэ-лээр байгуулах орон нут-гийн чанартай барилга байгууламж |
| нологийн төрөл<br>ийн төсөл | -улсын чанартай томоохон загасны аж ахуй<br>-ан амьтан, ургамал нутагшуулах, ашиглах болон бусад үйл ажиллагаа | -ан агнуурын болон ойн аж ахуй, ангийн отог<br>-тухайн дэвсгэр нутгийн хүн амын хэрэгцээг хангах зориулалттай загасны аж ахуй |
| Химийн хортой эн цацраг идэвхт ис, аюултай хаягд-төсөл | Химийн хортой бо-лон цацраг идэвхт бодис, аюултай хаягдлыг боловс-руулах, ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа | |
| Тусгай хамгаа-тай газар нутагт лах үйл ллагаа | Улсын тусгай хам-гаалалттай газрын хилийн цэсэд явуу-лах үйл ажиллагаа | орон нутгийн хамгаа-лалтад авсан газар нутагт явуулах үйл ажиллагаа |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

оны 1 дүгээр<br>
і 22-ны өдөр

Улаанбаатар<br>
хот

### БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**дүгээр зүйл**. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар йн 4 дэх хэсгийн "байгаль орчинд нөлөөлөх байдлын" гэсний "нарийвчилсан" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл**. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9 дүг зүйлийн 2 дахь хэсгийг "Байгаль орчинд нөлөөлөх байдл үнэлгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна" гэж өөрчл найруулсугай.

**3 дугаар зүйл**. 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн ", хотолб гэрээг" гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл**. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дүг зүйлийн 6, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсс тооцсугай.

**5 дугаар зүйл**. Энэ хуулийг Байгаль орчинд нөлөөлөх байдл үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн да мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаат хот

## АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд дурдсан агуулгатай 5 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 19 дүг зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалтыг тус тус нэмсугай:

1) 5 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг:

"8. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй ахуйн нэгж уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

9. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг хүүхдийн цэцэр сургууль, эмнэлэг, оюутан, сурагчдын хичээлийн болон нийт байр, орон сууц, түүний орц, хонгилд явуулахыг хориглоно."

2) 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"12/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 7 ду зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол согтууруулах ун үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, уг ахуйн нэгжид 2 жилийн хугацаанд дахин зөвшөөрөл олгохгүй."

**2 дугаар зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуул 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "зөвшөөрлийг" гэсний да "мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэсл

заар зүйлийн 1 дэх хэсгийн "бусад газарт" гэсний дараа "болон дээрээс", 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын гох" гэсний дараа "буюу 7-14 хоногийн хугацаагаар баривчлах", үгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 4 дэх заалтын "5 дугаар йн 1,2,3,4,5" гэсний дараа "8, 9", мөн зүйлийн 4 дэх заалтын угаар зүйлийн 2" гэсний дараа ", 7 дугаар зүйлийн 5" гэж тус эмсугэй.

**дугаар зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 р зүйлийн 1 дэх хэсгийн "Засгийн газар олгоно" гэснийг ийн газар олгох буюу хүчингүй болгоно.", "түүхий эдийг" ийг "түүхий эд, үйлдвэрийн байршлыг" гэж тус тус өөрчилсүгэй.

**дүгээр зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн үгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "3 дахь хэсгийн заалт," гэснийг хассугай.

ОНГОЛ УЛСЫН ИХ
УРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

оны 1 дүгээр Улаанбаатар
22-ны өдөр хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлийн 1, 2 дахь ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл одсон, эсхүл согтууруулах ундааны зүйл уусан эсэхийг зохих ын дагуу шалгуулахаас зайлсхийсэн зөрчилд захиргааны арга э авагдсаны дараа дахин тийм үйлдэл хийсэн бол тээврийн сэл жолоодох эрхийг хасаж гурван зуун тавин мянгаас дөрвөн тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтууруулах ны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд гааны арга хэмжээ авагдсаны дараа дахин тийм үйлдэл хийсэн урван жил хүртэл хугацаагаар хорих буюу эсхүл дөрвөн зуун ас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ"

ОНГОЛ УЛСЫН ИХ
ГРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 ду зүйлийн 2 дахь хэсгийн "5000-50000" гэснийг "25000-50000" өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 ду зүйлийн 1 дэх хэсгийн "10000-50000 төгрөгөөр торгох, эс гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуульд дор дурдсан агуул $10^1$ дүгээр зүйл нэмсүгэй:

"$10^1$ дүгээр зүйл. Төрийн тусгай албан хаагчийг захиргааны санаачилгаар халах

Албан байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах, түүн дүрэмт хувцастай үедээ согтууруулах ундаа уусан нь төрийн т албан хаагчийг захиргааны санаачилгаар халах үндэслэл болно."

**2 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүй 1 дэх хэсгийн "албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн" г дараа ", эсхүл албан байранд болон албан үүргээ гүйцэтгэж үедээ согтууруулах ундаа уусан" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДО

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | |
|---|---|
| 3 оны 1 дүгээр<br>ын 23-ны өдөр | Улаанбаатар<br>хот |

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**l дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар ийн 3 дахь хэсгийн "Тэс" гэсний дараа "Бургастай, Гашуун айт" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 3 хэсгийн "Хандгайт" гэснийг "Боршоо" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 1998 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс н дагаж мөрдөнө.

**ЮНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 08 | Улаанбаа[тар] хот

**Хуулийн төсөл буцаах ту[хай]**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүг[ээр] зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1997 оны 10 дугаар сарын 22-[ны] өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Стандартчилал, чанар баталгаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах туха[й]" "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчл[өлт] оруулах тухай хууль"-ийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийх як[ ] хууль санаачлагч болон Эдийн засгийн байнгын хорооны гарга[сан] саналыг үндэслэж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүд[ийн] олонхийн саналаар эдгээр хуулийн төслүүдийг санаачлагчид буцаасугай.

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОР[Ж]**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 09 | Улаанба[атар] хот

**Ажлын хэсэг байгуулах ту[хай]**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 38 ду[гаар] зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хура[л] ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нийслэлийг XXI зуунд Хархоринд шилжү[үлэх] шаардлага, хугацаа, боломж, нөхцөлийг судалж, дүгнэлт га[ргах] үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсу[гай]:

Ажлын хэсгийн ахлагч:

1. Р.Бадамдамдин -Улсын Их Хурлын гишү[үн]

гүүлээ:

| | |
|---|---|
| 2. Батж.Батбаяр | -Улсын Их Хурлын гишүүн |
| 3. Э. Бат-Үүл | -Улсын Их Хурлын гишүүн |
| 4. Л. Болд | -Улсын Их Хурлын гишүүн |
| 5. О. Дашбалбар | -Улсын Их Хурлын гишүүн |
| 6. Д. Лүндээжанцан | -Улсын Их Хурлын гишүүн |
| 7. М. Зэнээ | -Улсын Их Хурлын гишүүн |
| 8. С. Ламбаа | -Улсын Их Хурлын гишүүн |
| 9. Т. Султан | -Улсын Их Хурлын гишүүн |
| 10. С. Төмөр | -Улсын Их Хурлын гишүүн |
| 11. Д. Энхтайван | -Улсын Их Хурлын гишүүн |
| 12. Б. Даш-Ёндон | -Ерөнхийлөгчийн зөвлөх |
| 13. Дэд бүтцийн хөгжлийн сайд | |
| 14. Гэгээрлийн сайд | |
| 15. Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга | |
| 16. Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга | |
| 17. ШУА-ийн ерөнхийлөгч | |
| 18. МУИС-ийн захирал | |

2. Дээрх асуудлыг судлан гаргасан дүгнэлтээ 1998 онд багтаан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг /Б.Бадамдамдин/-т даалгасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

оны 1 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

**Төрийн хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай**

Төрийн хянан шалгах хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд "Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Жил бүрийн улсын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн байдал, төсвийн тухай Төрийн хянан шалгах хорооноос Улсын Их Хуралд ирүүлсэн санал, дүгнэлтийн талаар Төрийн хянан шалгах хорооны даргын мэдээллийг хэлэлцэж байхыг Төрийн байгуулалт болон Төсвийн байнгын хороонд үүрэг болгосугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/ Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн тухай хуулийг шинэчлэн боловсруулж 1998 онд багтаан Улсын Их Хуралд оруулах;

2/ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Удирдлагын хөгжлийн хөтөлбөрт төрийн хянан шалгах байгууллагуудыг хамруулан хянан байцаагчдыг давтан сургах.

3. Аймаг, нийслэлийн хянан шалгах хороодын ажлын байдал, дүнг улирал тутам шалгаж, тайланг нь хэлэлцэж, удирдамж, чиглэл өгч байхын зэрэгцээ хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, ажилд нэхцэл бололцоогоор хангах зэрэг хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчдэд зөвлөмж болгосугай.

4. Төрийн хянан шалгах ажлын арга барил, үр нөлөөг Улсын Их Хурлаас гаргасан дүгнэлт, шаардлага, эрх зүйн акт, гаргасан шийдвэрээ биелүүлэх, иргэд, байгууллагын гомдол, мэдээлэлд шуурхай шалгаж барагдуулах, илэрсэн дутагдал, зөрчлийн улмаас гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх талд онцгой анхаарч ажиллаж, үр дүнг нь жил бүр Улсын Их Хуралд танилцуулж байхыг Төрийн хянан шалгах хороо /Л.Жавзмаа/-д даалгасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот |

**Ж. Батмөнх агсны ар гэрийн ахуй хангамжийн ту**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төр, засгийн тэргүүн агсан Ж. Батмөнхийн эхнэр Авирмэдийн Дарьмаагийн ахуй хангамжид зориулж өөрийн

амьдарч байгаа орон сууцны ашиглалттай холбогдсон засвараас ад бүх зардлыг төрөөс хариуцаж, сар тутам 50 мянган төгрөгийн гэмж олгож байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хүүжүүлэх зардлыг төсвийн зохих хэсгээс жил бүр гаргаж байхыг гийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.
3. Энэ тогтоолыг 1998 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж ıсугай.

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

7 оны 1 дүгээр Улаанбаатар
ын 15-ны өдөр Дугаар 12 хот

**Тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 4О дүгээр ийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТООХ нь:
Улсын Их Хурлын гишүүн Шаравжамцын Батбаяр, имидцэрэн, С.Лямбаа, Ж.Отгонбаяр, Д.Батнасан, Д.Бохышарга, ргбадрах, Д.Энхтайван нарын өргөн мэдүүлсэн "Автомашины шинэчлэлтийн тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг лдаанаар хэлэлцэж, Эрүүлийг хамгаалах, цагдаа, батлан аалах, хилийн цэргийн байгууллагуудын автомашины паркийг эчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Засгийн газарт өөрт нь гах нь зүйтэй гэсэн Төсвийн болон Төрийн байгууллагын ггын хорооны саналыг үндэслэн хуралдаанд оролцсон гишүүдийн ıхийн саналаар уг тогтоолын төслийг санаачлагчид нь буцаасугай.

**АРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

**"Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай " тогтоолд нэмэ оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

" Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төри албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаал зэрэглэл тогтоох тухай" Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сар 3-ны өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төри өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаал зэрэг зиндаатай адилтгах албан тушаалын зэрэглэл"-и "ТӨ-VA"-ийн тусгай албан тушаалд "Үндэсний статистики газрын дарга", "ТӨ-VIA"-ийн тусгай албан тушаалд "Үндэсн статистикийн газрын дэд дарга" гэж тус тус нэмсүгэй.

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаата хот

**"Төрийн захиргааны албан тушаалын зэ дэв, түүний нэмэгдэл олгох журам батл тухай" тогтоолд нэмэлт оруулах туха**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэг олгох журам батлах тухай "Улсын Их Хурлын 1995 оны 10 дуг сарын 17-ны өдрийн 73 дугаар тогтоолын хавсралтаар батал "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэг олгох журам"-ын 3 дахь заалтын "Үнэт цаасны хорооны дар гэсний дараа "Үндэсний статистикийн газрын дарга" гэж нэмсүгэ

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 8 оны 1 дүгээр<br>сын 16-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаатар<br>хот |

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр ийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Д.Бохьшаргаас 1998 оны 1 дүгээр ын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн "Монгол Улсын Их Хурлын тухай ыд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг хэлэлцээд хаврын ганыг нээх хугацааг урагшлуулах шаардлагагүй гэж үзэж, лдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хуулийн төслийг ачлагчид нь буцаасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| оны 1 дүгээр<br>ын 22-ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар<br>хот |

**Үнэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлөх тухай**

Үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, ийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дахь заалт болон Монголбанкны Ерөнхийлөгчийн саналыг элсэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Данзанбалжирын Энхжаргалыг Үнэт цаасны хорооны гишүүнээс өлөөсүгэй.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

**Үнэт цаасны хорооны гишүүнээр томилох тухай**

Үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг бол Монголбанкны Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн Монгол Улс Их Хурлаас ТОГТООХ нь:

Гэнингийн Төмөрхуягийг Үнэт цаасны хорооны гишүүнэ томилсугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр | Дугаар 19 | Улаанбаат хот

**Ерөнхийлөгчийн хоригийн ту**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дуг зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хура ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс "Гүйцэтгэх ажлын тухай" хуу бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй г үзсүгэй.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

98 оны 1 дүгээр
ын 22-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон йгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ай хуулиудыг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч эгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/ одоогийн хэрэгжүүлж буй төсөлд 2000 онд багтаан нөхөн элгээ хийлгэх арга хэмжээ авах;

2/ Засгийн газар, яамдын байгаль орчинд нөлөөлөх байдлын элгээтэй холбогдсон шийдвэрийг Байгаль орчинд нөлөөлөх длын үнэлгээний тухай хуульд нийцүүлэх.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

8 оны 1 дүгээр
ын 22-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

**Казиногийн тухай болон Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт, оруулах тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Казиногийн тухай болон Онцгой албан татварын хуульд нэмэлт, өлөлт оруулах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол ын Их Хурлаас ТОГТООХ нь:

. Казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг олгох тендер ахдаа дараахь зүйлүүдийг тусгахыг Засгийн газар/М.Энхсайхан/-т гасугай:

/ казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрөл авсан аж ахуйн ашгийнхаа хэдэн хувийг дахин хөрөнгө оруулалтад оруулахаар

төлөвлөж байгаа;

2/тахир дутуу иргэд, өнчин хүүхдүүдийн асрамжийн газрууд болон нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх тусламжийн хэмжээ.

2. Казиногийн хуультай уялдуулж Эрүүгийн хууль, Захиргаан хариуцлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан 1998 оны хавр чуулганаар хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүл Засгийн газрын зохих тогтоол, шийдвэртээ зохих өөрчлөлт оруулах Засгийн газар/М.Энхсайхан/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эди засгийн байнгын хороо/Да.Ганболд/-нд даалгасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 22 | Улаанбаат хот

**Ю.Цэдэнбал агсны гэр бүл ахуй хангамжийн тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төр, засгийн тэргүүн агсан Ю.Цэдэнбал эхнэр Цэдэнбал-Филатова Анастасия Ивановнагийн ахуй хангамж зориулж өөрийнх нь амьдарч байгаа орон сууцны ашиглалт холбогдсон, засвараас бусад бүх зардлыг төрөөс хариуцаж, сар ту 50 мянган төгрөгийн тэтгэмж олгож байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг санхүүжүү зардлыг төсвийн зохих хэсгээс жил бүр гаргаж байхыг Засгийн га /М.Энхсайхан/-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 1998 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эх дагаж мөрдсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

8 оны 1 дүгээр ын 23-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

**Тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 4О дүгээр лийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ГТООХ нь:

1. 1997 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Засгийн газраас өргөн түүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Улсын Их лын тогтоолын төслийг хэлэлцээд төрийн өмчийг орон нутгийн ил шилжүүлэх тухай ойлголт, үзэл баримтлал тодорхой биш гаа, орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх длыг төсөлд дутуу анхаарсан зэрэг үндэслэлээр хуралдаанд лсон гишүүдийн олонхийн саналаар тогтоолын төслийг зачлагчид нь буцаасугай.

2. Холбогдох тогтоолын төслийг дахин боловсруулж, 1998 оны 3 ар сарын 15-ны дотор багтаан Улсын Их Хуралд өргөн үүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

3 оны 1 дүгээр ын 23-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

**1998 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 1998 оны хаврын ээлжит чуулганаар ахь асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай:

**Нэг. Төрийн байгуулалтын чиглэлээр:**

/а. Олон түмний мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөл
. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл

в. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл

2/ Сонгуулийн тухай хуулийн төсөл

3/ Улс төрийн намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруул тухай хуулийн төсөл

4/ Лоббийн тухай хуулийн төсөл

5/ Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн байдлын тух журмын төсөл /тогтоолын төсөл/

6/ Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагь тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

### Хоёр. Нийгмийн бодлогын чиглэлээр

7/ Гэр бүлийн тухай хуулийн төсөл

8/ Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуули төсөл

9/ Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл

10/ Эмийн тухай хуулийн төсөл

11/ Ариун цэврийн тухай хуулийн төсөл

12/ Эрүүл мэндийн үндэсний бодлого

13/Нийгмийн салбарын хувьчлалын тухай хуулийн төсөл

14/Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл

15/Технологи дамжуулах тухай хуулийн төсөл

16/Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодло

17/Залуучуудын тухай хуулийн төсөл

### Гурав. Эдийн засаг, төсвийн асуудлаар

18/ Улсын төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тух хуулийн төсөл

19/ Улсын төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

20/ Газар хувьчлах тухай хуулийн төсөл

21/ Иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл

22/ Орон сууцны тухай ерөнхий хуулийн төсөл

23/ Барилгын тухай хуулийн төсөл

24/ Хот байгуулалтын тухай хуулийн төсөл

25/ Хувьцаат компанийн тухай хуулийн төсөл

26/ Санхүүгийн түрээсийн тухай хуулийн төсөл

27/ Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хуульд нэмэ өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

28/ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл

29/ а.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

б. Монгол Улсын хүн амын нутагшлын байршил, хөгжли ерөнхий төсөл

30/ Төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай асуудал /холбогдох хууль тогтоомжийн төсөл/

**Дөрөв. Аюулгүй байдал, батлан хамгаалахын чиглэлээр:**

31/ Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ай хуулийн төсөл
32/ Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн өл
33/ "Монгол Улсын цэргийн номлолын үндэс" -д нэмэлт, өчлөлт оруулах тухай
34/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өчлөлт оруулах тухай хуулийн төсөл

**Тав. Хууль зүйн чиглэлээр:**

35/ Эрүүгийн хуулийн шинэчилсэн төсөл
36/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл
37/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн өруулга
38/ Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай лийн төсөл
39/ Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай лийн төсөл
40/ Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд элт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

**Зургаа. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн асуудлаар:**

41/Газрын бүртгэл, зураглалын тухай хуулийн төсөл
**42.Бусад**
2. Засгийн газраас өргөн мэдүүлж, хаврын чуулганаар хэлэлцэхээр йлдвэрлэсэн хуулийн төслүүдийг 1998 оны 3 дугаар сарын ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар Энхсайхан/-т даалгасугай.
3. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Байнгын хороо, гтаны хуралдаанаар өмнө хэлэлцэж эхэлсэн хуулийн төслүүдийг эын чуулганаар хэлэлцэх бэлтгэл хангахыг Байнгын хороодын га нарт даалгасугай.
4. Энэ тогтоолын хавсралтад дурьдсан Ерөнхийлөгч, Байнгын эод /Улсын Их Хурлын гишүүн/, Засгийн газраас өргөн үүлэхээр санал болгосон хуулийн төслүүдээс нэн яаралтай, шгүй хэлэлцэх шаардлагатай бөгөөд боловсруулалтын хувьд эн болсон төслүүдийг хаврын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг

хангахыг Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

5. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар тодорхой хугацаа хэлэлцэхээр хууль тогтоомжид заасан асуудлыг хаврын ээлж чуулганаар цаг тухайд нь хэлэлцэж байхаар тогтоосугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

"Монгол Улсын Их Хурлын хавр ээлжит чуулганаар хэлэлцэх асуудл тухай" Улсын Их Хурлын 1998 он 1 дүгээр сарын 23-ны өдрийн 24 то тогтоолын хавсралт

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 1998 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БОЛОН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ӨРГӨН МЭДҮҮЛЭХЭЭР САНАЛ БОЛГОСОН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

### Нэг. Нийгмийн бодлогын чиглэлээр

1. Нөхөн олговорыг амьжиргааны доод түвшний өөрчлөлт уялдуулан шинэчлэн тогтоож байх тухай хуулийн төсөл

2. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тух хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

3. Нийгмийн даатгалын тогтолцоог зах зээлийн харьцаа зохицуулан хуримтлалын зарчимд шилжүүлэх талаар төрө баримтлах бодлого, холбогдох хуулийн төсөл

4. Тахир дутуу иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого

5. Иргэдэд ажил,мэргэжлийн чиг баримжаа олгох тухай үндэсн хөтөлбөр

6. Биеийн тамир,спортын тухай хуулийн төсөл

7. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруу тухай хуулийн төсөл

8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,тэтгэмжийн ту хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

9. Нийгмийн халамжийн төрөлжсөн хуулийн төсөл

10. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчл оруулах тухай хуулийн төсөл

11. Нийгмийн даатгалын болон халамжийн багц хуульд нэм өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

### Хоёр. Төрийн байгуулалтын чиглэлээр:

12. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх ту шийдвэрийн төсөл

**Гурав. Эдийн засаг, төсвийн чиглэлээр:**

13. Үнэт цаасны тухай хуулийн төсөл
14. Аялал, жуулчлалын тухай хуулийн төсөл
15. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах тухай
лийн төсөл
16. Иргэний нисэхийн тухай хуулийн төсөл
17. Радио, долгионы тухай хуулийн төсөл
18. Автотээврийн тухай хуулийн төсөл
19. Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
й хуулийн төсөл
20. Мал аж ахуйн гаралтай түүхий эдэл экспортын татвар
аувах тухай хуулийн төсөл
21. Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай ерөнхий хуулийн төсөл
22. Гадаадын зээл тусламжийг авах, зохицуулах тухай хуулийн
эл
23. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл
24. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт,
члөлт оруулах тухай хуулийн төсөл
25. Үнэлгээний үйл ажиллагааны тухай хуулийн төсөл
26. ХАА-н даатгалын тухай хуулийн төсөл
27. Орон сууц хувьчлах тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах
й хуулийн төсөл
28. Агаарын зайд нислэг үйлдэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
лах тухай хуулийн төсөл
29. Ажлын байр бий болгох үндэсний хөтөлбөр
30. Нөхөрлөл, компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
лах тухай хуулийн төсөл
31. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл
32. Бууны албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
ийн төсөл
33. Татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
34. 1997 оны улсын төсвийн гүйцэтгэл
35. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
лах тухай хуулийн төсөл

**Дөрөв. Аюулгүй байдал, батлан хамгаалахын чиглэлээр:**

36. Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
й хуулийн төсөл
37. Улсын аюулгүй байдлын тогтолцооны тухай хуулийн төсөл

38. Зэвсэгт хүчний ерөнхий штабын тухай хуулийн төсөл
39. Монгол Улсын гадаад албаны тухай хуулийн төсөл
40. Иргэний хамгаалалтын даатгалын тухай хуулийн төсөл

### Тав. Хууль зүйн чиглэлээр:

41. Гадаад худалдааны арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлө оруулах тухай хуулийн төсөл
42. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төсөл
43. Сэжигтэн,яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих тух хуулийн төсөл
44. Хамтын гэрээ, хэлэлцээрийн тухай хуулийн төсөл
45. Захиргааны журмаар баривчлагдсан хүмүүсийг албад хөдөлмөрлүүлэх тухай хуулийн төсөл
46. Зарим өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх,албадан хөдөлмө лүүлэх тухай хуулийн төсөл
47. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэ өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
48. Захиргааны хариуцлагын тухай хуулийн төсөл
49. Цаазаар авах ялыг устгах тухай хуулийн төсөл
50. Зарим төрөлжсөн архивыг ашиглах журмын тухай хуули төсөл

### Зургаа. Байгаль орчин хөдөөгийн бодлогын асуудлаар:

51. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуули төсөл
52. Газар тариалангийн талаар төрөөс баримтлах бодлого
53. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруу тухай хуулийн төсөл
54. Байгалийн гамшгийн даатгалын тухай хуулийн төсөл
55. Их далай ашиглах тухай хуулийн төсөл
56. Газар тариалангийн тухай хуулийн төсөл
57. Хүнсний тухай хуулийн төсөл
58. Амьтны тухай хуулийн төсөл
59. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төсөл
60. Бэлчээр, хадлангийн тухай хуулийн төсөл
61. Ан агнуурын тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах ту хуулийн төсөл
62. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр
63. Мал даатгах тухай хуулийн төсөл

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 8 оны 2 дугаар ын 17-ны өдөр | Дугаар 6 | Улаанбаатар хот |

**Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай**

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсад гэмт гээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн элдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Зөвлөлийн ажиллах журмыг угаар хавсралтаар тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1998 оны 6 дугаар зарлигийн
1 дүгээр хавсралт

## МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| лөлийн дарга: | -Хууль зүйн сайд |
| өгч дарга: | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| | -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| ийн бичгийн дарга: | -Хууль зүйн сайдын дэргэдэх Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, зохицуулалтын албаны дарга |
| үүд: | -Монгол Улсын ерөнхий прокурор |
| | -Төрийн хянан шалгах хорооны ерөнхий нарийн бичгийн дарга |
| | -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч |
| | -Монгол Улсын Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга |

-Гэгээрлийн яамны Төрийн нарий(н) бичгийн дарга
-Сангийн яамны Төрийн нарий(н) бичгийн дарга
-Эрүүл мэнд, нийгмийн хамгаалл(ын) яамны Төрийн нарийн бичгийн дар(га)
-Цагдаагийн ерөнхий газрын дарга
-Шүүхийн шийдвэр биелүүл(эх) ерөнхий газрын дарга
-Улсын аюулгүй байдлыг хан(гах) газрын дарга
-Улсын Дээд шүүхийн судалгаа(ны) төвийн захирал
-Монголын ахмадын холбооны дарг(а)
-Иргэдийг гэмт халдлагаас хамгаал(ах) Монголын нийгэмлэгийн тэргүүн
-Монголын залуучуудын холбоо(ны) ерөнхий нарийн бичгийн дарга

Монгол Улсын Ерөнхийлөгчи(йн)
1998 оны 6 дугаар зарлигий(н)
2 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажл(ыг) зохицуулах зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь "Гэмт хэргээс урьдчи(лан) сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлд заасн(ы) улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажл(ыг) зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Зөвлөлийн үйл ажиллагааг Зөвлөлийн дарга удирдан зохи(on) байгуулна.

3. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, ахуйн нэгж, эрдэмтэд, ахмадууд, залуучууд, иргэдийн төлөөлөгч(ийг) оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөл(ийн) хуралдаан мөн. Хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх(тэй) холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүн, зөвлөлий(н)

лийн ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэнэ. Зөвлөлийн
иүүдийн олонхи нь хуралдаанд оролцож байгаа бол түүнийг хүчин
өлдөр гэж үзнэ.
5. Зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гарах бөгөөд түүнд
лөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
өлийн хуралдаанаар хэлэлцсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
удлаар зөвлөмж гаргаж болно. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл,
өмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан
эгжүүлэх талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнгийн тухай
тоосон хугацаанд хариу мэдэгдэх үүрэгтэй.
6. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Хууль зүйн сайдын дэргэдэх
т хэрэгтэй тэмцэх бодлого, зохицуулалтын алба гүйцэтгэнэ.
7. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгатай байна.
8. Зөвлөлийн орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь
өлийн даргын гарын үсэг бүхий үнэмлэхтэй байна.

## Хоёр. Зөвлөлийн үүрэг, эрх

1. Зөвлөл нь дор дурьдсан үүрэгтэй:
1. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга болон хууль
иулах төв байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ар зохиож байгаа ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах.
2. Иргэдийн амь нас, эрүүл мэнд, бусдын өмч хөрөнгөнд халдах,
гайлах, архидан согтуурах, танхайрах, зохион байгуулалттай гэмт
эгтэй тэмцэх болон авилгалын эсрэг арга хэмжээг хүчтэй
гоход бүх нийтийн хүч, анхаарлыг чиглүүлэх.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар төр, засгийн дээд
гуулагаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан холбогдох
гуулагад оруулах, ялангуяа шүүх, прокурорын байгууллагатай
лилцон улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар
арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулан
эгжилтийг зохион байгуулах.
4. УИХ, Засгийн газраас баталсан гэмт хэргээс урьдчилан
ийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний
элтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг улсын
жээнд зохион байгуулах.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам
ах, сахилга, зохион байгуулалтыг сайжруулах талаар иргэн,
гуулагаас гаргасан санал, хүсэлтийг судлан түүний мөрөөр
лал боловсруулах, тогтоосон журмаар шийдвэрлүүлэх.
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, төрийн бус
гууллагын үүсгэл санаачилгыг дэмжин, тэднийг энэ ажилд
нөөр оролцуулах, туслалцаа үзүүлэх.

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиула байгууллагуудын хамтын ажиллагаат зохицуулах.

8. Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаарх статистик мэдээг солилцох.

9. Гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаа нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох.

10. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрий бодлого болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээни талаар санал бэлтгэх.

11. Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлы зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлы шалган зааварлаж, чиглэл өгөх.

12. Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохио байгуулах.

2. Зөвлөл нь дараах эрхтэй:

1. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга болон хууль сахиулах төв байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаа зохиосон ажлын тайланг гаргуулан авах.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тог тоомж, Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийн биелэлтий яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжи харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах, тэдгээрийн удирда ажилтны илтгэл, сонсголыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж заалт чиглэл өгөх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулж авах.

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүү жилтийн явц, зарцуулсан хөрөнгийн тайланг холбогдо байгууллагуудаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх.

4. Зөвлөлийн ажилд мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагата нь тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах.

5. Эрх хэмжээнийхээ асуудлаар улс, орон нутгийн чанартай хура зөвлөгөөн, семинар зохион байгуулах.

6. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн д журам хангах ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэг байгууллагыг шагнаж урамшуулах.

7. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг биелүүлээгү хугацаа хожимдуулсан албан тушаалтны асуудлыг холбогдо байгууллагад нь албан ёсоор тавих.

**Гурав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл**

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн

аргаар толгойлуулсан орон нутгийн салбар зөвлөл /цаашид "Орон нутгийн салбар зөвлөл" гэх / зохицуулна.

2. Орон нутгийн салбар, зөвлөл нь 7-15 хүний бүрэлдэхүүнтэй айх бөгөөд бүрэлдэхүүнийг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал атална.

3. Орон нутгийн салбар зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн ухайн нутаг дэвсгэрийн онцлогийг тусгасан журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөж, гэмт хэргээс урьдчилан эргийлэх, нийгмийн дэг журам хангахтай холбогдсон хууль огтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

4. Орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах ичиг хэрэг, бусад үйлчилгээг тухайн Засаг даргын Тамгын газар ариуцах бөгөөд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

Банкны тухай хуулийн зарим зүйл заал Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны хянан хэлэлцсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Үндс хуулийн Цэцийн гишүүн Н. Жанцан даргалж, гишүүд Ж. Бямбажав, Ж. Бямбаа /илтгэгч/, С. Жанцан, Д. Чилхаажав нар бүрэлдэхүүнтэй хийв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Б. Цэндээху оролцуулав. Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Ц. Цэрэнжэ Н. Даш-Өлзий, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ-ы гишүүн Я. Эрхэмбаяр нар оролцов.

Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн Ц. Цэрэнжээ, Н. Даш Өлзий нар "Банкны тухай хуулийн 37 дугаар зүйл, 38 дугаар зүйлий 1-ийн 4 дүгээр заалт, 40 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 боло 2, 3 дугаар хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуули 16 дугаар зүйлийн 3-ын "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар о авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчи хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувиі өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлн гэснийг болон Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1,2 дуга заалт бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлий 2-ын "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгми гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шаш шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл боло Хүн бүр хууль зүйн этгээд байна", 16 дугаар зүйлийн 14-т бай "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомд гаргах . . . эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул хян үзэж, хэлэлцэж өгнө үү" гэж гомдол гаргасны дагуу Цэцийн гишү Ж. Бямбаа 1997 оны 11 дүгээр сарын 27-нд маргаан шийдвэрл ажиллагаа үүсгэжээ.

Энэхүү хуралдаанд бэлтгэж, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч иплуулан гэдний тайлбарыг сонсох, иргэн Ц. Цэрэнжээ, Даш-Өлзий нараас нэмэлт тодорхойлолт авах, Банкны /тухай/ ион Төв банкны тухай хуулийг хэлэлцэн өөрчлөлт оруулж баталсан Х-ын II дахь удаагийн сонгуулийн ээлжит бус чуулганы аллааны тэмдэглэлтэй танилцаж, хууль санаачлагчийн болон богдох хавсралт илтгэл дүгнэлт, УИХ-ын гишүүдийн санал үмжлэлийг судлах, түүнчлэн нийслэлийн Чингэлтэй дүүргийн үэд Монгол банкнаас гарган өгсөн Ардын банкийг татан лгасан тухай хавтаст материалыг харьцуулан үзэв.

Иргэн Ц. Цэрэнжээ, Н. Даш-Өлзий нар Үндсэн хуулийн Цэцэд гаж өгсөн нэмэлт тайлбартаа "Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн дахь хэсгийн заалт нь хүний өмчлөх эрхийг дээд түвшинд алгаажуулж өгсөн заалт. Гэтэл Банкны тухай хуулийн 37-41 дүгээр л нь бүхэлдээ Монгол банкинд хүний энэхүү эрхэнд өөрийн мжээр халдах боломжийг олгож байна. Монгол банкны үйл иллагаа хуулинд нийцэж байгаа эсэхэд тавих хяналтыг үндсэнд нь й болгож, банкны хувь нийлүүлэгч болох гишүүдийн өмчийг шууд лан авахаар заасан байна. Өөрөөр хэлбэл банк татан буугдсан иолдолд түүний үлдэх эд хөрөнгө бусад зүйлсийг өмчлөгч нь нгол банк болж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалттай эшиж байна.

Банкны тухай хуулиар зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гомдол ах эрхийг зөвхөн тодорхой хувь эзэмшигчдэд олгосон нь бусад » нийлүүлэгч гишүүдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх ирохоод хүргэж байна. Ингэснээрээ хүнийг хөрөнгө чинээний эдаар ялгаварлан гадуурхаж үл болох тухай Үндсэн хуулийн угаар зүйлийг давхар зөрчлөө.

Ёр нь Ардын банкийг татан буулгах үндэслэл байхгүй. Тийм иас Монгол банкны Ерөнхийлөгчийн 1996 оны 359, 362 дугаар аалуудыг хүчингүй болгохоор шүүхэд гомдол гаргасан. Гэтэл шүүх кны тухай хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн бидний эмжлэлийг хэрэгсэхгүй болгосон" гэв.

Энэхүү тайлбартай уялдуулан Чингэлтэй дүүргийн 1997 оны ' дугаар бүхий шүүхийн шийдвэр, Нийслэлийн шүүхийн ' оны 1128 тоот магадлалын үндэслэлийг судалж үзэхэд "Банкны й хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын нкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн" нийг ... тэдгээрийг эзэмшигч нэг субъектэд хамруулан ойлгоно" н Улсын дээд шүүхийн 1997 оны 379 дүгээр тогтоолоор өгсөн н ёсны тайлбарыг үндэслэн Н. Даш-Өлзий нарын нэхэмжлэлийг оны дүрмийн сангийн 25 хувийг дангаараа эзэмшигч нэхэмжлэл вагүй гэдгээр хэрэгсэхгүй болгожээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч УИХ-ын гишүүн Я. Эрхэмб
Үндсэн хуулийн Цэцэд 1998 оны 1 дүгээр сарын 27-нд гарг
тайлбартаа: Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зү
"Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаар
болно", Иргэний хуулийн 134 дүгээр зүйлд " эрх зүйн зөр
гаргасан этгээдийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй хураах бол
Иргэний хуулийн 139 дүгээр зүйлийн 3,4,6 дахь заалтад "ху
заасан үндэслэлээр өмчлөх эрхээ алдах", "өмчлөгч болох хууль
этгээд татан буугдсан" бол өмчлөх эрх нь дуусгавар болно г
заалтуудтай Банкны тухай хуулийн 37-40 дүгээр зүйлүүд Үн
хуулийн зөрчилтэй гэж гомдол гаргагчид үзсэн хэсгүүд ний
байна.

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Өмчлөгч
эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж бол
Иргэний хуулийн 22 дугаар зүйлд "хуульд заасан үндэслэл, жур
дагуу иргэн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж болно" г
заалтуудтай Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэс
заалтууд мөн нийцэж байгаа тул хуулийн зөрчил байхгүй. Ер
Монгол банк маань УИХ-аас баталсан төрийн мөнгөний бодл
хэрэгжүүлж, санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны найдва
байдлыг хангахын тулд тэдний үйл ажиллагаанд хяналт тав
Тийм ч учраас Төв банкны хуулийн дагуу "Банк байгуулах, бан
үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчи
болгох, хязгаарлалт хийх, шаардлага тавих, хяналт шалгалт х
банкинд онцгой дэглэм тогтоох, банкны эрх хүлээн авах эр
бөгөөд өмчлөгчдийн хувьд банкны гишүүд банкны үйл ажилла
өөрсдийн хяналтыг тавих ёстой юм" гэв.

Цэцийн хуралдаан дээр нэхэмжлэгч Ц. Цэрэнжээ, Н. Даш-Ө
нар Банкны хуулийн 7 бүлэг бүхэлдээ Үндсэн хуулийн зөрчи
Учир нь банкны эрх хүлээн авна гэдэг нь хэрэг дээрээ Мо
банкны эрх хэмжээг Үндсэн хуулийн дээр гаргаж тавьсан, Үн
хуулийн хүрээнд хүргэж болшгүй бүлэг болжээ. Банкийг т
буулгаж, өмчийг нь эрх хүлээн авагчид /өмчлөх эрхтэй
шилжүүлж буй ажиллагаа нь илэрхийлэж нэг эрх мэдэлтэй, нааш
Монгол банк өмчлөгчийн эрхийг өөрийн дураар эдлэх нөхц
бүрдүүлж байна.

Энэхүү хууль бус ажиллагааг Банкны тухай хуулийн 41 ду
зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар өмгөөлөн хааж зөрчигдсөн э
хамгаалан сэргээх хууль эрхийн үндэслэлгүй болгожээ. 7 ду
бүлгийн бусад заалтуудыг Монгол банкны дураар ашлах болом
бүрдүүлсэн дээрх заалтуудаас салгаж үзэх боломжгүй юм. Б
Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөн

ийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлагатай. Энэ байдлыг Цэц
рал үзэж дүгнэлтээ гаргана гэж найдаж байна" гэв.
ИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч УИХ-ын гишүүн Я. Эрхэмбаяр
гол банк Банкны тухай хуулиар улсын санхүүгийн болон
оний тогтвортой байдлыг хадгалж, эдийн засгийн амьдралыг
вартай болгох онцгой үүрэг хүлээсэн байгууллага. Тэгээд ч хоёр
алтай банкны тогтолцооны үед Төв банкны хариуцлага өндөр
ёстой юм. Тийм ч учраас Төв банкинд хуулиар хүлээх
уллагатай нь дүйцэх эрх олгохоос өөр аргагүй. Төв банк өөрөө
гол Улсын Их Хурлын хяналтанд байдаг учраас Үндсэн хуулиас
н эрх бүхий байгууллага гэж үзэхгүй байна" гэв.

АВАЛ:

нкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх
йн заалт нь банкны эрх хүлээн авагчийг томилсонтой
гдуулан хадгаламж эзэмшигчид, харилцагчдын шүүхэд гомдол
х эрхийг хөрөнгө чинээний байдлыг харгалзан хувь тогтоох
р хязгаарласан нь хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх
зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах тухай
н хуулийн заалтыг зөрчихөд хүргэжээ.
нкны тухай хуулийн 7 дугаар бүлгийн бусад зүйл, заалт Монгол
н Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл
гдохгүй байна.
онгол улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн
маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн
дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:
Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх
йн "Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж
энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос
30 хоногийн дотор дараахь этгээд шүүхэд гаргах эрхтэй:
Банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн
н;
Банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;
Банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг
игч"; гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр
16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийг зөрчсөн байна.

2. Банкны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар бүлгийн бус зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурьдсан зүй заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны даг УИХ-ын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хой 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хар ирүүлэхийг УИХ-д уламжилсугай.

ДАРГА — Н. ЖАНЦАН

ГИШҮҮД — Ж. БЯМБА
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ж. БЯМБАЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

1998 оны 2 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

**Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, гтлан хамгаалах яамны саналыг үндэслэн Монгол Улсын згийн газраас ТОГТООХ нь:

1."Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн зрын 1997 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 201 гээр тогтоолын 2 дугаар зүйлд дор дурдсан /улгатай "в" заалт нэмсүгэй:

"в/"Зохион байгуулалтын өөрчлөлт, орон тооны ахотролтой холбогдуулан авах зарим арга хэмжээний кай" Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр рын 19-ний өдрийн 193 дугаар тогтоолын дагуу 1990-92 онд цэргийн бүрэн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тгэврийг "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, гэмжийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх эгт заасан хувь, хэмжээгээр цэргийн алба хаасны зэн тэтгэвэр тогтоон шинэчлэн бодох".

**Монгол Улсын Ерөнхий сайд** — **М.ЭНХСАЙХАН**

**Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд** — **П.ЗОРИГ**

**Батлан хамгаалахын сайд** — **Д.ДОРЛИГЖАВ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

1998 оны 2 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

**"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариалагч хамт олон" шалгаруулах тухай**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны саналыг үндэслэн

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хээлтэгчийн хувийн хинг зохистой хэмжээнд хүрг мал сүргээ үр төлөөр нь өсгөн, малын үүлдэрл байдал, ашиг шимийг сайжруулж, мал аж ахуй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаа өндөр амжилт гаргасан, энэ тогтоолын 1 дугээ хавсралтад дурдсан малчдыг "Улсын сайн малчин"-аа газар тариалангийн үйлдвэрлэлийг үр ашигтай эрхл арвин ургац авч, газрын ашиглалтыг сайжруулах, газ тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар бүтээлтэй ажиллаж өндөр амжилт гаргасан, эн тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан хамт олн "Улсын тэргүүний тариалагч хамт олон"-оор тус т шалгаруулсугай.

2.Засгийн газрын 1997 оны 32 дугаар тогтооло батлагдсан "Улсын сайн малчин шалгаруулах журам"- 16 дугаар зүйлд ". . . 200,0 мянган төгрөгийн у бүхий . . ." гэснийг ". . . 350 мянган төгрөгийн у бүхий дурсгалын . . ." гэж өөрчилсүгэй.

3."Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариала хамт олон"-ы шагнал, дурсгалын зүйлийн үнэд зориу 3750 (гурван сая долоон зуун тавин мянган) мян төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах Сангийн сайд П.Цагаанд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Хөдөө аж ахуй,үйлдвэрийн сайд** **Л.НЯМСАМБУУ**

**Сангийн сайд** **П.ЦАГААН**

Засгийн газрын 1998 оны 13 дугаа тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН САЙН МАЛЧНААР:

1.Говь-алтай аймгийн Дэлгэр сумын Баянсан баги малчин Жамганы ТҮДЭВДОРЖ;

2.Өвөрхангай аймгийн Баян-өндөр сумын 2 дуга багийн малчин Нанзадын ЯГААНБАНДИ;

3.Баянхонгор аймгийн Баянговь сумын 3 дуга багийн малчин Шархүүгийн ЖАНЖАА;

4.Баян-өлгий аймгийн Алтанцөгц сумын 1 дүгээр
ийн малчин Бocaгaны РНС;
5.Ховд аймгийн Дарви сумын Мөнгөн-аяга багийн
чин Доржийн ЛХААСҮРЭН;
6.Сүхбаатар аймгийн Халзан сумын 1 дүгээр багийн
чин Болдын ЛХАМСҮРЭН;
7.Архангай аймгийн Хайрхан сумын Могой багийн
чин Маналлжавын БАТМӨНХ;
8.Завхан аймгийн Сантмаргац сумын Баяннуур багийн
чин Мөнгөөгийн ДАВАА;
9.Булган аймгийн Дашинчилэн сумын Лах багийн
чин Лхагваагийн АГВААН.

Засгийн газрын 1998 оны 13 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛНООР:

.Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Газрын ундраа"
;
.Булган аймгийн Хангал сумын "Цагаан тавилан"
;
.Увс аймгийн Улаангом сумын Газар тариалангийн
эм шинжилгээний станцын харьяа хүнсний ногооны үр
үүлгийн бригад.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 998 оны 2 дугаар<br>арын 12-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар<br>хот |

**Журам батлах тухай**

онгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
."Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх
эм"-ыг хавсралтын ёсоор баталсугай.
.Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх
длыг энэхүү журамд нийцүүлэн иж бүрэн төлөвлөж
хүүжүүлэх зорилгоор шинжлэх ухаан, технологийн
з хэмжээнд зориулсан хөрөнгө оруулалтыг Шинжлэх
ан, технологийн сангаар дамжуулан зарцуулж байх

байх арга хэмжээ авахыг Гэгээрлийн сайд Ч.Лхагважа
Сангийн сайд П.Цагаан нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

Гэгээрлийн сайд Ч.ЛХАГВАЖАВ

Засгийн газрын 1998 оны
дугээр тогтоолын хавсрал

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.Энэхүү журмын зорилго нь төсөл хэрэгжүүлэх ү ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, түүнтэй холбогд үүсэх харилцаар зохицуулахад оршино.

Шаардлагатай гэж үзвэл төсөл хэрэгжүүлэх ү ажиллагааны тодорхой үе шатыг нарийвчилсан дүрэ заавар, аргачилаар зохицуулж болно.Эдгээр дүрэ заавар, аргачилыг энэ журамд нийцүүлэн гарг Гэгээрлийн сайд батална.

2.Шинжлэх ухаан, технологийн төсөл (цаашид "төсө гэх) гэдэгт шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чи лэлийн хүрээнд гүйцэтгэх эрдэм шинжилгээ, турши зохион бүтээх ажлыг шударга өрсөлдөөн, гэр захиалгын үндсэн дээр олол, арга зүйн өндөр түвш явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан дүнг бий болгох үйл ажиллагаар төлөвлөсөн бари бичгийг ойлгоно.

3.Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд доор дурдс ажлууд багтана. Үүнд:

а/төсөл захиалах;

б/төсөл боловсруулах;

в/төсөл сонгон шалгаруулах;

г/төслийг гэрээлж баталгаажуулах;

д/төслийг санхүүжүүлэх;

е/төслийн гүйцэтгэлд хяналт тавих;

ж/төслийн үр дүнг баталгаажуулах, мэдээлэ тайлагнах;

з/төслийн үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн е авлагыг тооцох.

4.Төсөл хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг эмтална:
а/шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл юн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт аарах хөтөлбөр, төслийг тэргүүн ээлжинд сонгон эргжүүлэх;
б/төслийг Шинжлэх ухаан, технологийн сан (цаашид и" гэх)-гийн болон захиалагчийн хөрөнгөөс хүүжүүлэх.
5.Төслийн захиалагч нь Улсын Их Хурлын Тамгын ар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, гийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, Шинжлэх аны академи байна:
а/шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх лэлүүдийн хүрээнд явуулах онолын суурь судалгааны лийн захиалагч нь Шинжлэх ухааны академи байна;
б/эдийн засаг, нийгмийн салбаруудын хүрээнд хэрэг-лэх төслийн захиалагч нь тухайн салбарын асуудал иуцсан төрийн захиргааны төв байгууллага байна;
в/эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чиглэгдсэн бар дундын шинж чанартай зарим цогцолбор асуудлаар өлбөр, төсөл хэрэгжүүлэх даалгаврыг Монгол Улсын нхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд өгч болох өөд эдгээр төслийн захиалагч нь Ерөнхийлөгчийн гын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар на;
г/эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогын гамдсан зарим асуудлаар явуулах судалгаа, шинжил-ний ажлын захиалагч нь Улсын Их Хурал байж болох өөд эдгээр төслийг Улсын их Хурлын даргын шээрсноор зөвхөн Улсын Их Хурлын Тамгын газар иална.
.Төслийн гүйцэтгэгч нь дараах этгээд байж болно:
а/эрдэм шинжилгээний байгууллага (эрдэм шинжил-ний хүрээлэн, төв, судалгаа, туршилт, үйлдвэрлэл, несийн корпораци, их, дээд сургууль);
б/аж ахуйн нэгж, байгууллага;
в/эрдэмтдийн хамтлаг;
г/Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй
.
.Төсөл хэрэгжүүлэх багийг бүрдүүлэх, хэрэгжилтийг іон байгуулах, төсөлд зориулсан хөрөнгийг зохих мын дагуу зарцуулах, төслийн багийг арга зүйн цсэн удирдлагаар хангах, төслийн эцсийн үр дүнг алагчийн өмнө хариуцах үндсэн үүрэг бүхий төслийн

удирдагчийг ажиллуулна. Төслийн удирдагчид олг цалин хөлс, урамшлын хэмжээг уг төслийг хэрэгжүүл гэрээнд заана.

8.Төслийн үр дүнд гарч болзошгүй патент, зохио чийн эрх эзэмших болон төслийн эрдэм шинжилгээн тайланг өмчлөх, ашиглах асуудлыг тапууд төс хэрэгжүүлэх гэрээндээ тодорхой заана.

9.Төсөл хэрэгжүүлэх хугацаа 5 жилээс хэтрэхг байна.

### Хоёр. ТӨСӨЛ ЗАХИАЛАХ

10.Төсөл захиалах ажил нь дор дурдсан үе шатт байна:

а/захиалагчийн зүгээс төсөл боловсруулах ажл чиглэлийг тодорхойлох;

б/Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвл (цаашид "Үндэсний зөвлөл" гэх)-өөр тухайн чиглэли хэлэлцүүлэх;

в/сонгон авсан чиглэлээр төсөл (тендер) зарлах.

11.Төслийн чиглэлийг тодорхойлохдоо эдийн заса нийгмийн тухайн үеийн хэрэгцээ, шаардлага, шинжл ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлт уялдаж буй байдал, төслийн үр дүн нь үйлдвэрлэ үйлчилгээнд ашиглагдах боломж, төсөл захиал шаардлага байгаа эсэх, төсөл хэрэгжүүлэх шинжл ухаан, эдийн засгийн нөөц боломж зэргийг нарийвчл судалж тодорхой шийдвэр гаргасан байна.

12.Дараа онд шинээр эхлэх төслийн чиглэли захиалагч санал болгон дэвшүүлж Үндэсний зөвлөли ажлын албанд тухайн оны 2 дугаар сарын 15-ны дот албан ёсоор ирүүлнэ.

13.Ажлын алба төслийн чиглэлийг хүлээн авч шинжл ухааны салбараар ангилж, төсөл захиалах санал нэгтгэн боловсруулж Үндэсний зөвлөлийн хуралд дугаар сарын 15-ны дотор оруулж хэлэлцүүлнэ.

14.Үндэсний зөвлөлийн хуралаар төслийн чиглэл хэлэлцэх үед захиалагч захиалсан төслийнх үндэслэлийг хамгаална.

15.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн төс боловсруулах чиглэл (шаардлагатай чиглэлүүдээр те дер)-ийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан 3 дуга сарын 31-ний дотор зарлахыг ажлын алба хариуц Төслийн чиглэл болон болзлыг мэдээллийн хэрэгсл зарлахад шаардагдах хөрөнгийг Сангаас гаргана.

## Гурав. ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

16.Гүйцэтгэгч (өрсөлдөгчид) нь төслийг зарласан лэл (тендер)-ийн дагуу боловсруулах ба түүнийг богдох мэргэжлийн байгууллагын эрдмийн зөвлөлийн лаар хэлэлцүүлэн 2 хувь төслийн баримт бичгийг уг лын шийдвэрийн хамт 6 дугаар сарын 1-ний дотор ын албанд ирүүлнэ. Хугацаа хоцорсон материалыг ээн авахгүй.

.7.Зарласан чиглэлийн хүрээнд төсөл боловсруулах- дараах материалыг бүрдүүлнэ:

.Дараах зүйлийг тусгасан төслийн карт:

ı/төслийн нэр;

›/төслийн хугацаа (эхлэх, дуусах он, сар);

ı/төслийн захиалагч;

·/төслийн гүйцэтгэгч;

ı/төслийг санхүүжүүлэгч;

:/төслийн нийт зардал (мян.төг);

:/төслийн удирдагчийн овог, нэр, мэргэжил, эрдмийн эг, цол;

ı/төсөлд оролцогчдын овог, нэр, мэргэжил, эрдмийн эг, цол.

·.Дор дурдсан бүтэцтэй төсөл:

ı/төсөл гүйцэтгэх үндэслэл, шаардлага;

›/төслийн эцсийн үр дүн;

ı/төслийн үр дүнгийн шинэлэг буюу давшилттай тал;

·/төслийн эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач богдол;

ı/төслийн үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглах сдад худалдах, лицензийн гэрээгээр ашиглуулах, пийг санаачлагч өөртөө үлдээх гэх мэт).

## Дөрөв.ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

8.Ажлын алба төслийг хүлээн авч түүнд экспертиз лгэх ажлыг дараах үе шатаар зохион байгуулна:

/Шинжлэх ухааны академийн холбогдох салбарын э чуулганаар 6 дугаар сарын 20-ны дотор төслийн зар санал, дүгнэлт гаргуулж авах;

/ажлын хэсгүүдийг Үндэсний зөвлөлийн шийдвэрээр илуулж шаардлагатай зарим төсөлд хоёр дахь шатны эртиз хийлгэх. Шинжлэх ухааны академийн санал, нэлт хугацаандаа ирээгүй тохиолдолд төслийг хоёр ь шатны экспертизэд шууд оруулж болно.

9.Төсөлд үнэлгээ, дүгнэлт гаргах, экспертиз

хийхдээ дараах шалгуур үзүүлэлтийг баримтална:

1.Төсөл, түүний үр дүнгийн талаар:

а/төслөөр гүйцэтгэх ажил нь шинжлэх ухаан, техн логийн тэргүүлэх чиглэлд хамрагдаж буй байдал;

б/төслийн үр дүнгийн эрэлт хэрэгцээ, шаардлаг урьдчилан харсан байдал;

в/төслийн үр дүнгийн шинэлэг, цөмийлттэй т түүнийг орлуулан хэрэглэж болох өөр бүтээгдэхүү технологи байгаа эсэх;

г/төслийн үр дүн нь захиалагчийн шаардлагад нийц буй эсэх;

д/төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигл боломж;

е/төслийн үр дүнг зах зээлд борлуулах боломж;

ж/төслийн эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаа технологийн ач холбогдол.

2.Төсөл хэрэгжүүлэх ажлын онол, арга зүйн үнд лэл, мэдээлэл хангамжийн талаар:

а/төсөл хэрэгжүүлэх боловсон хүчний хангам тэдгээрийн онол, арга зүйн бэлтгэл, төсөл хэрэгжү байсан туршлага;

б/төслийн хүрээнд шаардагдах дотоод, гад мэдээлэл хангамж.

3.Төслийг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн ор талаар:

а/төслийн хүрээнд гүйцэтгэх судалгаа, турши ажлын материаллаг баазын хангамж, түвшин;

б/төслийн үр дүнг өмчлөх, ашиглахтай холбог үүсэж болох зарим онцлог харилцаа зохицуулах а зам.

20.Экспертиз хийсэн ажлын хэсгүүд төслийн 1 хув үнэлэлт, дүгнэлтийн хамт 7 дугаар сарын 10-ны до ажлын албанд ирүүлнэ.

21.Төсөлд хийсэн экспертизийн дүнг ажлын а нэгтгэн санал боловсруулж Үндэсний зөвлөл хуралд 8 дугаар сарын 1-ний дотор оруулна. Үндэс зөвлөлийн шийдвэр нь төслийг сонгон шалгару эцсийн шийдвэр байна.

22.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх аж ажлын алба зохион байгуулна.

## Тав.ТӨСЛИЙГ ГЭРЭЭЛЖ БАТАЛГААЖУУЛАХ

23.Төслийн захиалагч, гүйцэтгэгч нь (цаа "талууд" гэх) "Шинжлэх ухаан, технологийн төс

эгжүүлэх гэрээ"-ний үлгэрчилсэн загвар (журмын дугээр хавсралт)-ын дагуу төсөл хэрэгжүүлэх гэрээ йгуулна.

24.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дайн оны Төсвийн тухай хууль хүчин төгөлдөр эхноос хойш 15 хоногт багтаан төслүүдийн төсөвт гийг тодотгох ажлыг Сан захиалагч, гүйцэтгэгчийн лцоотойгоор гүйцэтгэнэ.Энэхүү тодотголын улмаас лийн бүтэц, агуулгад өөрчлөлт орвол уг өөрчлөлтийн аар талууд харилцан тохиролцож, нэмэлт тайлбар, цоо хийж төсөлд хавсаргана. Шаардлагатай бол хүү өөрчлөлтийг Үндэсний зөвлөлд оруулна.

25.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн төсөл эгжүүлэх гэрээ байгуулна. Гэрээг байгуулахдаа энэ мын 24-т заасан төслийн тодотгол хийснээс хойш хоногт багтаана. Гэхдээ Төсвийн тухай хуулиар лагдсан шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний өв хүрэлцэхгүй болсон тохиолдолд шинээр эхлэх лүүдэд зохицуулалт хийнэ.

26.Сан нь батлагдсан төслийн баримт бичгийг иалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч болон ажлын анд тус бүр 1 хувийг илгээнэ.

## Зургаа. ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

27.Төслийг санхүүжүүлэх үйл ажиллагааг Үндэсний лөлөөс баталсан хөрөнгийн хэмжээ, хуваарийг эслэн захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр эрхэлнэ. Гэрээг "Шинжлэх ухаан, технологийн лийг санхүүжүүлэх гэрээ"-ний үлгэрчилсэн загвар рмын 2 дугаар хавсралт)-ын дагуу хийнэ.

8.Төслийн санхүүжилтэд тухайн төслийн хүрээнд цэтгэх судалгаа шинжилгээ, сорилт туршилтын ажил, өнгө оруулалтаас гадна төсөлд тусгагдсан ажлын лэлээр явуулах сургалт, хурал, семинар, уулзалт, гэлэн сурталчилгаа зэрэгт шаардагдах зардлыг руулна.

9.Төсөл хэрэгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын дүнд бий болсон үндсэн хөрөнгийг төсөл дууссаны за хэрхэн эзэмших талаар төсөл санхүүжүүлэх ээнд тусгана.

0.Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын к чанар, түүний үр дүнг ашиглах хүрээ, борлуулах эмж зэргийг харгалзан төслийг дараах хэлбэрээр хүүжүүлнэ:

а/грант олгох буюу буцалтгүй санхүүжилт хийх;
б/эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх;
в/харьцангуй бага хүүтэй зээл олгох.

31.Төслийн санхүүжилтийн хэлбэрийг Үндэсний зөвл шийдвэрлэх бөгөөд санхүүжилтийн хэмжээ, хугаца хэлбэрийг төслийн санхүүжилтийн гэрээнд тусгас байна.

32.Гүйцэтгэгчийн хариуцлагыг өндөржүүлэх, төсли үр дүнгийн түвшинг дээшлүүлэх, тогтоосон хугацаа ажлыг дуусгах зорилгоор төслийн батлагдсан ни төсөвт өртгийн 5-10 хувьтай тэнцэх хөрөнгийг Са үлдээж төслийг дууссаны дараа захиалагчийн сана дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгчид олгоно.

33.Захиалсан төслийнхөө төсөвт өртгийн 10 хүр хувьтай тэнцэх хөрөнгийг захиалагч өөрөө хариуц Энэ хөрөнгийг Сангаар дамжуулж зарцуулна.

34.Төсөл хэрэгжүүлэх явцад төслийн санхүүжилт хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх (хорогдуулах) шаардл гарвал уг асуудлыг захиалагч, санхүүжүүлэгч хамт боловсруулж Үндэсний зөвлөлд оруулан шийдвэрлүүлнэ.

35.Үргэлжилж буй төслийн төлөвлөгөөт оны зард тодорхойлохдоо Үндэсний зөвлөлөөр анх баталсан н төсөвт өртгийн тухайн оны хуваарийг үндэс болгоно.

36.Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санх жүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах буюу дүн нь гэрээнд заасан шаардлага хангахгүй тохиолд захиалагч гэрээг хугацааны өмнө цуцлах, санхүүжүүл хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх арга хэм авч болно.

37.Төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, т ний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж Үндэсний зөвл оруулж батлуулна.

## Долоо. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ

38.Төслийн гүйцэтгэлд дараах чиглэлээр хян тавина:

а/төслийн хүрээнд гүйцэтгэж буй эрдэм шинжилг туршилт, зохион бүтээх ажлын арга зүй;
б/төслийн санхүүгийн үйл ажиллагаа;
в/төслийн үр дүн.

39.Арга зүйн хяналт тавих ажлыг холбогдох эр шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөл, санхүүги

элт тавих ажлыг Сан, үр дүнгийн хяналт тавих ажлыг налагч тус тус гүйцэтгэнэ.
0. Энэ журмын 39-д заасан хяналт тавих үүрэг ай этгээдүүд хяналт шалгалтын ажлыг дангаараа буюу гран гүйцэтгэж болно.

## Найм. ТӨСЛИЙН ҮР ДҮН, ТҮҮНИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ

1.Төслийн үр дүн нь дараахь хэлбэртэй байж болно:
/онолын судалгааны тайлан, онолын үндэслэл, үзэл имтлал, ном, товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл;
/шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний эар;
/шинэ ба шинэчилсэн технологи, технологийн эар;
/техник хэрэгсэл, түүний эд ангийг хийх ажлын аг;
/судалгаа, туршилтын ажлын үр дүнгээр үйлдвэрлэл улах техник-эдийн засгийн үндэслэл, зураг, тооцоо;
/судалгаа, туршилт, боловсруулалтын ажил болон двэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах бусад ийн заавар, журам, аргачлал, математик загвар, оогын алгоритм, тооцооны математик хангамжийн граммууд, стандарт, норм, схем.
2.Судалгаа, туршилтын ажлын үр дүнд тулгуурлан ийн зориулалттай хэрэнгээр жижиг, дунд үйлдвэр уулах тохиолдолд уг объектыг мөн төслийн үр дүн тооцож болно.
3.Төслийн үр дүнг дараахь баримт бичгийн аль эр баталгаажуулна:
а/шинэ бүтээлийн патент;
б/оновчтой саналын гэрчилгээ;
в/экспертизийн комисс, эрдмийн зөвлөлийн хурлын эн холбогдох бусад байгууллагын албан ёсны элт, дүгнэлт.
4.Төслийн үр дүнд экспертиз хийлгэж үнэлэлт, элт гаргуулах ажлыг захиалагч хариуцна.
5.Гүйцэтгэгч нь төслийн завсрын болон эцсийн үр тэдгээрийн баталгаажуулалтын талаар Гэгээрлийн ы Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газарт й бүр мэдээлж байх үүрэгтэй.
эардлагатай гэж үзвэл тус газар уг мэдээллийн эар захиалагчаас нотолгоо гаргуулан авч болно.
үү мэдээлэлд тулгуурлан Мэдээлэл, хяналт шинжил-

гээ, үнэлгээний газар шинжлэх ухаан, технологи
төслийн үр дүнгийн мэдээллийн сан байгуулж, түүни
баяжуулан сурталчлах үүрэгтэй.

46.Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны жил бүри
тайланд төслийн гүйцэтгэлийн явцын талаар дэлгэрэнг
тусгасан байна. Эрдэм шинжилгээний ажлын тайла
улсын стандартын дагуу бичиж Гэгээрлийн сайдын бат
лсан "Шинжлэх ухаан, технологийн төслийн тайланг х
лээн авах, хэрэглэгчдэд ашиглуулах журам"-ын даг
Итгэмжлэн хадгалагчид хүлээлгэн өгөх ажлыг төс
дуусcанаас хойш 2 сарын дотор багтаан гүйцэтгэнэ.

## Ес. ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ, САНХҮҮГИЙН ӨР АВЛАГЫГ БАРАГДУУЛАХ

47.Гүйцэтгэгч нь төсөл дуусcанаас хойш 2 сар
дотор түүний үр дүнг захиалагчид актаар хүлээлг
өгнө. Төслийн үр дүнг хүлээлгэн өгөхдөө "Шинжл
ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж хүлээн авс
акт"-ын үлгэрчилсэн загвар(журмын 3 дугаар хавсралт
ыг үйлдэнэ.

48.Төслийн үр дүнг хүлээн авсан тухай захиалагчи
албан ёсны дүгнэлт, санхүүгийн эцсийн тооцоо хи
талаар санхүүжүүлэгчид хандсан хүсэлт, төслийн эрд
шинжилгээний ажлын тайланг Итгэмжлэн хадгалагч
хүлээлгэн өгсөн тухай актыг үндэслэн санхүүжүүлэ
төслийн үйл ажиллагаатай холбогдсон санхүүгийн эцс
тооцоог хийнэ. Уг тооцоог эдгээр материалыг хүлэ
авснаас хойш 10 хоногийн дотор хийнэ.

49.Захиалагч нь төсөл дуусcанаас хойш 1-2 жи
багтаан түүний үр дүнг ашиглах талаар хийсэн ажи
тухай мэдээлэл, тайланг Үндэсний зөвлөлд илгт
байна.

Шинжлэх ухаан, технологийн төсөл
хэрэгжүүлэх журмын 1 дүгээр хавсралт

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

/Үлгэрчилсэн загвар/

99__оны___дугаар Дугаар___ Улаанбаатар хот
арын ___ ны өдөр

ахиалагч..............................................-ыг
(байгууллагын нэр)

өлөөлж..............................................
(албан тушаал, овог ,нэр )

үйцэтгэгч.............................................. -ийг
/байгууллагын нэр/

өлөөлж..............................................
/албан тушаал, овог нэр/

цаашид "талууд" гэх/ Шинжлэх ухаан, технологийн
эл хэрэгжүүлэх журмыг үндэс болгон
..............................................
гэй шинжлэх ухаан, технологийн төсөл /цаашид
сөл" гэх/ хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцож
күү гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

.Төслийг 19.... - 19 .... онд багтааж .... жилийн
цаанд гүйцэтгэнэ.

.Төслөөр гарах үр дүн, төслийн хүрээнд гүйцэтгэх
ин дарааллыг тодорхойлж, "Төслийн үр дүнгийн
габар", "Төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан
влөгөө"-г үйлдэж гэрээнд хавсаргав.
.Шинэ бүтээлийн патент, оновчтой саналын
илгээ авсан, зохиогчийн эрхэд хамаарах бусад
өл бий болгосон тохиолдолд тухайн бүтээлийг
лах онцгой эрх болон зохиогчийн эрхтэй холбогдон
эн харилцааг Патентын тухай, Зохиогчийн эрхийн
й, Иргэний хуулиуд ба энэ гэрээнд дурдсаны дагуу
цуулах зарчим баримтална. Өөрөөр зохицуулах
лага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ хэлцэл
уулж болно.

**Хоёр. Талуудын үүрэг, эрх, хариуцлага**

4.Үүрэг

1.захиалагч дараахь үүрэг хүлээнэ:

а/төслийн гүйцэтгэлд байнгын хяналт тавих;

б/төслийн төсөвт өртгийн .... хувийг хариуцах;

в/төсөл гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд зох дэмжлэг туслалцаа үзүүлэх;

г/төслийн явцтай хагас жил тутам танилцаж, түүн дараагийн санхүүжилтийн саналыг санхүүжүүлэгч гаргах;

д/төслийн үр дүнгийн үнэлгээг хянаж, баталга журлах;

е/төслийн үр дүнг хүлээн авч түүнийг үйлдвэрлэ хэрэглээнд ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх;

ж/үр дүнгийн ашиглалтын байдлыг харгалзан төсл гүйцэтгэгч нарыг зохих журмын дагуу хөхиүлэн дэмж урамшуулах.

2.Гүйцэтгэгч дараахь үүрэг хүлээнэ:

а/төслийг хугацаанд нь багтааж бүрэн гүйцэтгэх, дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс бууруулахгүйгээр бүтээж бий болгох;

б/төслийн хөрөнгө зардлыг оновчтой хэлбэр хуваарилж, үр өгөөж сайтайгаар зарцуулах;

в/төслийн гүйцэтгэлийн явц, үр дүн, түүний бат гаажуулалтын талаар холбогдох байгууллага, хүмү тухай бүр мэдээлж байх;

г/гүйцэтгэж буй төсөл, түүний үр дүнгийн тал сурталчилж байх, үр дүнг нэвтрүүлэх буюу ашиглах ахуйн нэгж, байгууллагуудыг илрүүлэн олох;

д/төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зард тооцож төслийн жил, жилийн төсөв, төлөвлөгөөнд тус хэрэгжүүлэх;

е/төслийн явцыг хагас жил тутам захиалаг танилцуулж байх.

5. Эрх.

1.Захиалагч дараахь эрх эдэлнэ:

а/төслийн гүйцэтгэл, үр дүн, түүний батал журлалт, санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагаа зэ асуудлын талаар гүйцэтгэгчээс тухай бүр мэдээ, тай гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөр дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардл тавих;

б/захиалсан үр дүнд холбогдолгүй ажлыг төсл хүрээнд гүйцэтгэж буй тохиолдолд уг ажлыг зогс

й асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлэх;
/төслийн үр дүн нь захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд үүнийг зогсоох буюу шинэчлэх, гэрээг цуцлах асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх;
/гэрээний шаардлагыг хангаагүй үр дүнг хүлээж авахгүй байх, уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсвэл арга хэмжээ авах;
/захиалсан үр дүнгийнхээ патентыг эзэмших, үр дүнг захиран зарцуулах;
/төслийн эрдэм шинжилгээний ажлын тайланг өмчлөх, цаашид ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;
/өгөөж, ашиг сайтай үр дүн бий болгосон тохиолдолд гүйцэтгэгчийг зохих журмын дагуу урамшуулах.
.Гүйцэтгэгч дараах эрх эдэлнэ:
/төслийн үйл ажиллагааны хүрээнд захиалагчаас санхүү, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын талаар зохих хэмжээний дэмжлэг туслалцаа авах;
/төсөл гүйцэтгэх нөхцөл боломжоор бүрэн хангахыг шаардах;
/захиалгаар бий болгосон үр дүн нь шинэ бүтээлийн патент авсан нөхцөлд захиалагчтай лицензийн гэрээ байгуулах үндсэн дээр тухайн үр дүнг ашиглах, эсвэл патент эзэмших эрхийг захиалагчаас зохих журмын дагуу худалдаж авах;
/төслийн үр дүн оновчтой саналаар батлагдсан нөхцөлд түүнийг хүлээн авч ашиглагч этгээдтэй зохиогч гэрээ хэлцэл байгуулах замаар лицензийн төлбөр авах;
/захиалгаар бий болгосон үр дүн нь зохиогчийн эрхэд хамаарах тохиолдолд захиалагчтай нэмэлт гэрээ хэлцэл байгуулж, түүнд тусгагдсан болзол, нөхцөлийн дагуу зохиогчийн эрх эдлэх;
/төслийн үр дүнгийн даалгаварт нэр заагдаагүй боловч төслөөр зайлшгүй хийгдэх ажлын хүрээнд бий болсон бүтээл нь зохиогчийн эрхэд хамаарах тохиолдолд зохиогч этгээд тухайн бүтээлийнхээ хувьд эдийн хөрөнгийн бус амины болон түүнийг ашиглах онцгой /эд хөрөнгийн/ эрх эдлэх;
/төслийн үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах явцад зохиогчийн хяналт тавих;
/төслийн үр дүнг бүтээж, бий болгосны төлөө, түүнийг үйлдвэрлэлд ашигласнаас олсон орлого, ашгаас гэрээ хэлцлийн үндсэн дээр зохих хэмжээний шан,

урамшуулал авах.

6. Хариуцлага

Үүргээ биелүүлээгүй талын ...үлээх хариуцлаг талууд харилцан тохиролцох замаар энэхүү гэрээ тодорхой тусгана.

**Гурав. Бусад зүйл**

7.Төсөл хэрэгжүүлэх, түүний үр дүнг баталгу жуулах, үнэлэх, хүлээлгэн өгөх, үр дүнг үйлдвэрл хэрэглээнд шилжүүлэх, ашиглах, урамшуулах ажи холбогдох хууль тогтоомж болон Шинжлэх ухаа технологийн төсөл хэрэгжүүлэх журам, түүнд нийцүү гаргасан бусад дүрэм, журам, заавар, аргачил хүрээнд хийж гүйцэтгэнэ.

8.Энэхүү гэрээний эхийг ..... хувь үйлд гэрээлэгч талууд ба Үндэсний зөвлөлийн ажлын алба тус бүр нэг хувийг хадгалав.

| Захиалагчийг төлөөлж | Гүйцэтгэгчийг төлөөлж |
| --- | --- |
| ........................ /гарын үсэг/ | ........................ /гарын үсэг/ |
| ........................ /овог нэр / | ........................ /овог нэр/ |
| ........................ /албан тушаал/ | ........................ /албан тушаал/ |

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

Тайлбар: Гэрээний энэхүү үлгэрчилсэн загвар нийтлэг шинж чанартай учир тодорхой төслөөр гэ байгуулахдаа гэрээний бүтэц, агуулга, үг найруул ялангуяа гүйцэтгэх ажил, гарах үр дүнгийн онцлог уялдуулан талуудын үүрэг, эрх, хариуцлагын ху зохих хэмжээний өөрчлөлт тодруулалт хийх нь зүйтэ

...................................... нэртэй
шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэг-
жүүлэх 19..оны..дугаар сарын..ны өдрийн
..... тоот гэрээний 1 дүгээр хавсралт

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР
/Техникийн даалгавар/

| ...гээр бий болгох ...р дүнгийн нэр | Тоо хэмжээ | Үндсэн параметр | Захиалагчид хүлээлгэж өгөх хугацаа |
|---|---|---|---|
| | | | |

| ...алагчийг ...өлөөлж | Гүйцэтгэгчийг төлөөлж | Төслийн удирдагч |
|---|---|---|
| ............... ...арын үсэг/ | ...................... /гарын үсэг/ | .................... /гарын үсэг/ |
| ............... ...овог нэр/ | ...................... /овог нэр/ | .................... /овог нэр/ |
| ............... ...лбан тушаал/ | ...................... /албан тушаал/ | .................... /албан тушаал/ |

...ын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

........................................................ нэр
шинжлэх ухаан, технологийн төсөл хэр
жүүлэх 199 ..... оны .... дугаар сарын ...
өдрийн ... тоот гэрээний 2 дугаар хавсра

## ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Ажлын программ/

| Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлуудын нэр | Эхлэх, дуусах хугацаа /он, сар, өдөр/ | Гүйцэтгэгчийн овог, нэр, мэргэжил |
|---|---|---|
| | | |

| Захиалагчийг төлөөлж | Гүйцэтгэгчийг төлөөлж | Төслийн удирдагч |
|---|---|---|
| ................. /гарын үсэг/ | ................. /гарын үсэг/ | ........... /гарын үсэг/ |
| ................. /овог нэр/ | ................. /овог нэр/ | ........... /овог нэр/ |
| ................. /албан тушаал/ | ................. /албан тушаал/ | ........... /албан тушаал/ |

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

Шинжлэх ухаан, технологийн төсөл
хэрэгжүүлэх журмын 2 дугаар хавсралт

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭРЭЭ
/Үлгэрчилсэн загвар/

99__оны___дугаар Дугаар___ Улаанбаатар хот
арын ___ ны өдөр

ахиалагч............................................-ыг
(байгууллагын нэр)
өлөөлж..............................................
(албан тушаал, овог, нэр)
анхүүжүүлэгч......................................-ийг
/байгууллагын нэр/
өлөөлж..............................................
/албан тушаал, овог нэр/
цаашид "талууд" гэх/ Шинжлэх ухаан, технологийн
эл хэрэгжүүлэх журмыг үндэс болгон ..............
..........................................нэртэй шинжлэх
эн, технологийн төсөл /цаашид "төсөл" гэх / -ийг
хүүжүүлэх талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг
гуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

.Төслийг 19.. - 19 ..онд .. жилийн хугацаанд
хүүжүүлнэ.
.Төслийн санхүүжилтийн нийт зардалд төслийн
эонд хэрэгжүүлэх судалгаа, сорилт, туршилтын ажлын
эн хөренгө оруулалтын зардлаас гадна уг төслийг
эгжүүлэхтэй холбогдсон дотоод, гадаадын сургалт,
инар, хурал, уулзалт, үзэсгэлэн сурталчилгаа зэрэг
з хэмжээний зардлыг хамруулна.
.Төслийг хэрэгжүүлэх явцад түүний санхүүжилтийн
хээ, хугацаанд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага
эал талуудын хооронд нэмэгдэл гэрээ хэлцэл
гуулна.
.Төслийг "Шинжлэх ухаан, технологийн төсөл
эгжүүлэх журам"-ын 29 (29.1., 29.2 ., 29.3.)-д
ган нөхцөлөөр санхүүжүүлнэ.
.Төслийн зардлаар бий болсон үндсэн хөренгө
гаж, тоноглол, техник хэрэгсэл, компьютер гэх
)-ийг төсөл дууссанаас хойш .......................

..................................................................................
..................................................................................
............ ашиглана (ямар нөхцөлөөр хэнд эзэмшү
лэхийг тодорхой заана).

6.Төслийн гүйцэтгэгчтэй хамтран "Төслийн өртө
зардал тохиролцсон тухай протокол" үйлдэж гэрээ
хавсаргав.

## Хоёр. Талуудын үүрэг, эрх, хариуцлага

7.Үүрэг

1.Захиалагч дараах үүрэг хүлээнэ:

а/төслийн санхүүжилтийн хөрөнгийг гүйцэтгэ
хэрхэн ашиглаж байгаа байдалд хяналт тавьж илэрс
зөрчлийг санхүүжүүлэгчид мэдэгдэх, түүнийг арилг
арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

б/төслийн төсөвт өртгийн ..... хувьтай тэнц
....... төгрөгийг хэдийд, хэрхэн Шинжлэх ухаа
технологийн санд шилжүүлэх тухай заах;

в/төслийн хөрөнгийн ашиглалтын тала
санхүүжүүлэгчийн шаардсан мэдээ, материалыг о
тухайд нь гаргаж өгөх;

г/төслийн санхүүжүүлэлтийн сар, улирлын хуваар
санхүүжүүлэгчтэй хамтран тодорхойлох;

д/төслийн хэрэгжилтийн явцыг үндэслэн санхүүж
олгох (зогсоох) тухай албан ёсны саналыг хагас ж
тутам санхүүжүүлэгчид ирүүлж байх;

е/төслийн үр дүнг ашигласан эхний 2, 3 дахь ж
түүнээс олсон ашгийн .... хувийг Шинжлэх ухаа
технологийн санд шилжүүлэх.

2.Санхүүжүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

а/төслийн гэрээнд заасан төсөвт зардлыг бү
олгох;

б/гэрээнд заасан хуваарийн дагуу төслийг хугаца
нь санхүүжүүлж байх;

в/төслийг санхүүжүүлэхдээ түүний хүрээнд гүйцэт
судалгаа шинжилгээ, сорилт туршилтын ажилд зориул
шууд ба шууд бус зардал, хөрөнгө оруулалтаас гадна
төслийн чиглэлээр гадаад, дотоодод явуулах сурга
дадлагажуулалт, хурал, семинар, уулзалт хэлэлц
үзэсгэлэн сурталчилгаа зэрэг арга хэмжээний зард
цогцолбороор хамруулан тооцож байх;

г/төслийн хөрөнгө зарлын зарцуулалт, ашиглал
байдалд санхүүжүүлэгчийн зүгээс хяналт тавьж, гарс

ргдал, зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээ
;
/төслийн эцэст санхүүгийн өр авлагын тооцоог
их журмын дагуу бүрэн гүйцэд хийж барагдуулах;
/үр дүнгийн ашиглалтын байдлыг хяналсан төслийн
эгтэгч ба бүтээлийн зохиогчийг зохих журмын дагуу
үлэн дэмжих, урамшуулах;
/хуульд заасан бусад үүргийг тодруулж заах.

. Эрх.
.Захиалагч дараах эрх эдэлнэ:
/төслийн санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагааны
ар шаардлагатай мэдээ, тайланг тухай бүр гаргуулж
;
/төсөл хэрэгжүүлэх явцад түүний санхүүжилтийн
ээг нэмэгдүүлэх (хорогдуулах) зайлшгүй шаардлага
ал уг асуудлыг санхүүжүүлэгчтэй хамтран боловс-
ж Үндэсний зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх;
/төслийн хэрэгжилтийн явц захиалагчаас үл хамаа-
шалтгаанаар удаашрах, төлөвлөсөн ажил биелэхгүй
, үр дүн нь хэрэгцээ шаардлагыг хангахааргүй
втэй байгаа тохиолдолд төслийн санхүүжилтийг
оох, гэрээг цуцлах асуудлыг санхүүжүүлэгчид зохих
мн дагуу тавьж шийдвэрлүүлэх;
/гэрээнд заасан хэмжээ, хуваарийн дагуу төслийн
үүжилт хийгдэхгүй тохиолдолд гэрээний үүргээ
үүлэх талаар санхүүжүүлэгчид шаардлага тавьж
у авах.
Санхүүжүүлэгч дараах эрх эдэлнэ:
/төслийн гүйцэтгэл, үр дүн, түүний баталгаажуу-
, хөрөнгө зардлын зарцуулалт, ашиглалт зэрэг
длаар захиалагчаас мэдээ, тайлан гаргуулж авах,
эний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах
ар түүнд анхааруулах, шаардлага тавих, зохих дээд
ы байгууллагад мэдээлэх, асуудал боловсруулж
эрлүүлэх;
санхүүгийн мэдээ, тайланг хожимдуулах, санхүү-
үйл ажиллагааг буруу явуулах, хөрөнгө мөнгийг
улалтын бус зүйлд зарцуулах, санхүүжилтийн бус
гаанаар төслийн ажил удаашрах, төлөвлөсөн үр дүнд
эгүй тохиолдолд төслийн санхүүжилтийг түр
оох, улмаар шаардлагатай гэж үзвэл төслийг хаах
л тавих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
төслөөр гүйцэтгэх ажлын чиглэл, төслийн үр дүнг
ласнаас ашиг олох боломж зэргийг харгалзаж төсөл

болон түүний тодорхой үе шатны ажлуудыг грант олгс эргэж төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэх, зээл олı зэргийн аль тохиромжтой хэлбэрийг нь сонгож ялгаві тайгаар санхүүжүүлэх асуудлыг захиалагчтай тохироլ хэрэгжүүлэх;

г/төслийн үр дүнгийн борлуулалт, нэвтрүүлэлт олсон орлого, ашгаас санд зохих хэмжээний шимті авах замаар сангийн хөрөнгийг арвижуулах, өг сайтай үр дүнг урамшуулах;

д/холбогдох талуудтай нэмэлт гэрээ хэл байгуулж, харилцан тохиролцох замаар төслийн үр д борлуулах буюу борлуулахад зуучлах, үүний төl зохих хэмжээний хувь ногдол хүртэх;

е/патент эзэмшигчтэй лицензийн гэрээ байгу патентлагдсан үр дүнг ашиглах, эсвэл патент эзэм эрхийг захиалагчаас шилжүүлж авах;

ж/төслийн нийт төсөвт өртгийн 5-10 хувийг с үлдээж төслийг бүрэн дуусгаж үр дүнг захиалагч эрдэм шинжилгээний ажлын тайланг Итгэмж хадгалагчид хүлээлгэж өгсний дараа захиалагчийн са дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгчид олгох.

9. Хариуцлага

Үүргээ биелүүлээгүй талын хүлээх хариуцла талууд харилцан тохиролцох замаар энэхүү гэрэ тодорхой тусгана.

**Гурав. Бусад зүйл**

10.Төслийг санхүүжүүлэх, төслийн эцэст санхүүгі өр, авлагыг тооцох, үр дүнг үйлдвэрлэл, хэрэглэ шилжүүлэх, ашиглах, урамшуулах ажлыг холбогдох ху тогтоомж болон Шинжлэх ухаан, технологийн тө хэрэгжүүлэх журам, түүнд нийцүүлж гаргасан бу дүрэм, журам, заавар, аргачиллын хүрээнд х гүйцэтгэнэ.

11.Энэхүү гэрээний эхийг .... хуэь үйл гэрээлэгч талууд ба Үндэсний зөвлөлийн Ажлын алб тус бүр нэг хувийг хадгалав.

| | |
|---|---|
| Захиалагчийг төлөөлж | Санхүүжүүлэгчийг төлөөлж |
| ............... /гарын үсэг/ | ............... /гарын үсэг/ |
| ............... /овог нэр/ | ............... /овог нэр/ |
| ............... /албан тушаал/ | ............... /албан тушаал/ |

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

айлбар: Гэрээний энэхүү үлгэрчилсэн загвар нь глэг шинж чанартай учир тухайн төслөөр гэрээ гүулахдаа гэрээний бүтэц, агуулга, үг найруулга, ггуна гүйцэтгэх ажил, гарах үр дүнгийн онцлогтой дуулан талуудын үүрэг, эрх, хариуцлагын хувьд их хэмжээний өөрчлөлт тодруулалт хийх нь зүйтэй.

........................ нэртэй
шинжлэх ухаан, технологийн төсөл
санхүүжүүлэх тухай 19... оны ...
дугаар сарын ... ны өдрийн .....
тоот гэрээний хавсралт

## ТӨСЛИЙН ӨРТӨГ, ЗАРДАЛ ТОХИРОЛЦСОН ТУХАЙ ПРОТОКОЛ

өслийн өртөг, зардал, санхүүжилтийг дараахь сээ, хуваарь, нөхцөлтэйгээр харилцан тохиролцож гүү протоколыг 19 .. оны ... дугаар сарын ...ны үйлдэв. Үүнд:

.Төслийн нийт төсөвт өртөг..........мянган төгрөг
үнээс: -урсгал зардал...............мянган төгрөг
-хөрөнгийн зардал...........мянган төгрөг

.Төслийн нийт зардлын оны хуваарь /урьдчилсан лаар/

| | бүгд | урсгал | хөрөнгийн |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийн агдсан хэмжээ, жилийн төсөв, төлөвлөгөөтэй дуулан дээр дурдсан оны хуваарьт жил бүр өөрчлөлт, ртгол хийнэ.

.Тухайн жилийн төсвийг зохиохдоо оны хуваарьт сан зардлыг санхүүгийн холбогдох байгууллагаас асан хүснэгт загварын дагуу зардлын нэрээр лж, нарийвчлан тооцох ба төсвийн батлагдсан оог тухай бүр энэхүү протоколд хавсаргана.

.Төслийг санхүүжүүлэхдээ түүний хүрээнд гүйцэтгэх н чиглэл, явц байдал, гарах үр дүнгийн онцлог

зэргийг харгалзан ажлын тодорхой үе шату санхүүжилтийн хэлбэрийг ялгавартайгаар сонгон тогт болох ба энэ тохиолдолд талууд тухай бүр харил тохиролцож нэмэлт тэмдэглэл үйлдэж энэхүү проток хавсаргана.

6. Энэ протокол ба түүнд хийсэн албан ё тодотгол, тооцоо нь төслийн эцэст санхүүгийн авлагыг тооцоход баримтлах эрхийн үндэслэл болно.

| Санхүүжүүлэгчийг төлөөлж | Гүйцэтгэгчийг төлөөлж | Захиалагчий төлөөлж |
|---|---|---|
| .............. /гарын үсэг/ | .............. /гарын үсэг/ | .......... /гарын үсэг/ |
| .............. /овог нэр/ | .............. /овог нэр/ | .......... /овог нэр/ |
| .............. /албан тушаал/ | .............. /албан тушаал/ | .......... /албан тушаал |

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

Шинжлэх ухаан, технологийн тө
хэрэгжүүлэх журмын 3 дугаар хавср

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ХҮЛЭЭН АВСАН АКТ**

/Үлгэрчилсэн загвар/

19 .. оны .. дугаар сарын .... -ны өдөр    Дугаар ..    Улаанбаатар

Захиалагч.......................................
/байгууллагын нэр/

төлөөлж.......................................
/албан тушаал, овог нэр/

гүйцэтгэгч.......................................
/байгууллагын нэр/

төлөөлж.......................................
/албан тушаал, овог нэр/

ашид" талууд" гэх/ "Шинжлэх ухаан, технологийн эл хэрэгжүүлэх журмыг үндэс болгон 19 .. оны ... зар сарын...ны өдрийн .... тоот гэрээний дагуу ..-19...онд гүйцэтгэсэн ......................... гэй шинжлэх ухаан, технологийн төсөл /цаашид" эл" гэх /-ийн үр дүнг үнэлэн хүлээлцэж энэхүү иг үйлдэв.

Нэг. Үнэлж хүлээн авсан үр дүнгийн жагсаалт

| Төслөөр гаргасан цсийн үр дүнгийн нэр | Тоо хэмжээ | Үндсэн параметр | Өөрийн өртөг /мян.төг/ |
|---|---|---|---|
| | | | |

Хоёр. Үр дүнг шилжүүлэх, ашиглах

.Үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд дараахь хэлбэрээр үүлэхээр тохиролцов:
/.............................................
/.............................................
.Үр дүнг үйлдвэрлэгч, хэрэглэгч нар дараахь эрээр ашиглана:
/.............................................
/.............................................
.Үр дүнг шилжүүлэх, ашиглах үйл ажиллагааг цаашид жүүлэн явуулах ба энэ зорилгоор төслийг гэрээлэгч уд хамтран ажиллаж доор дурдсан ажлыг хийж этгэх болно:
/.............................................
/.............................................
Үр дүнг борлуулах тохиолдолд үнийг нь тохиролцон оох зарчим баримтлах ба ингэхдээ энэхүү актад сан өөрийн өртгийг албан ёсны жишиг болгоно.

Гурав. Бусад зүйл.

5.Төслийн санхүүгийн тооцоо хийж, өр, авла барагдуулах ба санд шимтгэл оруулах, үр д урамшуулах зэрэг асуудлыг санхүүжүүлэгч байгууль зохих журмын дагуу харицан зохион байгуулж, төсл гэрээлэгч талууд тухай бүр хамтран ажиллах болно.

6.Энэхүү актын эхийг .... хувь үйлдэж төсл захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч талууд Үндэсний зөвлөлийн ажлын албанд тус бүр нэг хув хадгалуулав.

| Захиалагчийг төлөөлж | Гүйцэтгэлийг төлөөлж |
|---|---|
| ...................... /гарын үсэг/ | ...................... /гарын үсэг/ |
| ...................... /овог нэр/ | ...................... /овог нэр/ |
| ...................... /албан тушаал/ | ...................... /албан тушаал/ |

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 2 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаат хот |

**Журам батлах тухай**

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн ал хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дуг зүйлийн 5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэс заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТ нь:

1."Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ыг 1 дуг хавсралтын, "Цэргийн албыг сайн дурын үндсэн д гэрээгээр хаах журам"-ыг 2 дугаар хавсралтын ө тус тус батлсугай.

2.Эдгээр журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажиллагааг энэ оны батлагдсан төсөв, цалингийн са

:аан зохион байгуулах арга хэмжээ авахыг Батлан
·аалахын сайд Д.Дорлигжав, аймаг, нийслэлийн Засаг
·а нарт даалгасугай.

онгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

атлан хамгаалахын сайд Д.ДОРЛИГЖАВ

Засгийн газрын 1998 оны 15 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

.Монгол Улсын иргэн Иргэний цэргийн үүргийн болон
нйн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн
;угаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу цэргийн
г дүйцүүлэн хаахад энэ журмыг дагаж мөрдөнө.
.Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар
нйн бэлтгэл үүрэгтэн иргэн энэ журамд заасан
зэрийн дагуу, өөрийн хүсэлтээр Иргэний хамгаа-
ын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэмцэх
ар, Хилийн цэрэгт туслах хүчин, хүмүүнлэг
амжийн газар, халамжийн төв, төлбөргүй буяны
лэг зэрэг/- ийн болон бусад байгууллага /цаашид
энний хамгаалалтын мэргэжлийн анги, Байгалийн
игтай тэмцэх салбар, Хилийн цэрэгт туслах хүчин,
үнлэгийн болон бусад байгууллага" гэнэ/-д цэргийн
г дүйцүүлэн хааж болно.
.Монгол Улсын иргэний цэргийн албыг дүйцүүлэн
хугацааг хуулиар зохицуулна.
.Цэргийн албыг дүйцүүлэн хаах Монгол Улсын
ний тооны дээд хязгаарыг батлан хамгаалах асуудал
лсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг
слэн Засгийн газраас жил бүрийн 1 дүгээр улиралд
аан аймаг, нийслэл бүрээр тогтооно. Аймаг,
элийн Засаг дарга тухайн жилд цэргийн албыг
үүлэн хаах иргэний тоог тогтоолгох саналаа
огдох судалгааны хамтаар жил бүрийн 1 дүгээр сард

баттаан батлан хамгаалах асуудал эрхэлсэн төр
захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.Иргэдээр цэргийн албыг дүйцүүлэн хаалгах а
хэмжээг тухайн сум, дүүргийн Засаг дарга ну
дэвсгэрийн зарчмаар зохион байгуулна.

6.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэ
сургууль, дадлага, дайчилгаа болон хил хамгаала
оролцсон аливаа үйл ажиллагаат оногдуулсан үүр
гүйцэтгэсэнд тооцно.

**Хоёр.Дүйцүүлэх албанд иргэнийг авах**

7.Монгол Улсын иргэнийг дараахь шалтгаан
цэргийн дүйцүүлэх албанд авч болно:

а/сум хийдэд шавилан суугаа;

б/шашин шүтлэг-ёс зүйн шалтгаанаар цэргийн жинх
албыг хаах боломжгүй болохыг сум, дүүргийн За
дарга тогтоон тодорхойлсон.

8.Цэргийн албыг дүйцүүлэн хаах тухай хүсэ
шалтгаанаа Монгол Улсын иргэн ээлжит цэрэг татлаг
хуанлийн 45 хоногийн өмнө харьяалагдах сум, хоро
Засаг даргаараа уламжлан аймаг, дүүргийн Засаг дар
гаргана.

9.Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хур
Тэргүүлэгчид иргэний хүсэлт, шалтгаан, сум, хоро
Засаг даргын тодорхойлолт, аймаг, дүүргийн За
даргын саналыг үндэслэн цэргийн дүйцүүлэх албанд а
иргэдийн тооны дээд хязгаарыг сум, дүүрэг бүр
хяналтын тоотой уялдуулан гаргаж Иргэдийн Төлөөлө
дийн Хурлаараа батлуулан тухайн сум, дүүргийн За
дарга болон цэрэг татлагын товчоонд хүргүүлнэ.

10.Сум, дүүргийн Засаг дарга цэргийн албыг д
цүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг тогто
хязгаарт багтаан батлуулж цэрэг татлагын товчо
хүргүүлэх бөгөөд уг товчоо нь тогтоосон хязга
нэрсийн жагсаалтыг чанд баримтлан цэргийн ал
дүйцүүлэн хаах иргэдийг авах, энэ талаар шийд
гаргах, хуваарилах ажлыг зохион байгуулах үү
хүлээнэ.

**Гурав.Цэргийн албыг дүйцүүлэн хаах**

11.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний хам
лалтын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэм
салбар, Хилийн хороо, Хүмүүнлэгийн болон бусад

'ууллагын удирдлага тухайн цэрэг татлагын товчооны ıвэр, хуваарийн дагуу цэргийн албыг дүйцүүлэн хаах эдийг хүлээн авч бүртгэн, уг албыг хаалгах ажлыг ıон байгуулна.

2.Цэргийн дүйцүүлэх албыг хааж байгаа иргэн нь йн шатны иргэний хамгаалалтын болон байнгын ·ой комиссын дарга, штаб, хилийн хорооны захирагч, 'үплэгийн болон бусад байгууллагын удирдлага, ıвэрийн дагуу дараахь үүрэг гүйцэтгэнэ:

/байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, осол хээрийн түймэр, усны үер, ган, зуд, хүчтэй цасан ıн шороон шуурга, газар хөдлөлт, дэлбэрэлт, цацраг ıxт болон хүчтэй үйлчилгээтэй хорт бодис алдах г/-ын аюулаас хүн ам, эд хөрөнгийг хамгаалах, ээртэй тэмцэх, хор уршгийг арилгах;

/гамшиг, осолд нэрвэгдэгсдийг аврах, хамгаалах;

/улсын хилийн бүс, зурвас улсын хилийн болон хил ын дэглэмийг сахиулах;

/хүмүүнлэгийн болон бусад байгууллагад туслах;

/байгалийн гамшиг, ослоос сэргийлэхтэй холбогдсон үейн чанартай ажил гүйцэтгэх.

·.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний дуулсан үүрэг, түүнийг гүйцэтгэх үеийн харилцааг ан хамгаалахын асуудал хариуцсан Засгийн газрын үний баталсан дүрмээр зохицуулна.

·.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн алтыг алба хаалгахаар бүртгэн авсан тухайн уулага хариуцан тэдгээрийг уг албанд авсан өс эхлэн зохион байгуулна. Энэ сургалтаар үүрэг этгэх анхан шатны мэдлэг, дадлага эзэмшүүлэх өд хугацаа нь ажлын 14 хоногоос багагүй байна. алтыг алба хаалгагч байгууллагууд хамтран,эсвэл илсэн хэлбэрээр явуулж болно.

.Хилийн цэрэгт туслах хүчинд цэргийн албыг үүлэн хааж байгаа иргэдийн сургалтыг тухайн йн хороо хариуцан зохион байгуулах бөгөөд хил залалтын үүрэг гүйцэтгэх үед нь захирагчийн эрийг уидэслэн хяналт, ажиглалт явуулах, холбоо жад шаардагдах багаж хэрэгслээр хангана.

.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн этгэх үүргийн мэдлэг, дадлагыг гүнзгийрүүлэх, рхой чиглэлээр цэргийн болон бусад мэдлэг олгох алтыг тухайн байгууллага жилд 2-оос доошгүй удаа бүр ажлын 14 хоногийн хугацаагаар явуулна.

.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн

сургалтын хөтөлбөрийг холбогдох төрийн захиргаа байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга батална. Уг хөтөлбөрт тухайн албыг дүйцүүлэн хаалгаж байгаа байгууллага өөрийн үйл ажиллагаа болон нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан өөрчлөлт оруулж болно.

18.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн тухайн сум, дүүргийн Засаг дарга, алба хаалгаж байгаа байгууллагаас дуудсан хугацаанд хувийн бэлтгэлтэй хүрэлцэн ирж, оногдуулсан үүргийг гүйцэтгэнэ. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний цугларалтын үеийн хувийн бэлтгэлийн нормативыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батлан мөрдүүлнэ.

19.Иргэний хамгаалалтын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэмцэх салбар, Хилийн хамгаалалт, Хүмүүнлэгийн болон бусад байгууллагад цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, дадлагын нь сурах бичиг, үзүүлэн таниулах материал, бусад гарын авлага, дадлагын болон дайчилгааны төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалтыг мэргэжлийн холбогдох байгууллага баталж, сум, дүүргийн, эсвэл хил хорооны захиалгаар хангалт хийнэ.

20.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн нь албыг хаах хугацаандаа 5-аас доошгүй сарын хугацаагаар дүйцүүлэх албаны оногдуулсан үүргийг биечлэн гүйцэтгэсэн байна. Дүйцүүлэх албаны сургалт, цугларалтын хугацаагаар үүрэг гүйцэтгэснээр тооцно.

21.Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

а/томилгоот үүргээ биелүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх;

б/албыг дүйцүүлэн хаах хугацаандаа өөрийн ажил амьдралаа албандаа эрх ашигт нийцүүлэн зохицуулж байх;

в/даалгасан үүргийг шударга, хариуцлагатай биелүүлэх;

г/цугларах дохио, дуудлага хүлээн авмагц заасан газар, тогтоосон хугацаанд хувийн бэлтгэлтэй хүрэлцэн ирж, оногдуулсан үүргийг гүйцэтгэх;

д/зөвхөн сум, дүүргийн Засаг даргаас, эсвэл хил хорооны штабаас олгосон зөвшөөрөл, чөлөөгөөр тухайн орон нутгаас 5- аас дээш хоногоор гадагш явах;

е/сум, хорооны Засаг дарга, алба хаалгагч байгууллага

н удирдлагын, эсвэл хилийн хорооны захирагчийн
ээрийг үг дуугүй биелүүлэх;
оногдуулсан үүрэгтэйгээ холбоотой зөрчил гарсан
холбогдох арга хэмжээг бие даан нэн яаралтай
он байгуулах.

### Дөрөв. Орон нутгийн байгууллагуудын гүйцэтгэх ажлын чиг үүрэг

.Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
үүлэгчид дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
сум, дүүргийн цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэ-
тооны дээд хязгаарыг тогтоох тухай саналаа
г, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд
лан батлуулах;
байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, ослоос
айлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр цэргийн
г дүйцүүлэн хааж байгаа иргэдийн цугларалт зохион
уулах тухай шийдвэр гаргах, Засаг даргад заалт
.
.Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
үүлэгчид дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
тухайн жилд цэргийн албыг дүйцүүлэн хаах
дийн жагсаалтыг хянан батлах;
хяналтын тоонд багтаагүй иргэнийг дараагийн онд
ийн албыг дүйцүүлэн хаалгахаар цэрэг татлагаас
лөөлөх тухай шийдвэр гаргах.
.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь чиг
айг хэрэгжүүлнэ:
тухайн жилийн цэргийн албыг дүйцүүлэн хаах
дийн талаар сум, дүүргээс ирүүлсэн саналыг хянаж,
ээ аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
ын Тэргүүлэгчдэд оруулах;
энэ журмын 22 дугаар зүйлийн "б"-д заасан
ээрийг хэрэгжүүлэх, эсвэл холбогдох хууль тог-
ийг биелүүлэх, дайчилгаа явуулах зорилгоор цэр-
албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн цугларалтыг
эрүүлэн зохион байгуулж, тодорхой үүрэг гүйцэт-
эх тухай шийдвэр гаргах;
Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн
йг хэрхэн төвлөрүүлэн ашиглах талаар төлөвлөж,
бүр тодотгож байх;
цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн
алт, цугларалт, дайчилгааны үед шаардлагатай

материал, техник хэрэгслийг үүрэг гүйцэтгүүлэх
татан оролцуулах;

д/иргэдийн цэргийн албыг дүйцүүлэн хааж бай
байдалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг
хэрэгжүүлэх.

25.Сум, дүүргийн Засаг дарга дараахь чиг үүрг
хэрэгжүүлнэ:

а/цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлт гарга
иргэний хүсэлт, үндэслэлийг нарийвчлан хян
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчидтэй
зөвшилцөж саналаа аймаг, нийслэлийн Засаг даргад
бүрийн 2 дугаар сард багтаан хүргүүлэх;

б/цэргийн албыг дүйцүүлэн хаах байгаа иргэд
сургалт, бэлтгэл, цугларалт, дайчилгаа, өдөр ту
үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

в/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэд
дайчилгааны үеийн аюулгүй байдлыг хангуулах а
хэмжээ авах;

г/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа ир
гамшиг, ослын хор уршгийг арилгах, иргэдийн амь н
эд хөрөнгийг хамгаалах болон бусад оногдуулсан үүр
үнэнчээр биелүүлж амжилт гаргавал тэдний шаг
урамшуулах, шагналд тодорхойлох;

д/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа ир
оногдуулсан үүргээ гүйцэтгэж байх үедээ тахир ду
болсон, амь насаа алдсан тохиолдолд хууль тогтоом
дагуу өөрт нь болон ар гэрт нь тэтгэвэр, тэт
олгох;

е/цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаандаа
дэтгэх бус шалтгаанаар сургалт, цугларалт, дайчил
тасалсан, сахилга хариуцлага алдсан, түүнчлэн
хэрэг үйлдсэн нь хууль тогтоомжийн дагуу тогтоог
иргэнийг уг албанаас хасах санал тавих, эсвэл хуу
байгууллагад шилжүүлэх;

ж/цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн зар
жил бүр орон нутгийн төсөвтөө тусган батлуулж бай

з/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа ирг
шаардлагатай тохиолдолд оногдуулсан үүргээ гүйцэ
үед нь ажлын хувцас, багаж хэрэгслээр хангах
хэмжээ авах;

и/цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаа дуу
иргэнийг уг албанаас халах тухай саналаа ай
дүүргийн цэрэг татлагын товчоонд гаргаж өгөх.

26.Цэрэг татлагын товчоо дараахь чиг үүр
хэрэгжүүлнэ:

/зохих шийдвэрийн дагуу цэргийн албыг дүйцүүлэн
: иргэдийг ээлжит цэрэг татлагын үед жагсаалтын
у бүртгэж, хуваарилах, алба хаах байгууллагад нь
элгэн өгөх;
/цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаа дуусссан
нийг уг албанаас халж, бичиг баримтад нь
эглэл хийж өгөх.
/.Цэрэг, иргэний хамгаалалтын штаб дараахь чиг
нийг хэрэгжүүлнэ:
/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдэд
эжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
/цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнд алба
 хуудас олгох ажлыг эрхлэн гүйцэтгэх;
/иргэдийн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа
ал, түүний зохион байгуулалт, үйл ажиллагаанд
лт тавьж, сум, дүүргийг мэргэжил, арга зүйн
длага, туслалцаагаар хангах;
/иргэд цэргийн албыг дүйцүүлэн хаахтай холбогдсон
гэл, тайлан, мэдээллийн асуудлыг эрхлэх.
.Иргэдийн цэргийн албыг дүйцүүлэн хаалгах ажил
уцсан байгууллага дараахь чиг үүргийг хэрэг-
нэ:
цэргийн албыг дүйцүүлэн хаахаар хуваарилагдан
н иргэдийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомж,
м, журам, заавар зэрэг дагаж мөрдвөл зохих эрх
 баримт бичгийг танилцуулах, тэдний сургалт,
аралт, дайчилгааг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу
он байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэх;
сахилга хариуцлага алдсан болон бусад шалтгаа-
 цэргийн албыг дүйцүүлэн хаах боломжгүй болсон
нийг уг албанаас хасах тухай саналаа сум,
гийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;
цэргийн албыг дүйцүүлэн хаасан иргэнийг уг
наас халах тухай санал, тодорхойлолтоо сум,
гийн Засаг даргад гарган өгч шийдвэрлүүлэх;
цэргийн албыг дүйцүүлэн хаасан иргэдэд энэ тухай
мт бичгээ бүрдүүлэн халагдахад нь дэмжлэг
алцаа үзүүлэх.
.Аж ахуйн нэгж, байгууллага дараахь чиг үүргийг
гжүүлнэ:
цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэнийг
алах сум, дүүргийн Засаг даргад уламжлах;
цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнийг
сан хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлж сургалт,
аралт, дайчилгаанд оролцох, оногдуулсан үүргээ

гүйцэтгэх нөхцөл, боломжоор хангах.

### Тав. Бусад зүйл

30.Зарлан дуудсан хугацаанд хүндэтгэн ү шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй, сургу цугларалт, дайчилгаанаас зайлсхийсэн болон энэ жур зөрчсөн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэн уг албанаас хасч, холбогдох хууль тогтоомжийн да шийтгэл ногдуулна.

31.Цэргийн албыг дүйцүүлэн хаахаас хасагдсан ир цэргийн жинхэнэ алба хаах үүргээс чөлөөлөгдөхгүй.

32.Цэргийн албыг дүйцүүлэн хаалгахаар иргэн авах, уг албыг хаах, түүнээс хасах, халах холбогдсон асуудлаар гарсан маргааныг аймаг, дүүрг Цэрэг, иргэний хамгаалалтын штаб шийдвэрлэнэ. Цэр иргэний хамгаалалтын штабын шийдвэрийг эс зөвшөөр тухайн иргэн гомдлоо дээд шатны байгууллага ( шүүхэд гаргаж болно.

Засгийн газрын 1998 оны 15 дуг
тогтоолын 2 дугаар хавсралт

### ЦЭРГИЙН АЛБЫГ САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР ГЭРЭЭГЭЭР ХААХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын иргэн Иргэний цэргийн үүргийн бо цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуу 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цэр албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаахад журмыг цагаж мөрдөнө.

2.Цэргийн хугацаат албаны хугацаа нь дуусч ба байлдагч, түрүүч болон цэргийн нэгдүгээр зэр бэлтгэл үүрэгтэн цэргийн жинхэнэ албан х зөвшөөрөгдсөн мэргэжлээр сайн дурын үндсэн цэргийн албыг гэрээгээр хааж болно.

3.Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгууллаг цэргийн албыг гэрээгээр хааж байгаа иргэн /ца "гэрээт цэргийн албан хаагч" гэнэ/-д "Цэргийн олгох журам"-ын дагуу цэргийн цолыг олгоно.

### Хоёр.Иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон авах

Гэрээт цэргийн албан хаагчийн алба хаах албан ал, мэргэжил, тооны дээд хязгаарыг санхүүгийн батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн ргааны төв байгууллага жил бүрийн эхэнд тогтооно.
Цэргийн жинхэнэ албыг 8 сараас доошгүй хугаар хааж байгаа байлдагч, түрүүч, нэгдүгээр ийн цэргийн бэлтгэл үүрэгтэн 25 хүртэлх насны л Улсын иргэнийг гэрээт цэргийн албан хаагчаар ш шалгаруулж авна.
Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй Монгол Улсын аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэрэг, иргэний алалтын штаб, цэргийн ангийн удирдлагад өргөдлөө на.
Гэрээт цэргийн албан хаагчаар иргэнийг сонгон руулах журам, хугацааг Зэвсэгт хүчний ерөнхий Хилийн цэргийг удирдах газар тогтоож, ллийн хэрэгслээр зарлан мэдээлнэ.
Цэрэг, иргэний хамгаалалтын штаб, цэргийн ангийн лага сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гчдын цэргийн болон тусгай мэргэжил, эрүүл мэнд, биилдрын хөгжил, боловсролын түвшинг тогтоох гоор батлагдсан журмын дагуу үзлэг, шалгалт ж, дүнг Зэвсэгт хүчний ерөнхий штаб, Хилийн ийг удирдах газарт хүргүүлэх бөгөөд тэдгээр нь лтын дүн, цэргийн жинхэнэ алба хаасан байдал ийг үндэслэн иргэнийг гэрээт цэргийн алба хаалгах асуудлаар шийдвэр гаргана.

### Гурав.Гэрээ байгуулах

Энэ журмын 8 дугаар зүйлд заасны дагуу гэрээт ийн алба хаалгахаар шийдвэр гарсан иргэнтэй гт хүчний ерөнхий штаб, Хилийн цэргийг удирдах н эрх бүхий албан тушаалтан хяналтын тоонд ан "Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-г улна.
Иргэнтэй байгуулсан "Гэрээт цэргийн алба хаах гэрээ"-нд дараахь асуудлыг тусгана:
а/гэрээгээр цэргийн албыг хаах хугацаа;
б/гэрээний хугацаанд ажиллах анги, байгууллага, х албан тушаал;
в/цалин хөлс, нэмэгдлийн хэмжээ;

г/гэрээ байгуулагч Талуудын хүлээх үүрэг, эрх
д/гэрээ зөрчигдөхөд Талуудын хүлээх хариуцлаг
е/гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа.

11.Гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 2 байна.Гэрээг мөн хугацаагаар байлдагч, түрүүч цэргийн алба хаах насны дээд хязгаар хүртэл сун болно.

12."Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-г 2 х үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгална.

### Дөрөв.Гэрээт цэргийн албыг хаах

13.Гэрээт цэргийн албан хаагч нь хугацаат алб байлдагч, түрүүч нарын нэгэн адил цэргийн анг байнгын байрлалд байрлана.

14.Гэрээт цэргийн албан хаагч нь албан тушаа үүрэг, анги, байгууллагын өдөр тутмын цагийн хуваа дотоод дэг журам, цэргийн нийтлэг дүрмүүдийг ажиллагаандаа мөрдлөг болгоно.

### Тав.Гэрээт цэргийн албан хаагчийг томилох,шилжүүлэх

15.Талуудын хооронд байгуулсан "Гэрээт цэрг алба хаах тухай гэрээ"-г үндэслэн тухайн а байгууллагын захирагчийн тушаалаар иргэнийг байлда түрүүчийн албан тушаалд томилно.

16.Гэрээт цэргийн албан хаагчийг зөвхөн орон зохион байгуулалтын өөрчлөлт, ажил, мэргэж шаардлага, ар гэрийн гачигдлыг харгалзан гэр өөрчлөлт оруулсны үндсэн дээр анхлан шийдвэр гарг байгууллагын шийдвэрээр өөр анги, байгуулл шилжүүлэн томилж болно.

### Зургаа.Гэрээт цэргийн албан хаагчийн цалин, бусад хангамж

17.Гэрээт цэргийн албан хаагчийн мөнгөн орлог үндсэн цалин, цол, мэргэжлийн зэргийн болон б нэмэгдлээс бүрдэнэ.

18.Гэрээт цэргийн албан хаагчийн мөнгөн орлогы хүртэл хувийг сар тутам бэлнээр олгож болох бө үлдэх хэсгийг гэрээний хугацаа дууссаны дараа олг

19.Гэрээт цэргийн албан хаагчийн албан туша үндсэн цалинг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн

ıргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн
ı батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн
ıргааны төв байгууллага тогтооно.
).Эрх бүхий байгууллагын баталсан цэргийн
эжлийн зэрэг, шагнал олгох журмыг үндэслэн гэрээт
ийн албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл,
алыг олгоно.
1.Гэрээт цэргийн албан хаагчийн алба хаасан
цаагг иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн
цаанд оруулан тооцно.

### Долоо.Гэрээт цэргийн албан хаагчийн амралт, чөлөө

?.Гэрээт цэргийн албан хаагчид цэргийн анги,
ууллагаас тогтоосон журмын дагуу түр чөлөө олгох
ед ээлжийн амралтыг холбогдох хууль тогтоомжийн
у биеэр эдлүүлнэ.
ı.Гэрээт цэргийн албан хаагчийн ээлжийн
лтаараа орон нутагтаа ирж, очиход шаардагдах
н зардлыг түүний алба хааж байгаа анги,
уууллагаас автомашин, галт тэрэгээр зорчих тухайн
н тарифаар тооцон 2 жилд нэг удаа олгоно.
ı.Гэрээт цэргийн албан хаагчид анги, байгууллагын
рагч нарын тушаалаар ар гэрийн гачигдлын учир
үртэл хоногийн цалинтай, 14 хүртэл хоногийн
нгүй чөлөөг жилд нэг удаа ажлын өдрөөр тооцон
ж болно.
·.Өвчний болон эмчлүүлэх чөлөөг цэргийн их эмч
н комиссын магадалгаа, дүгнэлтийг үндэслэн анги,
ууллагын захирагч нар олгох бөгөөд эмчлүүлэх,
луулах нийт хугацаа нь дөрвөн долоо хоногоос
гүй байна.

### Найм.Гэрээ цуцлах, цэргийн жинхэнэ албанаас халах

.Гэрээт цэргийн албан хаагчтай байгуулсан гэрээг
эхь тохиолдолд цуцална:
байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд
зарт хүрсэн;
гэрээний хугацаа дуусч, халагдах өргөдлөө
ısан;
дөрвөн долоо хоногоос дээш хугацаагаар эмчлүүлэх
ıлагатай болсон;

г/ар гэрийн гачигдлын улмаас гэрээгээ цуцлах хүсэлтээ гаргасан;

д/шүүхээр ял шийтгүүлсэн;

е/хүндэтгэх шалтгаангүйгээр анги, байраа ор явсан;

ж/олгосон амралт, чөлөөний хугацааг хүндэт шалтгаангүйгээр хэтрүүлсэн;

з/мэргэжил, ур чадвар, сахилга хариуцлагын ху ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон, гэрээг хүлээсэн үүргээ биелүүлээгүй, цэргийн дүрмийн бо сахилгын зөрчил удаа дараа гаргасныг нь тухайн ан байгууллагын захирагч нар тодорхойлон гэрээгээ цуц санал тавьсан;

и/орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт мэргэжлийн дагуу өөр анги, байгууллагад шил ажиллах боломжгүйгээ тухайн албан хаагч бичг мэдэгдсэн.

27.Энэ журмын 26 дугаар зүйлийн "д-з"-д заа шалтгаанаар гэрээгээ цуцалж байгаа гэрээт цэрг албан хаагч гэрээнд заасны дагуу материалын зард төлөх үүрэгтэй.

28.Гэрээт цэргийн албан хаагчтай байгуулсан гэр энэ журмын 26 дугаар зүйлд заасны дагуу цуцалбал албан хаагчийг хууль тогтоомжийн дагуу цэрг жинхэнэ албанаас бэлтгэлээр хална.

29.Гэрээт цэргийн албан хаагч гэрээнд заа хугацаанаас өмнө өөрийн хүсэлтээр халагд материалын зардлаа гэрээний дагуу төлсний дараа ха асуудлыг шийдвэрлэнэ.

30.Халагдаж байгаа гэрээт цэргийн албан хааг байгуулсан гэрээгээ дүгнэн холбогдох тооцоог хийс дараа нийгмийн даатгалын дэвтэр, бусад баримт бичг олгоно.

## Ес.Бусад асуудал

31.Албан үүргээ үлгэр жишээчээр гүйцэтгэж бай гэрээт цэргийн албан хаагч ахлагчийн болон офицер албанд шилжин ажиллах хүсэлт гаргавал түүнд зо шатны сургуулийн элсэлтийн уралдаант шалгалтад ор мэргэжил дээшлүүлэхэд нь анги, байгууллагын удирдл дэмжлэг үзүүлнэ.

32.Гэрээний хугацаа дуусч байгаа гэрээт цэр албан хаагч цаашид сурч, боловсрох хүсэлтээ гарга бэлтгэлийг нь хангуулах үүднээс тухайн ан байгууллагаас их, дээд сургууль, коллежийн элсэлти

алтын голлох хичээлүүдээр төрөлжүүлсэн сургалт он байгуулж болно.
3.Гэрээт цэргийн албан хаагчдын дунд явуулах ийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг Зэвсэгт ий ерөнхий штаб, Хилийн цэргийг удирдах газар ан гаргаж мөрдүүлнэ.
.Гэрээт цэргийн албан хаагч болон түүний алба байгаа анги, байгууллагын хооронд гарсан ааныг Зэвсэгт хүчний ерөнхий штаб, Хилийн цэргийг дах газар шийдвэрлэнэ. Зэвсэгт хүчний ерөнхий , Хилийн цэргийг удирдах газрын шийдвэрийг эс өөрвөл Талууд гомдлоо шүүхэд гаргаж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

98 оны 2 дугаар рын 18-ны өдөр Дугаар 18 . Улаанбаатар хот

### Тогтоолуудын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

нгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор агдсан "Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах тбөр"-ийн "Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд" ı "Гурав"-ын 2 дугаар жагсаалтаас 1 дүгээр алтад нэр заасан аж ахуйн нэгжүүдийг, Засгийн ын 1997 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан ийн мэдлийн хувьцааг худалдах компанийн алт"-аас 2 дугаар хавсралтад нэр заасан аж ахуйн үдийг тус тус хассугай.
Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор агдсан "Хувьчлах жижиг аж ахуйн нэгжүүд" гэсэн "-ын 1 дүгээр жагсаалтад 3 дугаар хавсралтад нэр ан аж ахуйн нэгжүүдийг нэмж оруулсугай.

**нгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**нгийн сайд** **П.ЦАГААН**

Засгийн газрын 1998 оны 18 дуга
тогтоолын 1 дүгээр хавсралт

**Гурав.Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд**
**(2 дугаар жагсаалт)**

А.Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

| д/д | Аймаг, нийслэлийн нэр | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Төрийн өмчийн эзлэх хувь | Ажи дм то |
|---|---|---|---|---|---|
| 12 | Булган | Сэлэнгэ | Ингэттолгой ХК | 20 | 523 |
| 14 | Говь-алтай | Есөнбулаг | Баянтоорой ХК | 31 | 106 |
| 22 | Дархан-уул | Дархан-уул | Торгон үр ХК | 51 | 169 |
| 23 | Дархан-уул | Дархан-уул | Ужимхангай ХК | 20 | 140 |
| 28 | Дорнод | Хэрлэн | Халх буудай ХК | 51 | 121 |
| 29 | Дорнод | Чойбалсан | Баян талбай ХК | 51 | 109 |
| 45 | Сүхбаатар | Түмэнцогт | Түмэнцогт ХК | 51 | 325 |
| 47 | Сэлэнгэ | Баруун-бүрэн | Бүрэн Бургалтай ХК | 34,2 | 349 |
| 48 | Сэлэнгэ | Ерөө | Хандгайт гол ХХК | 51 | 62 |
| 49 | Сэлэнгэ | Зүүнбүрэн | Зүүнбүрэн ХК | 51 | 87 |
| 50 | Сэлэнгэ | Зүүнбүрэн | Их бүрэн ХК | 29 | 118 |
| 53 | Сэлэнгэ | Орхон | Орхондалай ХК | 30 | 278 |
| 54 | Сэлэнгэ | Орхонтуул | Сэлэнгэ сүрэг ХК | 40 | 130 |
| 55 | Сэлэнгэ | Орхонтуул | Орхонбулаг ХК | 40 | 176 |
| 56 | Сэлэнгэ | Орхонтуул | Цуу тайж ХК | 33 | 145 |
| 58 | Сэлэнгэ | Түшиг | Зэлтэр ХК | 7 | 220 |
| 59 | Сэлэнгэ | Цагааннуур | Сэлэнгэ найрамдал ХК | 25 | 150 |
| 60 | Сэлэнгэ | Цагааннуур | Баянцулаан-уул ХК | 25 | 169 |
| 61 | Сэлэнгэ | Цагааннуур | Товхон хан ХК | 25 | 176 |
| 62 | Төв | Жаргалант | Жаргалант ХК | 59 | 412 |
| 64 | Төв | Заамар | Заамар ХК | 9,6 | 111 |
| 68 | Төв | Цээл | Залуучууд ХК | 20 | 600 |
| 69 | Төв | Эрдэнэсант | Хоргохайрхан ХК | 20,1 | 144 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төв | Эрдэнэсант | Буянт төв ХК | 16 | 301 |
| Увс | Баруун-туруун | Усжуулах ХК | 51 | 95 |
| Хөвсгөл | Тариалан | Алтандуулга ХК | 70,7 | 179 |
| Хөвсгөл | Тариалан | Ар тархи ХК | 65,7 | 62 |
| Хэнтий | Хэрлэн | Тахилгат ХК | 51 | 237 |

Засгийн газрын 1998 оны 18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**Төрийн мэдлийн хувьцааг худалдах компанийн жагсаалт**

| Аймаг, нийслэлийн нэр | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Төрийн өмчийн эзлэх хувь | Ажилчдын тоо |
|---|---|---|---|---|
| Төв | Нөхөрлөл ХК | Хөдөө аж ахуй | 51 | 211 |
| Төв | Атар ХК | Хөдөө аж ахуй | 33 | 96 |
| Төв | Заргал ХК | Хөдөө аж ахуй | 32,2 | 123 |
| Төв | Баянтолгой ХК | Хөдөө аж ахуй | 31 | 20 |
| Хэнтий | Өндөрхаан ХК | Хөдөө аж ахуй | 31 | 112 |
| Төв | Зөөн шанд ХК | Хөдөө аж ахуй | 28 | 65 |
| Төв | Шунхлай ХК | Хөдөө аж ахуй | 20 | 80 |

Засгийн газрын 1998 оны 18 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

**Хоёр.Хувьчлах жижиг аж ахуйн нэгжүүд**
(1 дүгээр хавсралт)

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

| Аймаг, нийслэлийн нэр | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Төрийн өмчийн эзлэх хувь | Ажилчдын тоо |
|---|---|---|---|---|
| Сэлэнгэ | Сэлэнгэ | Ингэттолгой ХК | 20 | 523 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 165 | Говь-алтай | Есөнбулаг | Баянтоорой ХК | 31 | 10 |
| 166 | Дархан-уул | Дархан-уул | Торгон үр ХК | 51 | 16 |
| 167 | Дархан-уул | Дархан-уул | Уужимхангай ХК | 20 | 14 |
| 168 | Дорнод | Хэрлэн | Халх буудай ХК | 51 | 12 |
| 169 | Дорнод | Чойбалсан | Баян талбай ХК | 51 | 10 |
| 170 | Сүхбаатар | Түмэнцогт | Түмэнцогт ХК | 51 | 32 |
| 171 | Сэлэнгэ | Баруун-бүрэн | Зүүн хөвч ХК | 51 | 32 |
| 172 | Сэлэнгэ | Баруун-бүрэн | Бүрэн бур-галтай ХХК | 30 | 84 |
| 173 | Сэлэнгэ | Баруун-бүрэн | Бүрэн бумбат ХХК | 30 | 70 |
| 174 | Сэлэнгэ | Баруун-бүрэн | Бүрэн шивээт ХХК | 30 | 41 |
| 175 | Сэлэнгэ | Ерөө | Хандгайт гол ХХК | 51 | 62 |
| 176 | Сэлэнгэ | Зүүнбүрэн | Зүүнбүрэн ХК | 51 | 87 |
| 177 | Сэлэнгэ | Зүүнбүрэн | Их бүрэн ХК | 29 | 11 |
| 178 | Сэлэнгэ | Орхон | Орхондалай ХК | 30 | 27 |
| 179 | Сэлэнгэ | Орхонтуул | Сэлэнгэ сүрэг ХК | 40 | 13 |
| 180 | Сэлэнгэ | Орхонтуул | Орхонбулаг ХК | 40 | 17 |
| 181 | Сэлэнгэ | Орхонтуул | Цуу тайж ХК | 33 | 14 |
| 182 | Сэлэнгэ | Түшиг | Зэлтэр ХК | 7 | 22 |
| 183 | Сэлэнгэ | Цагааннуур | Сэлэнгэ найрамдал ХК | 25 | 15 |
| 184 | Сэлэнгэ | Цагааннуур | Баяндулаан-уул ХК | 25 | 16 |
| 185 | Сэлэнгэ | Цагааннуур | Товхон хан ХК | 25 | 17 |
| 186 | Төв | Жаргалант | Жаргалант ХК | 59 | 41 |
| 187 | Төв | Заамар | Заамар ХК | 9,6 | 11 |
| 188 | Төв | Цээл | Залуучууд ХК | 20 | 60 |
| 189 | Төв | Эрдэнэсант | Хоргохайрхан ХК | 20,1 | 14 |
| 190 | Төв | Эрдэнэсант | Буянт төв ХК | 16 | 30 |
| 191 | Төв | Аргалант | Нөхөрлөл ХК | 51 | 21 |
| 192 | Төв | Баянхангай | Атар ХК | 33 | 96 |
| 193 | Төв | Жаргалант | Зардал ХК | 32,2 | 12 |
| 194 | Төв | Батсүмбэр | Баянтолгой ХК | 31 | 20 |
| 195 | Төв | Архуст | Ноён шанд ХК | 28 | 65 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| эв | Архуст | Шунхлай ХК | 20 | 80 |
| эс | Баруун-туруу | Усжуулах ХК | 51 | 95 |
| эвсгэл | Тариалан | Алтандуулга ХК | 70,7 | 179 |
| эвсгэл | Тариалан | Ар тархи ХК | 65,7 | 62 |
| энтий | Хэрлэн | Тахилгат ХК | 51 | 237 |
| энтий | Хэрлэн | Өндөрхаан ХК | 31 | 112 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

3 оны 2 дугаар                                    Улаанбаатар
ын 18-ны өдөр     Дугаар 19                       хот

**Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

гол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
онгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр, лпросцветмет" нэгдлийн Зөвлөлийн Монголын хэс- үрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.
ардлагатай үед ажил төрлийн холбогдолтой аар яам, газруудын ажилтнуудыг Зөвлөлийн ын хэсгийн ажилд татан оролцуулж байхыг Монгол- хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр, "Монголрос- т" нэгдлийн Зөвлөлийн Монголын хэсгийн дарга анд зөвшөөрсүгэй.
э тогтоол гарсантай холбогдуулан "Монгол- хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр, "Монголрос- т" нэгдлийн Зөвлөлийн Монголын хэсгийн эхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны аар сарын 29-ний өдрийн 268 дугаар тогтоолыг үй болсонд тооцсугай.

**гол Улсын Ерөнхий сайд**                    **М.ЭНХСАЙХАН**

**гийн сайд**                                  **П.ЦАГААН**

Засгийн газрын 1998 оны 1
дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН "ЭРДЭНЭТ" ҮЙЛДВЭР, "МОНГОЛРОСЦВЕТМЕТ" НЭГДЛИЙН ЗӨВЛӨЛИЙН МОНГОЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн Монголын хэсгийн дарга — Сангийн сайд П.ЦАГААН

Гишүүд:

- Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн агентлаг дарга Д.ЗОРИГТ;
- Засгийн газрын ахлах референт Ш.СОЛОНГО;
- Хөдөө аж ахуй, үйлдвэрий яамны Стратегийн төлөвло нэгдсэн бодлогын газрын орлогч дарга Л.ДҮГЭРЖАВ;
- Сангийн яамны Бүтцийн өөрчлөлт, өмчийн хэлтси дарга Д.БАЯСГАЛАН;
- Гадаад харилцааны яамны ОХУ-ын асуудал хариуцса мэргэжилтэн Ө.БАТ-ЭРДЭН
- Үндэсний татварын ерөнх газрын хяналт шалгалтын улсын байцаагч Ч.ГАНСҮХ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 2 дугаар сарын 18-ны өдөр — Дугаар 21 — Улаанбаа хот

**Журам батлах тухай**

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаа тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжү зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлы

оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 02 дугаар тогтоо-
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаат-
тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн биелэл-
зохион байгуулах журам"-ыг хавсралтын ёсоор
ісугай.
Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга
эанд шаардагдах 11 /арван нэг/ сая төгрөгийг
ийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Сангийн сайд
ааанд зөвшөөрсүгэй.
"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаат-
тэдэнд нөхөх олговор олгох тухай" Монгол Улсын
ійг хэрэгжүүлэх ажлыг Монголын Улс төрийн хэлмэг-
ийн холбоотой хамтран шуурхай зохион байгуулж
ахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалга-
і.

**нгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН**

**нгийн сайд П.ЦАГААН**

Засгийн газрын 1998 оны 21
дүгээр тогтоолын хавсралт

**УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах
і гомдол гаргаж, нөхөх олговор гаргуулах тухай
ажлэхтэй холбогдсон баримт бичгийг бүрдүүлэх,
олговор олгох ажлыг зохион байгуулахад энэхүү
г баримтална.

**Хоёр.Улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэж үзэж байгаа этгээдийг цагаатгуулах тухай гомдол гаргах**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч, тэдгээрийн
бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч болон
эрийн эрх ашгийг хамгаалах байгууллага "Улс
н хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, нөхөх

олговор олгох тухай хууль"-ийн 6 дугаар зү
заасанаар гомдол гаргахын тулд улс төрийн хилс хэ
холбогдсон гэж үзэж байгаа этгээдийг Монгол У
Засаг төрийн эрх бүхий байгууллагаас цагаатга
хэлмэгдсэнд тооцсон эсэхийг Улсын аюулгүй бай
хангах газрын архивын албанаас аймаг, х
Цагаатгалын салбар комиссоороо дамжуулан урьдч
лавлаж мэдсэн байвал зохино.

3.Улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэж үзэж
этгээдийн хэргийг шалгаж цагаатгаагүй байвал тэ
этгээдийг Шүүх, Тусгай комисс, Онцгой бүрэн
комиссоос ял шийтгэсэн, эсвэл улс төрийн хилс хэ
холбогдуулан баривчилж мөрдсөний аль нь болохыг У
аюулгүй байдлыг хангах газрын архивын алба энэ жу
2-т заасан этгээдэд мэдэгдэнэ. Уул мэдэгдлийг хү
авсан хүн түүнийг үндэслэн "Улс төрийн хилс хэ
хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор о
тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу холбо
байгууллагад гомдлоо гаргана.

### Гурав.Нөхөх олговрыг нэхэмжлэхэд бүрдүүлэх баримт бичиг

4."Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч
цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуу
10.1-т заасан этгээд нөхөх олговор гаргуулах т
нэхэмжлэлд дараахь баримт бичгийг хавсаргасан ба
зохино. Үүнд:

а/мөн хуулийн 8.1, 8.2-т заасан эрх б
байгууллагын шийдвэрийн тухайн хүнд холбогдох хэс
хуулбар /Улсын аюулгүй байдлыг хангах газрын арх
албанаас олгоно/;

б/мөн хуулийн 8.3 заалтад холбогдох шийдвэ
хуулбар /шийдвэр гаргасан байгууллага олгоно/;

в/улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэж
байгаа этгээдийг цагаатгасан, эсвэл хэлмэгд
тооцсон тухай мэдэгдсэн лавлагаа /Улсын аюу
байдлыг хангах газрын архивын албанаас олгоно/;

г/мөн хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4-т за
этгээд мөн болохыг магадлах үндэслэл болох "Ам бү
тодорхойлолт" /Үндэсний архивын газраас олгоно/;

д/нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн гэ
тогтоосон анхан шатны шүүхийн шийдвэр буюу нота
таар гэрчлүүлсэн "Өв залгамжлах эрхийн гэрчилгээ"

### Дөрөв. Нөхөх олговор олгох

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч болон ...эрийн хууль ёсны өв залгамжлагчид нөхөх олговрыг ... төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, ...д нөхөх олговор олгох тухай" хуулийн 16.3-т ...ы дагуу доор дурдсан дараалныг баримтлан олгоно:

...хэлмэгдэгч өөрөө;
...хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/;
...төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд;
...эцэг, эх, ах, эгч, дүү;
...ач, зээ.

...төн хуулийн 14.1.2-т заасны дагуу улс төрийн ... хэрэгт ял шийтгүүлээд цагаатгагдсан хүмүүст ...лыг нь нөхөн төлсөн бол энэ тухай бүртгэлийг ...йн яам Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.
...төн хуулийн 14.1.1-д заасны дагуу хохирлыг нөхөн ...н баримтыг хэлмэгдэгч өөрөө, эсвэл түүний хууль ...өв залгамжлагч нь Цагаатгах ажлыг удирдан зохион ...улах Улсын комисст хүргүүлнэ.
...рьд хохирлыг нь нөхөн төлсөн хэмжээг ханшны ...өлтөөр тооцох итгэлцүүр нь 140 байна.
...нэ журмын "Гурав"-т заасан баримт бичгийг ...үлсэн этгээд энэ тухайгаа аймаг, нийслэлийн ...тгалын салбар комисст бүртгүүлнэ. Цагаатгах ... удирдан зохион байгуулах Улсын комисс нөхөх ...ор гаргуулахаар нэхэмжлэл гаргах гэж буй ...ийн нэрийг "Засгийн газрын мэдээ" сонинд сар ...рлана.
Нөхөх олговор олгох хуваарийг тухайн жилийн ...рсон төсөвт батлагдсан хөрөнгийн хэмжээ, энэхүү ...д заасан дараалныг харгалзан Сангийн яам, ...гах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс ...ан гаргана. Үг дараалнын дагуу нөхөх олговор ... явцад тухайн жилд батлагдсан хөрөнгө ...улагдаж дуусвал дараа онд үргэлжлүүлэн олгоно.

### Тав. Бусад зүйл

Нөхөх олговор нэхэмжлэхэд шаардлагатай баримт ...ыг үрэгдүүлбэл энэ тухайгаа аймаг, хотын ...гтгалын салбар комисст мэдэгдэж, үрэгдсэн ...ыг хүчингүйд тооцох тухай зарлалыг "Засгийн

газрын мэдээ" сонинд нийтлүүлнэ.Уг баримтыг олгосон байгууллагад хандаж дахин олгох тухай өргө гаргаж хуулбарыг авна. Өргөдөлдөө сонины зарл хавсаргана. Дахин олгосон баримт нь энэ т тэмдэглэсэн дардастай байвал зохино.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 2 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаат хот |

Тогтоолын хавсралтад нэмт оруулах тухай

"Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэ үйлдвэрийн үйл ажиллагааны тухай БНМАУ, ЗСБН /хуучин нэрээр/ Засгийн газар хоорондын 1991 Хэлэлцээр"-ийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол У Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1998 оны 19 дүгээр тогто батлагдсан Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлд "Монголросцветмет" нэгдлийн зөвлөлийн Монголын гийн бүрэлдэхүүнд Сангийн яамны ажилтан Б.Да чулууныг нэмж оруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХА

Сангийн сайд П.ЦАГААН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

оны 11 дүгээр | | Улаанбаатар
---|---|---
10-ны өдөр | №427 | хот

### ДЭЭД ШҮҮХИЙН 1993 ОНЫ 49-Р ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

тварын хууль тогтоомжийн зарим актын зүйл, хэсэг, заалтыг ярлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 1993 оны 49-р лын (цаашид "тогтоол" гэх) зарим заалтыг сүүлийн үед дсан Татварын хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтөд үлэх зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

49-р тогтоолын нэг дэх хэсгийн 3 дугаар заалтыг дор анаар өөрчилсүгэй.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан р ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан" г "Татвар ногдох орлого, татвар ногдох зүйлийн тоо хэмжээг н бодох данс, бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ, ий орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны д алдах, хуурамч буюу алдаатай тооцоог үндэслэх, тооцооны бусад техник хэрэгслийг буруу ашиглах, мэдлэг чадвар ах, хайхрамжгүй хандах буюу зориудын бус бусад хэлбэрээр лсныг ойлгоно.

Тогтоолын хоёр дахь хэсгийн 10 дугаар заалтын дараа дор ан агуулгатай 11,12,13,14 дүгээр заалт нэмж, 11, 12, 13, ээр заалтыг 15,16,17,18 дугаар заалт болгосугай.

Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд заасан "Албан татвар их хэмжээний орлого, эд хөрөнгө буюу ажил гүйцэтгэсэн, гээ үзүүлсэн нуух" гэсний "нуух" гэдэг нь үйлдэл, эс үйгээр илрэх бөгөөд татвар ногдох их хэмжээний орлого, эд ө буюу гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс орлогоо данс, бүртгэл, татварын мэдээ, тайлан тэнцэл, ий орлого татвар тодорхойлох хуудсанд тусгахгүй байх, ас зайлсхийх зорилгоор шилжүүлэх, данс, тооцооны болон аргаар далдлах, татварын тооцоо хийхэд шаардлагатай баримт г гаргаж өгөхгүй байх, устгаж үгүй болгох, тэдгээрийг чаар үйлдэх, зохих зөвшөөрөлгүйгээр бусдын нэр, хаяг, бичиг, түүний дотор аж ахуйн нэгжийн гэрчилгээ болон рлийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг ойлгоно.

"Мөн зүйл, хэсгийн тоо хэмжээг зориуд бууруулан эх" гэдэгт нягтлан бодох данс, бүртгэл, тайлан тэнцэл,

татварын тайлан, мэдээ, иргэний орлого, татвар тодорх
хуудсанд татвар ногдох орлого, эд хөрөнгө, гүйцэтгэсэн
үзүүлсэн үйлчилгээнийхээ тоо хэмжээг санаатайгаар буур
тусгаж татварын албанд мэдээлсэн эсвэл мэдээлэхээр за
үйлдлийг ойлгоно.

14. "Мөн зүйл, хэсгийн" . . . албан татвар төлөхгүй оргон за
гэдэгт татвар ногдох орлого, эд хөрөнгө буюу гүйцэтгэсэн
үзүүлсэн үйлчилгээ зэрэг татвар ногдох зүйлдээ татвар төлө
тулд улсын татвар төлөгчийн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, б
байгууллага болон татварын албанд мэдэгдэлгүйгээр нэр, о
байгаа газраа өөрчлөх, ийнхүү өөрчилсөн тухайгаа мэдэгдэхгүй
хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байх зэрэг үйлдлийг хэ

15. "Мөн зүйл, хэсгийн өөр бусад хэлбэрээр" гэдэгт т
төлбөл зохих мөнгийг өөр зориулалтаар ашиглах, татварын ал
үл маргах журмаар татварын төлбөрийг гаргуулах, эд хөрөнгө,
хөлс, бусад орлогоос татвар төлүүлэх, татвар төлөх хугацаа то
өгөх, эд хөрөнгөнд үзлэг хийх, битүүмжлэх, тооллого хийх,
зураг авах зэрэг хууль ёсны ажиллагаанд элдэв хэлбэрээр
учруулах замаар албан татвар төлөхгүй байх, татварын өр төлб
барагдуулахаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбо
хуульд заасан арга хэмжээг хууль бусаар тасалдуулах, са
зэргийг хамааруулна."

3. Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд заасан гэмт х
үйлдсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар дан
болон битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан,
шилжүүлсэн буюу хураагдвал зохих эд хөрөнгийг нуусан завше
түүний үйлдлийг Эрүүгийн хуулийн 210 дугаар зүйлтэй
зүйлчилж байсугай.

4. Монгол Улсын Дээд шүүхийн 1994 оны 12 дугаар
31-ний өдрийн 206 дугаар тогтоолд "Монгол Улсын Дээд шү
1993 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49 дүгээр тогт
"11 дүгээр зүйлд . . . "гэснийг "Монгол Улсын Дээд шү
1993 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49 дүгээр тогтоолын
16 дугаар зүйлд . . . " гэж өөрчилсүгэй.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** **Д. ДЭМБЭРЭЛЦЭР**
**ШҮҮГЧ** **Д. ДАНЗАНДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

ны 11 дүгээр 19-ний өдөр №442 Улаанбаатар хот

## ИРГЭНИЙ ХУУЛИЙН ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙН ХЭСГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

эний хуулийн өмчийн эрх зүйн хэсгийн зарим зүйл, хэсэг, нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

эний хуулийн (цаашид хууль гэх) Өмчийн эрх зүйн хэсгийн зүйл, хэсэг, заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

Хуулийн 76-р зүйлд заасан "эд хөрөнгийн эрх" гэдгийг эд ийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой болон засгийн эргэлтэд оролцогчдын хооронд эд хөрөнгийг лах, солилцох шаардлагатай холбоотой үүсдэг эрх зүйн ланд оролцогчдын субъектив эрх гэж ойлгоно.

уулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "үл хөдлөх хөрөнгөд түүнээс салган хэрэглэж үл болох зүйл хамаарна" гэдгийн т иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын болон төрийн эрх байгууллагын ашиглал, эзэмшил, өмчлөлд байгаа эдэлбэр газрын хэвлийн хэсэг, эдэлбэр ус, "түүнээс салган хэрэглэж үл зүйл" гэдэгт ой, олон наст ургамал, байшин, бусад барилга амж, байнга ашиглах зориулалттай газрын хөрсөнд суулгаж хашаа, хороо зэрэг газраас салгамагц зориулалтынх нь дагуу ж үл болох, зориулалтад нь дуйцээгүй хохирол хүйгээр шилжүүлэн байршуулж болдоггүй эд зүйлийг улна. Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхой эд ийг үл хөдлөх хөрөнгөд тооцож болно.

Хуулийн 88 дугаар зүйлийн "өмчлөгч биш этгээд" гэдэгт өөрийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах шилжүүлсэн тохиолдолд эд хөрөнгө, оюуны үнэт зүйл, эрхийг ооос өгсөн зориулалт, өөрийн үйл ажиллагааны зорилгод эн хууль, гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд эзэмших, , захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлж байгаа иргэн, этгээдийг хэлнэ.

Хуулийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Эд хөрөнгийг хэсгээр өмчлөгчдийн аль нэг нь өөрт оногдох хэсгээ худалдах, эх тохиолдолд энэ тухай бусдадаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд нь уг хэсгийг тэргүүн ээлжинд худалдан авах буюу түрээслэн

авах эрхтэй" гэдгийн "бусдалаа мэдэгдэх" гэдгийг оногдох х
худалдах буюу түрээсэлж байгаа этгээд энэ тухайгаа эд хөрө
дундаа хэсгээр өмчлөгч бусад бүх этгээдэд мэдэгдэх гэж ойл
Энэ үүрэг зөвхөн эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх иргэд
зэрэгт хамаарах бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай ком
нөхөрлөл хоршоо зэрэг аж ахуйн нэгжид хамаарахгүй.

5. Хуулийн 91-р зүйлийн 2 дахь хэсгийн ". . . бусад өмчлөгч
худалдан авагч авагч, түрээслэгчийн эрх, үүргийг өөрт шилжүүл
шаардаж, зургаан сарын дотор шүүхэд хэнэмжлэл гаргаж б
гэдгийг хуульд өөрөөр заагаагүй бол эрх зөрчигдсөн өдөр
ийнхүү зөрчигдснийг мэдэх ёстой байсан өдрөөс хойш зургаан с
дотор багтаан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж ойлгоно.

6. Хуулийн 95-р зүйлийн 4 дэх хэсгийн "Гэр бүлийн гишү
үүргээ гэр бүлийн эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгээр хари
гэдгийг гэр бүлийн гишүүн нь гэрээний болон гэрээний бус үү
үүссэн төлбөрийг өөрийн хуваарьт болон гэр бүлийн дундаа ха
өмчлөх эд хөрөнгийн өөрт оногдох хэсгээр хариуцна гэж о
бөгөөд оногдох эд хөрөнгийг нь Иргэний хуулийн 98 дугаар
заасан журмын дагуу тодорхойлно.

7. Хуулийн 96-р зүйлийн 3 дахь хэсгийн "гэрлэгчдийн
хувийн үйл ажиллагаатайгаа холбогдсон үүрэг" гэдэг гэрлэгсдий
нэг нь гэр бүлийн бусад гишүүдэд холбогдолгүй зөвхөн өөрийн
тусын төлөө явуулсан үйл ажиллагаатай холбогдсон х
гэрлэхийн өмнө үүссэн үүргийг хамааруулан ойлгох бөгөөд гэрл
өөрөөр тохиролцоогүй бол хуваарьт эд хөрөнгөөрөө хариуцна.

8. Хуулийн 97-р зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын
гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хөдөлмөр, аж ахуй
ажиллагаанаас бий болсон эд хөрөнгө, мөнгөн хуримтлал"
гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүдийн цалин, хөдөлмөрийн
түүнтэй адилтгах орлогоор бий болж, гэр бүлийн гишүүдийн д
хамтран өмчид хуримтлагдсан хэсгийг хамааруулна.
хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь Монгол Улсы
амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн
хэсэгт заасантай адилаар тодорхойлогдоно.

9. Хуулийн 99 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн ". . . гэр бүл
ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах эд хөрөнгө"
"гэр бүлийн аж ахуй" гэж гэр бүлийн бүх гишүүд хамтран э
байгаа, гэдний нийтлэг хэрэгцээг хангахад зориулагдсан бүх то
үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ түүнчлэн хуулийн
байгуулахгүйгээр гэр бүлийн гишүүд хамтран эрхэлж буй аж ах
. . . аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах эд хө
гэдэгт дээр дурьдсан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн яву
байнга хэрэглэгддэг машин техник, тоног төхөөрөмж, ажлын

эл, ажлын болон үржлийн мал зэрэг, үндсэн болон мөнгөн өноос бусад эргэлтийн хөрөнгө хамааруулна.
ууллийн 125 дугаар зүйлийн 3 дахь хэсгийнх "бүртгэн авч, мэдээлсэн" гэдгийг эзэнгүй буюу эзэн нь мэдэгдэхгүй байгаа өнгийг захиргааны байгууллага бүртгэн авч, орон нутгийн товийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу нийтэд этэй бусад аргаар мэдээлсэн байхыг гэж ойлгоно. Хуулийн зүйлийн 3 дахь заалтын "нийтэд мэдээлэх нь арга хэлбэрийн уулийн 125 дугаар зүйлийн 3 дахь хэсгийнхтэй адил байна.

ЭНХИЙ ШҮҮГЧ Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ҮГЧ А. ДОРЖГОТОВ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

ны 12 дугаар 12-ны өдөр №473 Улаанбаатар хот

### ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ТАЛААРХ ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

хор учруулснаас үүсэх үүргийн талаарх иргэний хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгон зөв хэрэглэх явдлыг хангах ор Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн уулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:
хор учруулснаас үүсэх үүргийн талаархи Монгол Улсын й хуулийн 48 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг дор наар тайлбарласугай.
Иргэний хуулийн (цаашид "хуулийн" гэх) 327 дугаар зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь хэлэлцэн тохиролцсон хэлцлийг ямар нэг байдлаар зөрчсөнтэй холбоогүйгээр үүсэх гэм хор учруулагчийн хууль зөрчсөн үйлдэл (эс үйлдэхүй), үүсэх гэм хор (хохирол), тэдгээрийн хоорондын шалтгаант гэм хор учруулсан этгээдийн гэм буруу тогтоогдсон үед Гэвч хуульд шууд заасан зарим тохиолдолд тухайлбал, орчин доо аюул учруулж болох зүйлээс хохирол учирсан бол гч гэм буруугүй байсан ч хариуцлага хүлээлгэнэ.

2. Хуулийн 377 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "эрх үүрг ёсоор бусдад гэм хор учруулсан этгээд"-д хууль тогтоомжид за бусдын эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хү хөрөнгөнд эрхэлж байгаа ажил, албан тушаал, мэргэжлийн халдах эрхтэй бөгөөд үүний улмаас гэм хор учруулж боло малын эмнэлэг, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүй алба, зэвсэгт хүчний зэрэг байгууллагын эрх бүхий а хамаарна.

3. Хуулийн 377 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "гар байдлын улмаас бусдад гэм хор учруулсан" гэдэгт өөрийн бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд заналхийлсэн аюулыг тухайн нөхцөл байдалд өөр арга, хэрэгслээр зай боломжгүй байсан гэм хор учруулсныг ойлгоно.

4. Энэ зүйл хэсгийн "учирч болох байсан хохирлын хэ аюул учруулсан хүчин зүйлийн үйлчлэл уг аюулын шинж чан хэмжээ, түүний улмаас учирч болох байсан бөгөөд зайлуулса хорын хэмжээ, өөрөөр хэлбэл хохирогчийн амь бие, эрүүл мэ хөрөнгөнд учрах байсан хор уршиг зэргийг харгалзан тодорхой

5. Хуулийн 378 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хөдөлм гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх" гэдэгт тухайн этгээд (аж хуулийн этгээд, иргэнтэй тохиролцон байгуулсан хөдөлм гэрээнд заасан ажил үүргийг буюу тухайн хуулийн этгээд, и шийдвэрээр өөр ажил үүргийг гүйцэтгэж байсныг хамааруулна.

6. Хуулийн 378 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "төр захи байгууллага, түүний албан тушаалтан"-д Төрийн албаны хуулийн 6,7,8,9 дүгээр зүйлүүдэд заасан төрийн улс т захиргааны тусгай, үйлчилгээний байгууллага, тэдгээрийн тушаалтнууд хамаарна.

7. Энэ зүйл, хэсгийн "буруу шийдвэр гаргасан буюу өөр-б албаны үйл ажиллагааг буруу явуулсан" гэдэгт Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад акт, Монгол Улсын олон гэрээгээр Монгол Улсын иргэнд олгосон эрхээ бүрэн боломжийг хууль бусаар хязгаарласан буюу алдагдуулсан, т иргэнд ямар нэг үүрэг хууль бусаар оногдуулснаас гэм хор уч төр, захиргааны байгууллага, түүний албан тушаалтны хууль шийдвэр, албаны үйл ажиллагаа явуулсныг ойлгоно.

8. Хуулийн 378 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хэрэг б мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын албан ту албаны үйл ажиллагааг буруу явуулсан" гэдэгт хууль бус шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, цагдан хорих сэргийлэх арга хэмжээ авсан, захиргааны шийтгэл оногду хамааруулан ойлгоно.

Энэ зүйл хэсгийн "хуульд заасан үндэслэл, журмын дагуу на" гэдэг гэмт хэрэг гараагүй болон бүрэлдэхүүнгүй эсхүл гэмт үйлдсэн ба захиргааны зөрчил гаргасан нь нотлогдоогүйгээс г хэрэгсэхгүй болгож, тухайн иргэний цагаатган, учирсан эд ийн хохирлыг нөхөн төлүүлэх, түрүүчийн ажил (албан )-д нь эргүүлэн тогтоох, ажилласан хугацааг тооцох, тэтгэвэр жийг нөхөн олгох, орон сууц эзэмших эрхийг сэргээх, цол ыг эргүүлж олгох, хууль зөрчсөн ажиллагааны тухай олон мэдээлэх, үрэгдүүлсэн баримт бичгийг бүрдүүлж өгөх зэргээр тусгайлан заасан хэлбэрээр хохирлыг арилгахыг хамааруулна.

Хуулийн 379 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "орчин тойрондоо чруулж болох зүйл" гэдэгт төрөл бүрийн авто, механикжсан йн хэрэгсэл, шатахуун түгээх газар, өндөр хүчдэлийн ын шугам, тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх болон түргэн ай, идэмхий буюу хорт бодис, орсон буур, зуудаг нохой зэрэг тойрондоо аюул учруулж болох бөгөөд хүний бүрэн хяналтад ломжгүй объект, амьтныг хамааруулж байвал зохино.

Энэ зүйл, хэсгийн "эзэмшигч"-д уул зүйлийг хууль буюу заасны дагуу байнга буюу түр хугацаагаар өөрийн эзэмших үндсэн дээр ашиглаж байгаа хуулийн этгээд, иргэнийг улна. Харин орчин тойрондоо аюул учруулж болох зүйлийг эзэмшлээс хууль бусаар авсан этгээд уг зүйлээс учирсан ыг хариуцан арилгана.

Хуулийн 379 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "гэнэтийн буюу штгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэдэгт тухайн байдалд даван гарах боломжгүй гал түймэр, үер, газар , ган, зуд зэрэг байгалийн гамшгийн шинжтэй үзэгдэл, тахал, ны ажиллагаа, хорио цээр зэрэг нийгмийн амьдралд гарсан байдлыг ойлгоно.

Хуулийн 380 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бараа, эсэн ажил үйлчилгээний үр дүн нь үйлдвэрлэл, зохион , жор найрлагын болон бусад дутагдалтай байсан" гэдгийг бараа, гүйцэтгэсэн ажил үйлчилгээний үр дүн болох эхүүн эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, эрүүл ахуйн хор зэргийг зөрчсөн байна гэж ойлгоно.

Хуулийн 384 дүгээр зүйлийн "эрхийн бүрэн чадамжтай иргэн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу түүнийг зөв чадваргүй байхдаа" гэдгийг бусдад хүчээр дарлагдсан буюу доромжлогдсон, эсхүл түүний хууль бус бусад үйлдлээс болж хүчтэй цочрон давчдаж, түүнчлэн ямар нэгэн өвчин, үйл улмаас сэтгэхүйн хүчтэй цочролд орж өөрийн үйлдэлд өгч, ач холбогдлыг ойлгохгүй буюу түүнийг удирдаж байдалд хүрснийг ойлгоно.

15. Хуулийн 385 дугаар зүйлийн "хамтран гэм хор учруулсан гэдгийг хоёр буюу түүнээс дээш тооны хүмүүс санаатай болгоомжгүйгээр хамтын үйлдлээр гэм хор учруулсныг ой Хамтран гэм хор учруулсны улмаас учирсан хохирлыг төлүүлэхдээ Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 6 дахь заасны дагуу бүх үүрэг хүлээгчдийг эсхүл тэдний аль нэгийг хариуц татан оролцуулж гэм хорыг нөхөн арилгуулж байвал зохино.

16. Хуулийн 387 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хөдөлм чадвараа алдсанаас дутуу авсан цалин, хөлс, түүнтэй адилтгах о гэдэгт гэм хор учирсны улмаас хохирогч ажлаас чөлөөлөгдсөн цалинтай ажилд шилжсэн, тахир дутуугийн группэд орсон з болж одоогийн авч байгаа цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж н эрүүл байхдаа авч байсан цалин, олж байсан орлогоос буурсан ойлгоно.

17. Хуулийн 387 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн " тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ" г Хөдөлмөрийн хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх, хэсэгт за Засгийн газраас тогтоосон тухайн үед дагаж мөрдөж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ойлгоно.

18. Хуулийн 389 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хохир асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд"-д Нийгмийн даа сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зү 1 дэх хэсэгт заасан:

1/ Хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахг төрүүлсэн буюу үрчлэн авсан 16 нас (сургуульд суралцаж бай 19 нас) хүрээгүй хүүхэд (үүнд эцгээ нас барснаас хойш мэн хүүхэд нь хамаарна);

2/ Хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 16 нас хүрээгүй ач, зээ, дүү;

3/ тэжээгчийн асрамжинд байсан төрөлхийн тахир дуту нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төр эгч, дүү;

4/ Эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;

5/ Найман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, эх буюу эхнэрийн аль нэг (нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгү хүмүүсийг хамааруулж ойлгоно.

19. Хуулийн 393 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бусад байгу гэдэгт тухайн хохирогчид учирсан гэм хорын хохирлыг ур төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийнхаас бусад а

байгууллага, түүний дотор буяны болон халамжийн ллагуудыг хамааруулна.

ЭНХИЙ ШҮҮГЧ Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ІХИМЫН ТЭРГҮҮН ҮГЧ Р. ЖАМЪЯАНЧОЙЖИЛ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

ны 12 дугаар 29-ний өдөр №524 Улаанбаатар хот

## ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

гол Улсын Дээд шүүхийн Бүгд хурлын 1989 оны 51 дүгээр лын зарим заалтыг Дээд шүүхийн бусад тогтоолтой нийцүүлэх ор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрүүгийн хуулийн 292, 293 дугаар зүйлийг шүүхийн практикт х тухай" Дээд шүүхийн Бүгд хурлын 1989 оны 12-р сарын 21-рийн 51 дүгээр тогтоолын зарим заалтыг доор дурьдсанаар сугэй.

угаар заалтын: "Эрүүгийн хуулийн 292 дугаар зүйлийн 1 дэх заасан бага бус гэм хор гэдэг ойлголтод . . . 2000-10000 хүртэл йн хохирол . . . ыг хамааруулж ойлгоно" гэснийг "Эрүүгийн 292 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бага бус гэм хор ілголтод . . . 50000-1500000 төгрөгийн хохирлыг ойлгоно" гэж; оолын 5 дугаар заалтын 2 дахь хэсгийн "Эрүүгийн хуулийн гаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнд хор уршиг гэдэг од . . . 10000-аас дээш төгрөгийн их хэмжээний эд лын хохирол учрахыг . . . хамааруулж ойлгоно" гэснийг йн хуулийн 292 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнд хор эдэг . . . 1500000 төгрөгөөс дээш хэмжээний эд материалын г ойлгоно" гэж;

гаар заалтын: "Эрүүгийн хуулийн 293 дугаар зүйлийн 1 дэх заасан бага бус гэм хор гэдэг ойлголтод . . . Цэргийн лагад учруулсан 5000-10000 хүртэлх хэмжээний төгрөгийн

хохирол, . . . ыг хамааруулна" гэснийг "Эрүүгийн хуулийн 293 д
зүйлийн 1 дэх
хэсэгт заасан бага бус гэм хор гэдэгт . . . 550000-3000000 х
хэмжээний төгрөгийн хохирол . . . ыг хамааруулна" гэж;

"Эрүүгийн хуулийн 293 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан
хор уршиг гэдэг ойлголтод . . . 10000 төгрөгөөс дээш их хэмж
хохирол учруулсныг хамааруулна" гэснийг " . . . 3000000 төг
дээш хэмжээний хохирлыг хамааруулна гэж;

2. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 193 д
зүйлийн 1 дэх хэсэгт заасан бага бус гэм хор, мөн зүйлүүдийн
хэсэгт заасан хүнд хор уршигийн материалын хохирлын хэм
энэ тогтоолын 1 дүгээр заалтын 1, 2 дахь хэсэгт дурьдсан
хэмжээг, Эрүүгийн хуулийн 194 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт
бага бус гэм хор, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүн
уршигийн материалын хохирлын хэмжээнд энэ тогтоолын 1 д
заалтын 3, 4 дэх хэсэгт дурьдсан зохих хэмжээг түс
хамааруулахаар тогтоосугай.

3. Дээр дурьдсан 1989 оны 51-р тогтоолд "БНМАУ-ын
шүүхийн Бүгд хурлын тогтоол" гэдгийг Монгол Улсын Дээд шү
тогтоол, "БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 292, 293 дугаар
гэдгийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 292, 293 дугаар зү
тогтоолын 2 дугаар заалтад "БНМАУ-ын . . . "гэдгийг Монгол У
. . . 10 дугаар заалтад " . . . Ялын төлөвлөгөө" гэснийг . . .
дүгнэлт гэж тус тус өөрчилсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д. ДЭМБЭРЭЛЦЭР

ШҮҮГЧ М. ДАМИРАНСҮРЭ

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

| | |
|---|---|
| Ерөнхий эрхлэгч | **Л. Цог** |
| Хариуцлагатай нарийн бичгийн дарга | **Б. Ганбат** |
| Гишүүд | **С.Баяр**<br>**Б. Бадамханд**<br>**Ч. Дашням**<br>**Б. Цэндоо**<br>**Б. Энэбиш** |
| Техник редактор | **С. Итгэлт** |
| Уншиж хянасан | **Сан. Жаргалсайхан**<br>**Б. Янжинлхам** |

Зах №23
Үйлдвэрт шилжүүлсэн 1998 оны 3-р сарын 9-нд. Өрөлтөд 1998 оны 3-р сарын 10-нд. Хэвлэлтэд 1998 оны 3-р сарын 25-нд. Хэвлэлийн хуудас 8.0. Хэвлэсэн тоо 4097 ш

**Манай хаяг:** Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

**Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг**
**Эрхлэх Газрын харьяа**
**Хэвлэх үйлдвэр**